

НЬЮ-ЙОРК ТАЙМСЫН
БЕСТСЕЛЛЕР ЗОХИОЛЧ

ЛИЗА
БИНВЭР

ГЭХЭЙГҮХ

ДЕВОШН НОМ

Хүчтэй бөгөөд
галтай амьдрал

Найз минь,

Чамайг хүчтэй болгож, итгэлээр гүнээ өсгөж, чамд Бурхантай ч, бусадтай ч, өөртэйгээ ч эвтэй амьдрахын сайн сайхныг эдлүүлэх нь миний чин хүсэл. Чи Бурханы Үгийг уншиж, ярьж, амьдрах замаар итгэлээр өсөх явцдаа л хүчийг олно!

Хүч нь дуудлага ч, тушаал ч мөн боловч, хүчээ хаанаас олох нь хүчээ үзүүлэн болгохоос дутуугүй чухал. Манай соёлд хүн дотроосоо хүчийг олдог хэмээн сургадаг ч, үнэндээ Бурхан л бидний өөртөө итгэх итгэл, хүчний Эх болой. Тэр л бидний ирээдүйг атгаму.

Христ дотор учраас чи хүчирхэг. Чамд хүч, хайр, эрүүл саруул ухаан, Өөрийн Үнэн Үг, ямар ч эргэлзээгүйгээр зөвт байдлыг мөшгих хүчийг өгсөн.

Босоод, амьдралд чинь зориулсан Бурханы хүчийг өөрийн болго!

Христийн доторх:



Лиза эгчээс нь
LisaBevere@ymail.com




MessengerX



Messenger
INTERNATIONAL

ХҮЧИРХЭГ

ДЕВОШН НОМ

*Хүчтэй бөгөөд
Галтай амьдрал*

ЛИЗА БИВЭР

Strong Devotions, (Mongolian), by Lisa Bevere

© 2024 Messenger International

MessengerInternational.org

Originally published in English as *Strong Devotions* by Thomas Nelson, Nashville, USA.

ISBN 978-4002-1313-9

This version of the *Strong Devotions* published in cooperation with Thomas Nelson,
a registered trade mark of HarperCollins Christian Publishing Inc.

Additional resources in Mongolian are available for
free download and video streaming at

MessengerX.com and on the **MessengerX** app

To contact the author: LisaBevere@ymail.com

This book is a gift from Messenger International and is
NOT FOR SALE

Printed in Mongolia

Хүчирхэг Девошин ном, (Монгол), Лиза Бивэр

© 2024 Messenger International

MessengerInternational.org

Англи номын нэр: *Strong Devotions* by Thomas Nelson, Nashville, USA.

ISBN 978-4002-1313-9

This version of the *Strong Devotions* published in cooperation with Thomas Nelson,
a registered trade mark of HarperCollins Christian Publishing Inc.

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа дараах цахим хуудас апп-аас авна уу:

MessengerX.com болон **MessengerX** app

Зохиолчтой холбогдох имэйл: LisaBevere@ymail.com

Энэхүү номыг Мессенжер Интернэйшнэл байгууллагаас Монголчуудад өгч буй бэлэг юм.
ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

Монгол улсад хэвлэв.



App Store бол Apple ХХК-ийн АНУ болон олон улсад бүртгэлтэй худалдааны тэмдэг.

Google Play болон Google Play лого нь Google ХХК-ийн худалдааны тэмдэг.

АГУУЛГА

ХЭСЭГ 1 – Бурхан дотор хүчирхэг

1	Хүчирхэг байх нь хэвийн зүйл	2
2	Христийн дотор өөртөө итгэлтэй	4
3	Ганцаараа биш	6
4	Бурхан чамайг сонсдог	8
5	Бидний жинхэнэ хүсэл	10
6	Хангалуун	12
7	Хайран дотор чимээгүй байх	14
8	Айх аюулгүй, хамгаалагдсан	16
9	Чимээгүй.	18

ХЭСЭГ 2 – Сүнс дотор хүчирхэг

1	Дууны хүч	22
2	Өөртөө итгэлтэй бөгөөд чадвартай	24
3	Эрүүл зүрх	26
4	Бүсгүй хүний мөн чанараа хайрлахуй	28
5	Тайван бөгөөд хүчирхэг	30
6	Хүсэл тэмүүлэл	32
7	Хүндэтгэл нь магтан дуулахын нэр биш	34
8	Сүнсний эрх мэдэл	36
9	Сүнсний дагуу залбир	38

ХЭСЭГ 3 – Цэвэр байдал дотор жүчирхэг

1 Цэвэр.	42
2 Зориулагдсан	44
3 Үзэмж	46
4 Урнаар шаглагдсан	48
5 Сэтгэлийн холбоо	50
6 Харууслыг эдгээхүй	52
7 Гэрлэлтийг хүндэтгэхүй	54
8 Хамгаалагдсан	56
9 Сүйт бүсгүй	58

ХЭСЭГ 4 – Цэнхэр дотор жүчирхэг

1 Цэцэн үгтэй	62
2 Нэг л цул сэтгэл	64
3 Хана	66
4 Эргүүлж тойруулж	68
5 Харууслын нутгаа орхих	70
6 Хайрлуулсан	72
7 Хоёрдугаар зэргийнх биш	74
8 Бүх хайраа	76
9 Гэрэлд алхах	78

ХЭСЭГ 5 – Наринцаандаа жүчирхэг

1 Хэзээ ч гологдохгүй	82
2 Зөрчил дундах амар тайван	84
3 Татагдах, чиглүүлэгдэх	86
4 Аюулгүй бөгөөд хамгаалагдсан	88
5 Зөв нөхөрлөл	90

6	Шударга Бурхан	92
7	Хов живээс хамгаалагдсан	94
8	Эвтэй амьдрах	96
9	Бурханлаг хамт олон дунд өсөх	98

ХЭСЭГ 6 – Тулаанд жүчирхэг

1	Сэрэмжтэй бөгөөд анхааралтай байх	102
2	Хүйс хоорондын энх тайван	104
3	Үл уучлалын тулаан	106
4	Чиний хорогдох газар.	108
5	Бид тулалдаж байна	110
6	Бамбай ба сум	112
7	Жинхэнэ дайн	114
8	Гэрэл дотор тулалдах	116
9	Шийдэмгий	118

ХЭСЭГ 7 – Нигүүлслээр жүчирхэг

1	Өнгөрсөн нь чиний ирээдүй биш	122
2	Уучлагдсан	124
3	Нигүүлсэнгүй	126
4	Яллах биш, өсөх	128
5	Зүрхэн цэцэрлэг	130
6	Хайрцаглан шүүх.	132
7	Буруугаа хүлээгээд, тавьж явуулах	134
8	Тэсээд гарах хүчтэй	136
9	Ялгүй	138

ХЭСЭГ 8 – Биеэ хянан захирагдаа хүчирхэг

1	Анхааралтай сонсох	142
2	Дуршлаа хянан захирах	144
3	Уурлах нь хэвийн	146
4	Үгээ мэдэх	148
5	Харуусалгүй	150
6	Үгэнд үндэслэсэн	152
7	Тариалах ба хураах	154
8	Амрахын хүч	156
9	Бурханы төлөөлөгч	158

ХЭСЭГ 9 – Эрх чөлөөгөөр хүчирхэг

1	Нүглээс чөлөөлөгдсөн	162
2	Шинэ зүрх	164
3	Мэдэгдлийн хүч	166
4	Нүглээс эрх чөлөөтэй	168
5	Дэндүү өвдөж байна	170
6	Эрх чөлөө дотроо бат	172
7	Хүлээсгүй	174
8	Шинэ болгогдсон	176
9	Түүнийх байхаар чөлөөлөгдсөн	178

ХЭСЭГ 10 – Ариун байдлаар хүчирхэг

1	Энэ дэлхийнх бус	182
2	Дуулгавартай занд суралцах	184
3	Ариун болгогдсон	186
4	Галаар шинэтгэгдсэн	188
5	Мах биеийн мацаг	190

6	Зүрхээ тахил болгон өргөх	192
7	Загалмайгаа авах	194
8	Бурханы Үг	196
9	Тэсвэр суух	198

Бурхан
дотоо
хүчирхэг

ХҮЧИРХЭГ БАЙХ НЬ ХЭВИЙН ЗҮЙЛ

Эзэн ба Түүний чадлын аугаа хүч дор хүчтэй байгтун..

ЕФЕС 6:10

Хүчирхэг аяллаа эхлүүлэхээсээ өмнө “Хүчирхэг байхад буруугүйг” тогтоож аваарай.

Христэд итгэдэг эмэгтэй хүнийг хүчирхэг гэхээсээ дорой чанартай илүү холбож сэтгэдэг. Шашин заримдаа бидэнд өндийж цэгцрэхийн оронд бөгтийж бөртөлзөхийг сургадаг. Үнээн. Бид ноомой бус, номхон байхаар дуудагдсан. Номхон чанарыг атган дахь хүч гэж ойлгож болно. Мосе, Есүс хоёр номхон байснаас, ноомой байгаагүй. Хүч чадал нь Есүсээс ирдгийг номхон нэгэн мэднэ. Эстер ноомой бус, номхон байсан. Үүнээс гадна номхон хүн хүч нь өөрөөс нь өндөр хүчээс ирдгийг мэддэг тул даруу байдаг. Номхон нь хэрхэн дайтахыг мэддэг ч, тэмцлийг эрэлхийлдэггүй.

Түүнчлэн хүч чадал нь сөнөөгч зэвсэг ч, хоригдлуудыг чөлөөлөх зэвсэг ч болж чадах ар, өвөртөө иртэй сэлэм болой. Олонтаа чөлөөлөгдөх ёстой анхны хоригдол нь бид өөрөө болж таардаг.

Амьдрахад хүч чадал шаардагдана. Нас ахих тусам, амьдрал улам л хүндрэх. Бурхангүй соёлд бурханлаг амьдрахад чи, бид хоёрт хүнийхээ хүчээр барахгүй, өндөр хүч чадал хэрэгтэй. Гэхдээ чи, бид хоёр ганцаараа бишдээ гялайх хэрэгтэй. Хүн ямар учраас бэрхшээлийг залгиад, хүчирхэгжих ёстойг тоймлон заасан Ефесийн дараах ишлэлийг судалцгаая. Паул харилцааны талаар заасныхаа дараа Ефес 6: 10-18 дээр “Эцэст нь Эзэн ба Түүний чадлын аугаа хүч дор хүчтэй байгтун” (10) гэжээ.

Бүх харилцаа хүч шаардана. Гэхдээ бид хүмүүнийг хүнийхээ хүч чадлаар хайрлах гэж оролдох бүрийдээ бүтэлгүйтэх жамтай. Хүн бидний хүчин чадал өдөр тутам шаардлагатай хүчин чадлын минь хаа ч хүрэхгүй. Тиймээс л бид Эзэнийхээ хүч чадал, эрх хүч рүү нэвтэрдэг. ЭмЭсЖи Библи дээр “Бурхан хүчтэй бөгөөд чамайг ч хүчтэй байхыг хүсдэг” гэжээ.

Бурхан биднийг хүчгүйг мэддэг учраас, хүчтэй болгодог. Магтаалч Давид хоньчин хөвүүн байхдаа л энэ хүч чадлын эх ундаргыг олжээ. Хүчирхэг Бурхан минь биднийг хүчирхэг болгоно. Бурхан маань охиддоо хүчийг өгөх чадалтай. Бурхан чиний амьдралд төлөвлөгөө гаргасан бол, диавол схем гаргажээ. Тэр схем нь чамайг Бурханы төлөвлөгөөнөөс гаргах зорилготой. Диавол хэзээ ч шударгаар үзэлцдэггүйг мэдээрэй. Чи Бурханы охин болж, Ариун Сүнсээр тамгалагдсан цагаасаа л дайсны бай болжээ. Чи дахин төрөхөөсөө өмнө диаволын боол байсан бол, дахин төрснөөсөө хойш түүний бай болсон. Тиймд жинхэнэ эх хүчийг олсон бид эдүгээ хуяг дуулгаа өмсөх ёстой. “Та нар диаволын заль мэхний эсрэг зогсож чадахын тулд Бурханы өвч зэвсгийг агс.” (Ефес 6:11)

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Та Өөрөө хүчирхэг бөгөөд намайг ч хүчирхэг байлгахыг хүсдэг учир гялайлаа. Би хуяг дуулгаа өмсөөд, Таны төлөвлөгөөн дотор босч зогсоно..

Би хүчирхэг

БУРХАН МИНИЙ ХҮЧ ЧАДЛЫН ЭХ
УНДАРГА УЧИР БИ ХҮЧИРХЭГ.

ХРИСТ ДОТОР ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ

Тэгээд шударга ёс нь цөлд оршиж, Үнэн зөв нь үржилтэй талбайд байна. Үнэн зөвийн үйлс нь амар тайван байж, Үнэн зөвийн үр дүн нь Үүрдийн амар амгалан, аюулгүй байдал болно..

ИСАИА 32:16-17

Өөртөө итгэлтэй эмэгтэй гэхээр ямар дүр төрх санаанд чинь бууж байна? Өөртөө итгэлтэй эмэгтэйн дүрийг дэлхий хэрхэн гаргадгийг сэтгүүл, лангуу бас дэлгэцнээс олж үзнэ - захиргаадагч инээмсэглэлтэй, өөгүй маягтай, уургалагч дүр. Энэ дүр төрх нь гол төлөв аль нэг оо энгэсэг, бараа бүтээгдэхүүнийг хэрэглэснээр “нугасны муухай дэгдээхэйгээс” “үзэсгэлэнт хун” болж байгаад итгүүлэх гэсэн арилжааны шинжтэй. Гэхдээ амжилт, дур булаам байдлаас баталгаа эрэлхийлэх нь эцсийн дүндээ хоосон гүйдэл юм. Танихгүй хүмүүсээс зураг дээрээ хичнээн лайк, хэдэн коммент даруулж байж, “Одоо л ханалаа” гэж хэлэх гээ вэ? Хэдэн мянга ч хангахгүйг би чамд баттай хэлье.

Алдар юмуу гоо үзэсгэлэнд найдагч нь өөрийгөө үнэ цэнэтэй, хүнд хэрэгтэйг мэдрэхийн төлөө байнга л бусдыг царайчилна. Өөрийгөө үнэлэх үнэлэмж минь ч цаг үргэлж бусад хүүхнүүдийн халдлага, заналхийлэл дор байж, өөртөө итгэх итгэл минь ч байнгын доргиостой. Гэтэл бидэнд Өөр дээр нь очсон эмэгтэйчүүдийг гоо болгодог Ханхүү бий.

Түүнээс ирдэг өөртөө итгэх итгэл нь оройгүй бөгөөд ёроолгүй. Юун тэр шилний цаад үзүүлэн, утасны фильтр, гоёл чимэглэл,

будаг шунх. Тэр гоо үзэсгэлэн нь Есүс чамайг дотно мэдэж, гүн хайрласан гэдэг мэдлэгээс эхтэй, халуун дулаан, гүн илч. Ийн хайрлуулсан бүсгүй хүн... андашгүй дээ. Христ Есүс минь биднийг таалан ерөөсөн. Өөрийгөө хэрэгтэй хэрэггүй хэлтэрхий, хаягдлаар дүүргээд байлгүй, Есүсийн цул хайраар өлгийдүүл.

Сэтгэл чинь л “өмнө” ямар байгаад, “дараа” нь ямар болсонд анхаар. Христ бидний төлөө юу хийснийг үнэн голоосоо үнэлж, энэ суурин дээрээ л өөртөө итгэх итгэлээ сүндэрлүүл. Түүний хангаж өгдөг хайр хэзээ ч хөсөрдүүлэхгүй. Есүс биднийг нэг бүрчлэн нямбайлан тордож, хайр дотроо цэцэглүүлэхийг хүснэ.

*Эзэн минь, Та намайг Өөрийнхөө төсөөлөн харсан тэр
бүсгүй болгохын төлөө өдөр бүр шинэчилж, цэвэрлэж,
шинээр бүтээдэгт гялайлаа. Би өөртөө итгэх
итгэлээ Таны авралын нигүүлсэл дээр суурилуулна.*

Би хүчирхэг

ЕСҮС НАДАД ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛИЙН ЖИНХЭНЭ
ЭХ УНДАРГЫГ НЭЭЖ ӨГСӨН УЧИР, БИ ХҮЧИРХЭГ.

ГАНЦААРАА БИШ

Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл.

*Бурхан итгэмжтэй, Тэр та нарыг хэр чинь хэтэртэл
соригдохыг зөвшөөрдөггүй, харин дааж гарахын тань
тулд сорилттой хамт мөн гарцыг ч буй болгоно.*

1 КОРИНТ 10:13

Би чамтай хэзээ ч уулзаж үзээгүй мөн надад нэрийг чинь мэдэх завшаан тохиогоогүй байж болох ч, чи бид хоёр энэ амьдралд ялгаагүй л бэрхшээлийг туулж яваа адилхан улс. Энэ амьдралд чи юмуу би л зовоогүйг Коринт хэлжээ. Гэвч бидний сэтгэлийн дайсан - Сатан биднийг ганцаараа л ийм мэтээр ойлгуулж, ганцаардлаар яллах дуртай. “Чам шиг зовж яваа амьтан байхгүй! Чам шиг адгийн амьтан байхгүй!” гэдэг худал үгээ чихэн дээр шивнэгнэнэ. Би ч энэ худлыг сонссон. Чи ч энэ худлыг сонссон.

Бурхан амлалт, Үг дээрээ хэнийг ч алагчилдаггүй. Өөр дээр нь дуулгавартай, даруу зүрхээр очдог хүн бүрийг хүлээж авдаг. Харин бүгдийг мэддэг, чаддаг гээд төсөөлчихсөн, өөртөө зөв, ихэрхүү этгээд бол өөр хэрэг ээ. Бурхан өөрийнхөө хүчээр үйлдэхээс туйлдсан хүнийг л хамгийн сайн сонсоно. Бурхан туйлдаж, гэмтсэн хүмүүсийг “Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5) гэдэг урилгаараа түшээд л авна.

Гэтэл үнэт нандин охид бүсгүйчүүд ганцаардаж, гансарсаар. Бид зөрчлөөрөө нэгдэхээс гадна хүчээрээ ч нэгдэж чадахыг ухаарах цаг нь иржээ. Магадгүй чи яллагдаж, ганцаардсан байх. Тэгвэл

энэ худлаа шүү. Чи ганцаараа биш. Эзэн чамайг яллагч бус, аврагч сэргээгч болой.

Иймээс л хамт олон амин чухал. Бидний эдүгээ туулж яваа зөрчлийг хэдийнээ даваад гарсан хүмүүстэй холбогдох үедээ бид итгэлээр урам орно. Бид итгэлээр алхлаад, Бурхан тэр хүмүүст итгэмжтэй хандсан шигээ бидэнд ч итгэмжтэй хандана гэдэгт итгэх зүрх орно.

Бурхан чамд уурлаагүй.

Бурхан чамайг яллаагүй.

Бурхан чамд туслахыг хэнээс ч илүү хүсдэг.

Чи ганцаараа биш.

*Аав аа, Та намайг ялладаггүй бас би ганцаараа биш
учраас, гялайлаа. Намайг эдгэрлийн оршихуйдаа
хүлээж авсанд баярлалаа. Би эдгэрсэн бөгөөд
бусдыгаа ч энэ замаар дагуулан урамшуулна.*

— Би хүчирхэг —

БИ ГАНЦААРАА БИШ УЧИР, ХҮЧИРХЭГ. ЭЗЭН -
МИНИЙ ЯЛЛАГЧ БУС, АВРАН СЭРГЭЭГЧ БОЛОЙ.

БУРХАН ЧАМАЙГ СОНСДОГ

*Харин Бурхан үнэхээр сонсож,
Залбирлын минь дуунд Тэр чих тавьсан.*

ДУУЛАЛ 66:19

Заримдаа бидний нандин хайрханууд санасандаа хүрэх гэсэндээ муухай үг хэлж, цохиж, сарвалзаж, нумардгийг (за, томчууд бид ч ялгаагүй дээ) бага насны хүүхэдтэй аав ээж нар мэднэ. Хоёр настантай үзэлцэж байснаас зүгээр л буугаад өгсөн нь дээр мэт. Хожмын том дайнд ялахын төлөө ойр зуурын дажинд буугаад өгчихбөл. Гэвч ингэлээ гээд, одоогийн дажнаас улам л хүнд, улам л том зөрчил ирнэ. Болохгүй зан аашийг өнгөрөөх аваас, адагтаа араа шүд нь улам л чангарна. Өнгөрөөлөө гээд хүүхэддээ тус бус, ус л хүргэнэ. Бидний тэнгэрийн Бурхан Аав шиг цэцэн цэлмэг Аав үгүй. *Дураараа зан* маань бидний хамгийн үнэт зүйл болох зан чанарыг хөсөрдүүлэх эрсдэлтэйг Аав мэднэ.

Би ч үе үе ааш гаргана аа гаргана. “Бурхан минь, энэнд ийм юм, тэрэнд тийм юм байхад, яахаараа надад байдаггүй юм?” гэж ирээд л гоншигноно. Мөн заримдаа бусдынхаа талаар “Бурхан минь, тэдний буруу, миний зөв гэдгийг Та мэднэ! Тэдэнд мэдүүлээд, харуулаад өг!” гэнэ. Ялангуяа нөхөртэйгээ юмуу өөр итгэгч хүнтэй муудалцахаараа тэр л дээ. Тэгээд Бурхан тэдэнтэй уулзах үеэрээ миний зөв байсныг тэдэнд хэлж өгнө хэмээн төсөөлнө. Мэдээж, Бурхан хэзээ ч тийм юм хийгээгүй. Бурхан миний гоомой хүслийг биелүүлэхийн оронд сайн сайхныг минь бодолцсонд талархаад барашгүй.

Залбирал хариултаа хүлээж авахгүй байх шалтгаан олон. Бурхан сонсоогүй учраас тэргэвэл, худлаа болно. Бид тухайн үедээ ойлгохгүй байлаа ч, Бурхан илүү том зорилгын төлөө бидний өсөлтийг л цаг үргэлж уухайлан дэмждэг. Бид онцсайн сэдлээр залбирна уу, тааруухан ойлголтоор залбирна уу - Бурхан бидэнд чихээ наагаад, хэрэгцээг минь нэг бүрчлэн мэддэг. Түүнд өнө мөнхийн үзэл бодол бий. Миний бие ойлгосон ч, ойлгоогүй ч - өөрийгөө ч, бусдыгаа ч Бурханы мутарт даатгадаг болох хүртлээ төлөвшсөн цагт л Бурханы зөвт байдал бүрэн тогтоно. Тиймээс Бурханы сонсголд л найдаж, Түүний бүрэн эрх илчлэгдэхийн төлөө л амьдралаа авч явах ёстой.

*Эзэн минь, Та намайг ярих үед нигүүлслээрээ сонсож,
цэц ухаан, хүсэл дотроо хүлээн авч, хариулдагт
гялайлаа. Ирээдүй минь Таны мутарт аюулгүй.*

Би хүчирхэг

БИ ИРЭЭДҮЙГ МЭДДЭГ НЭГЭНИЙ
МУТАРТ БАЙДАГ УЧИР, ХҮЧИРХЭГ.

БИДНИЙ ЖИНХЭНЭ ХҮСЭЛ

Харцаа би уулс өөд өргөнө. Хаанаас надад тусламж ирэх вэ?

Тэрхүү тусламж минь тэнгэр газрыг бүтээгч ЭЗЭНээс.

ДУУЛАЛ 121:1-2

Хүн болгон аз жаргалыг хүсэх. Үүнийгээ олохын төлөө зарим нь мөнгө, эрх хүч, дэлхийн амжилттай хөөцөлдөх. Зарим нь хайр, секс, хүний тааллын араас хөлөө хугалах. Тэр бүү хэл, буян үйлдэх, шударга ёсыг дэмжих зэрэг эерэг зөв зүйлээс ч аз жаргалыг хайх нь бий. Гэвчиг Бурханаас гадуур хайсан аз жаргал буюу ханамж нь дампуурах жамтай. Зөв зүйлийг буруу газраасаа хайх шиг харуусал үгүй.

Бид харцаа тэнгэр өөд өргөх ёстой. Учир нь тусламж минь Бүтээгчээс л ирдэг. Тэндээс л бид эх үүсвэр, ханамжийг олно. Бид өөр юмстай хөөцөлдөөд байвал, тэр зүйл бидэнд хортой байсан ч, Бурхан биднийг дураар минь тавина. Энэ тун гунигтай үнэн. Паул хүн төрөлхтөнд “Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тул тэднийг Бурхан завхарсан сэтгэл болон хийх ёсгүй үйлдэлд нь орхижээ” (Ром 1:28) хэмээн бичсэн буюу.

Бид газар дэвслээд “Үгүй ээ! Миний хүссэнийг өгөөд аль!” гээд байвал, Бурхан гэдрэг ухраад, тэнэглэлийг минь биелүүлээд өгнө. Тэгээд бид найдлага минь талаар болсныг хождож ухаарна.

Бурхан биднийг цагдахыг ч, шийтгэхийг ч хүсдэггүй. Түүний урилгыг л л сонс: “Хүрээд ир, тэгээд хэлэлцье” гэж ЭЗЭН айлдаж байна. “Хилэнц нүгэл чинь час улаан мэт байвч цасан адил

цагаан болно. Хүрэн лугаа улаан боловч ноос лугаа адил болно. Уриалгахнаар та нар дагах аваас Уул газрын сайныг иднэ.” (Исаиа 1:18-19)

Бүгдээрээ Бурхан руу дуртайяа, дуулгавартайяа эргээд, Түүнийг л хүч, тусламжийнхаа ундарга болгоцгооё.

*Тэнгэрийн Аав минь ээ, Та миний амьдрал, тусламжийн
жинхэнэ эх ундарга байтал, итгэлгүй хоосон газар руу гүйсэнд
минь уучлаарай. Намайг цэмцүйтэл угаагаад, хүсэлтэй,
дуулгавартай сүнсийг хөгжүүлэхэд минь туслаарай.*

— Би хүчирхэг —

ТЭНГЭР, ГАЗРЫГ БҮТЭЭГЧ НАМАЙГ ХҮЧТЭЙ
БОЛГОСОН УЧИР, БИ ХҮЧИРХЭГ.

ХАНГАЛУУН

*Чөмөг, өөхөнд юм шиг сэтгэл минь цатгалан бөгөөд ам
минь баясгалант уруулаар магтаалуудыг өргөнө. Шөнөжин
Таны тухай тунгаан бодохдоо орондоо Таныг би дурсан
санана, Учир нь Та миний тусламж бөгөөд Таны жигүүрийн
дор би баясгалантайгаар дуулна. Сэтгэл минь Танаас
зуурчээ. Таны баруун мутар намайг түшиж байна.*

ДУУЛАЛ 63:5–8

Чи биеэ бодсондоо, элдэв эрүүл, амтат, тансаг зоог бүхий найрын ширээнээс хэтрүүлж бус, тааруулж хүртдэг л байх. Тиймээс орондоо орохдоо цатгалдаж зовох бус, сайхан зоог барьсандаа сэтгэл чинь жаргана. Хэмжээг хэтийг тааруулахад бие ч, сэтгэл ч жаргах.

Ер нь хүний сэтгэл биетэйгээ л адил таашаах дуртай. Бид ч Давид шиг орондоо хэвтэхдээ, Бурханы сайн сайхныг эргэцүүлэн жаргаж болно. Үгүй бол зөрчил, бүтэлгүйтлээ дурсаж болно. Би чамайг Аавынхаа гайхамшгийг бодоод, сэтгэл оюунаа амрахыг урамшуулж байна. Далавчаа тэлэн, ангаахайнуудаа хамгаалах хүчирхэг шувууг төсөөл. (Одооноос би Тайтгаруулагч Бурханаа яг ингэж төсөөлнө!) Тэгээд амар тайван нойрс. Ийм талархал, гайхамшгийн уур амьсгал дунд зүрх минь бидний зүрх амьдрал дээрх Эзэний тусламж, хамгааллыг магтан дуулна. Өдөр бүр Бурханд баярлаж амьдар.

Нойр бол гайхамшиг. Хүн унтах үедээ хамгийн эмзэг. Хэдэн цаг ухаан тасраад, алга болдог. Хүүхдүүд насанд хүрсэн хүнээс илүү бөх нойрсдог. Сэтгэл зовнихыг үл мэдэх, амгалан жаалууд нүд ирмэхийн зуур завгүй өдрөө шөнийн нойроор хөрвүүлнэ. Гэтэл

томчууд унтах гэж баахан зовох. Бид орондоо буруу юмс тээж ордог. Тэгээд шөнө дунд өнгөртөл зовнил, айдастайгаа барилдсаар, орондоо орсноосоо ч илүү ядраад сэрнэ.

Би ч санаа зовниж унтсан үедээ хэзээ ч сайн амарч чаддаггүй байлаа. Шөнө нь өдрөө өндөрлөөд, зүрхээ Бурханд даатгадаг цаг. Дуулал 127:2 дээр “Хайрладаг хүндээ Тэр нойрыг ч өгдөг” гэдэг. Бурхан төгс хүмүүст эсвэл төгс амьдарсан хүнд нойр өгдөг гэж хэлээгүй. Бурхан хайртай хүүхдүүддээ нойр өгдөг. Түүний хайртай хүү нь чи юм. Өнөө шөнө унтахдаа, Бурханы сайн сайхан, хамгаалалтаар өлгийлүүлээд унт. Тэгсэн цагт өглөө толгойд чинь магтаал мандаж сэрнэ.

*Эзэн минь, би шөнө бүр алдаа оноотой өдрөө хаагаад,
Таны өө сэвгүй хайрыг л бодмоор байна. Та хайр учраас,
намайг хайрладаг. Надад нойр өгдөгт баярлалаа.*

Би хүчирхэг

БИ БУРХАНЫ САЙН САЙХНЫГ ЭРГЭЦҮҮЛЭХДЭЭ
ХҮЧИРХЭГ БАЙЖ, СЭТГЭЛ АМАРДАГ.

ХАЙРАН ДОТОР ЧИМЭЭГҮЙ БАЙХ

Чиний Бурхан ЭЗЭН, аврагч дайчин, Та нарын дунд байна. Тэр та нарын дээр баяр хөөртэйгөөр баясна. Тэр хайр дотроо чимээгүй байна. Тэр та нарын дээр баярын уухайгаар баясах болно.

ЗЕФАНИЯ 3:17

Бидний олонх маань сексийн хар дарсан зүүдэндээ амьдрах. Зарим нь харилцааны аймшиг дотроо амьдрах. Тэгвэл хар дарсан зүүдтэй зүүдээр тэмцэх үр дүнтэй байдгийг би сурсан.

Жишээ нь хөвгүүд минь шөнө айх, өвдөх юмуу хэт хөөрсөндөө сэрчихбэл, би хөвгүүдээ тайтгаруулаад, дахиад унтуулах гэж оролддог. Хажуугаар нь орж хэвтээд бүүвэйлэх юмуу эсвэл нөхөр хол явах юмуу их орой болчихсон байвал, өвөртөө оруулаад, бүүвэйлдэг. Яагаад? Ээж нь хамт байгааг мэдүүлэх гэж. Хөвгүүдийнхээ үсийг нь илбэнгээ, гараараа тэврээд, айдсыг нь сонсоно. Тэгээд Бурханы ч, өөрийнхөө ч хайрыг шивнэн баталгаажуулаад, Бурханы итгэмжит хамгаалалтыг сануулна. Ийм маягаар эргээд нойрстол нь бүүвэйлнэ.

Айсан үрээ ийнхүү бөмбийлэн энхрийлэх ээжийн үйлдэл нь Бурханаас л эхтэй. Биднийг тайтгаруулах гэсэн Бурханы хүслийн өчүүхэн тусгал гэлтэй. Шархдаж, бүтэлгүйтэж, айсан биднийг Бурхан Өөрөөс нь холдолгүй, харин улам наалдаасай гэж хүсдэг. Бурхан хүүхдүүддээ хайр, хамгаалалтын тэврээ дэлгэдэг. Тэвэр дороо Бурхан бидэнд гоо үзэсгэлэнт алсын хараагаа өгөөд, тайтгаруулан амраадаг.

Ямх охиноо тэврээд, үсийг нь зөөлөн илэн аргадан тайтгаруулж

байгаа аавын дүр зурагт би хайртай. Бурхан Аав маань ч чамд дараах юмсыг өгөхийг хүсч буй:

- чамтай дотносох
- ял, ичгүүрийн сэв бүрийг чинь угаах
- үнэнийхээ гэрлээр айдсыг чинь үлдэн хөөх
- найдвар, ирээдүй хайрлах
- шуурга намжтал бүүвэйлэх
- дахин амраах
- зүрхний чинь мөрөөдлийг дахин бадраах

Бурхан хахир хатуу нэгэн биш. Бурхан бидэнд туслахад хэзээд бэлхэн байдаг бөгөөд аугаа хүчээрээ биднийг авардаг. Бидний аврал эрсэн айдсын дуунаас Бурхан түвэгшээхгүй. Эх хүн үрээ тайтгаруулдаг шиг Бурхан ч үр хүүхдээ тайвшруулах дуртай. Гэхдээ эх хүний тайтгаруулах чадвар хязгаартай бол, Бурханы хайр, чадвар хязгааргүй. Бурханы гүн зан чанар биднийг тайтгаруулан бүүвэйлдэг. Хүнийхээ хүчээр намжааж дийлэхгүй шуургаа Бурханаар намжаа.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Та надтай хамт байж,
хайраараа тайвшруулна гэсэн Зефаниа 3:17 дээрх амлалтанд
тань итгэн, Танд ойртъё. Таны зүүд надад тулгарсан ямар
ч хар дарсан зүүднээс хүчирхэг. Би Таны дотор амаръя.*

— Би хүчирхэг —

ХҮЧИРХЭГ БУРХАН НАДТАЙ БАЙЖ,
ХАЙРААРАА СЭТГЭЛИЙГ МИНЬ БҮҮВЭЙЛЭН,
ТАЙТГАРУУЛДАГ УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

АЙХ АЮУЛГҮЙ, ХАМГААЛАГДСАН

Зүрх юугаан урьтан хамгаал амийн булгууд түүнээс ундарюу.

СУРГААЛТ ҮГС 4:23

Манай гэрийн үнэт хөрөнгө юу вэ? Түүнийгээ хулгайд алдах юмуу алга болгочихбол, яах уу? Жаахан явдал чирэгдэлтэй ч, хадгаламж, даатгалаараа дахиад авчих боломжтой учраас, аминд тулсан аюул болохгүй байх. Тэгвэл дурсамж агуулсан үнэт хөрөнгө чинь? Тухай нь, амьдралын чинь түүхийг өгүүлсэн зургийн цомог ч юм уу. Иймэрхүү эд хөрөнгийг орлуулах боломжгүй. Алдагдлаа хүлээхээс өөр замгүй. Гэхдээ харууслаа харууслаа гээд амьдрал чинь мөн л үргэлжилдгээрээ үргэлжилнэ. Үнэндээ, хулгайчид хамаг гэрээ ухуулчихсан байлаа ч, зүрхтэйгээ л үлдсэн бол, хамгийн үнэт юмаа алдаагүй л гэсэн үг.

Гэхдээ чи зүрхээ хүнд юмуу юмд хайр гамгүй тавиад туучихсан нөхцөлд хулгайд алдах боломжтой. Үлэмж хохирол үзнэ. Иймээс л Бурхан Өөрийг нь л бүх зүрхээрээ хайрлаарай гэжээ. Учир нь Түүн дотор л бидний зүрх аюулгүй. Чиний зүрх буюу сэтгэл “амьдралын чинь бусад бүх зүйлд нөлөөлөх” (Сургаалт үгс 4:23 ТиЭлБи) хүчийг агуулна.

Энэ ишлэл дээр “эх ундарга” болсон зүрхээ хамгаалаарай гэдэг. Эх ундарга нь амьтан, ургамлыг тэтгэгч цэвэр, цэнгэг, аюулгүй ус. Эх ундарга нь эргэн тойрондоо амь өгөх. Иргэншлүүд ч ус дагаж л хөгждөг. Хуурай газар дээр амь, үхлийг ус л шийдэх. Усыг хордуулах юмуу гүнээс нь тасалдуулах юм бол, тухайн орчин бүхлээрээ

мөхнө. Тиймээс л усны эх ундаргыг хамгаалж, хандаж, гүнээс нь тасалдуулдаггүй.

Зүрх нь бидний амьдралыг тэтгэгч эх ундарга учраас, бид зүрхээ хамгаалах ёстой юм. Бид хорсол, гомдлоос сэргийлснээрээ, зүрхээ бохирдохоос хамгаална. Бид залбирал, магтаалаараа жинхэнэ эх ундаргатайгаа холбогдсоноороо, зүрхээ хатахаас сэргийлнэ. Бид энэ дэлхийн найдваргүй юмсаас зайлсхийснээрээ, зүрхээ эрүүл бус дуршлаас хамгаална. Зүрхээ нандигнан хамгаалж, “Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла” (Матай 22:37) гэсэн Есүсийн тушаалыг хайрлалбал, Есүс чамайг аюулгүйгээр сахин, тордоно.

Бурхан минь, зүрхээ Танд даатгаж, Танаар хамгаалуулахыг зааж өгөөч. Зүрх минь Таны халамжин дор л аюулгүйг би мэднэ.

Би хүчирхэг

ЭХ УНДАРГА БОЛСОН ЗҮРХЭЭ
ХАМГААЛДАГ УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

ЧИМЭЭГҮЙ

“Тэмцэлдэхээ больж Бурхан гэдгийг минь мэд.”

ДУУЛАЛ 46:10

Ө нөө орой унтахаар хэвтэхдээ нэг туршилт хийгээд үзээрэй. Унтдаг цагтаа орондоо ороод, хэсэгхэн хугацаанд чимээгүй хэвтээд, Бурханд зүрхээ нээгээрэй. Зүгээр л чив чимээгүй байж, Бурханаа хүндэтгээд, мэд. Юуг мэд гэж? Түүнийг Бурхан гэдгийг нь мэдэж, амьдралд чинь - аз жаргал, зовлон, зөрчил, нулимсан дунд чинь Өөрийгөө илчлэхийг нь зөвшөөр. Бурхан чамайг нойрондоо автахаас өмнө хайраа шивнэхийг хүснэ.

Зүгээр л нам гүм, чив чимээгүй болоод... сонс. Зөрчилдөж байгаа бол, өөрийгөө зөвтгөх гэмээн бүү улайр. Зүгээр л чимээгүй байгаад, аниргүйн дунд Өөрийгөө илчлэхийг нь Бурханд зөвшөөр. Өөрийнхөө бүх аргументыг хойш тавиад, Түүний ойлголт, үзэл бодлыг хүлээж ав.

Залбирал, тунгаан бодохуйн жин нь ярихад бус, сонсоход оршино. Залбирал гэхээр, бид голдуу бидний зүгээс хийх юмс л гэж боддог - Бурханы өмнө үгээ хэлэх, зүрх сэтгэлээ уудлах, хүсэлтээ уламжлах. Эдгээр нь сайн зүйлс. Гэхдээ хангалтгүй. Мэдээж Бурханд зүрхнийхээ хүслийг дэлгэж, гуйх цаг бий. Шударга ёсыг шаардаж, гуйж гувших ч цаг ч бий. Гэхдээ хүний үгийн урсгал биднийг цэвэрлэхгүй. Тэдгээр нь ердөө л бидний үзэл санааг л илэрхийлнэ. Хүний учир зүй үерлэн гарахдаа нил шавар шавхай дагуулдаг болохоороо цэвэрлэх нь бүү хэл, хамаг байдгаар нь хутган, булингартуулдаг. Бид ойлголтоо сэргээж, миний ял, шившгийг зайлуулах чадалтай, гүн уснаас татах хэрэгтэй.

Амсхий. *Села*. Бурханы хэлж байгаа үгийг сонсох цаг гарга. Өдрийн адаг дээр бодлыг чинь хэрсэн зовнил, эрээлжилсэн бодолд хүчээ соруулж, амар тайвнаа алдах шаардлага байхгүй. Мэлийж суугаад, өдрийнхөө шаналал, бүтэлгүйтлийг толгой дотроо ахин дахин тоглууладгаа боль. Оронд нь жинхэнэ амар тайвныг авчрах чадалтай Нэгэнтэй уулз. Тэр л чамайг цуцаагч бодлоос чөлөөлж, унтах хойгуур чинь сэтгэлийг чинь нөхөн сэргээнэ. Чи сэрэхдээ, “ЭЗЭНий хайр энэрэл дуусдаггүй Өршөөл юунд нь төгсгөл үгүй. Өглөө бүр энэ нь цоо шинэ. Таны итгэлт байдал юутай аугаа” (Гашуудал 3:22-23) гэдгийг олж мэднэ.

Аав аа, намайг унтах хойгуур сэтгэлийг минь түвшитгэж, зүрхэнд минь айлдаач. Жолоогүй эрчлэх бодлыг минь ганцхан Та л зогсоож чадна. Би жаргаж буй энэ өдрийг Таныхаа мутарт даатгаад, өглөө буух шинэхэн өршөөлд тань талархъя.

Би хүчирхэг

БУРХАНЫХАА ӨМНӨ ТҮВШИН
УЧИР, БИ ХҮЧИРХЭГ.

Сүнс
готол
хүчлэхэг

ДУУНЫ ХҮЧ

*ЭЗЭНД шинэ дууг дуулагтун, учир нь Тэрээр
гайхамшигтай зүйлсийг үйлдсэн Түүний баруун гар ба
Түүний ариун мутар Түүнд авралыг гүйцэтгэсэн.*

ДУУЛАЛ 98:1

Хайр, хөгжим хоёр цаанаасаа л тэнгэрлэг зангилаатай. Эдгээр нь тэлэхдээ, нэг нэгнээ илчлэх. Хөгжим биднийг аялуулах хүчтэй. Хөгжмөөр булхсан үг нь зүрхний минь хэний ч, юуны ч хөндөж чадахгүй хэсэгт хүрэлцэх чадалтай. Бид бүгдээрээ л дууны хүчээр ер бусын жаргалын оройд дүүлж, уй гунигийн ёроолд тунаж үзсэн.

Хөгжим биднийг бодит нөхцлөөс минь шүүрэн, Бурханы Өөрийнх нь шууд оршихуйд нэвтрүүлдэг учир, Бурханыг гэх хайрыг минь сэрээх оньсон түлхүүр мөн. Хөгжим бидний цөм дэхь мэдрэмжийг мандал дээр түрж гаргаад, улам л Бурханы зүрх рүү ойртуулах. Үгээр илэрхийлэшгүй, оргилсон их сэтгэл мэдрэмжийг минь хөгжим л төлөөлөн өгүүлэх.

Хөгжмийн тосолгоо гэж байдгийг мэдэх үү? Тиймээс бид сонголтоо тун болгоомжтой хийх хэрэгтэй. Тосолгоо нь Хуучин гэрээний үед хаан, тахилч юмуу зөнчийг тослон томилохтой холбоотой ойлголт байв. Тосолгоо нь Бурханы Сүнсний биет төлөөлөл байв. Шинэ гэрээнд тосолгоо нь Христийг илчлэх Ариун Сүнсний оршихуй, хүчитгэлийг төлөөлнө. Тиймээс Сүнсээр хүчижсэн, тосолгоотой, бурханлаг хөгжим нь биднийг Бурханы

оршихуй руу нэвтрүүлнэ. Миний хувьд, магтаал хүндэтгэлээр Бурханы оршихуйд бүрэн автах үе байдаг. Хэдийгээр Бурханыг нүдээрээ үзэхгүй ч, яг л Биеэрээ хамт байх мэт. Тэр оршихуйд би төгс хайрлуулж, төгс хамгаалагдана.

Хөгжим бидний сэтгэл оюуныг аялуулдаг болохоор, зорих газраа болгоомжтой сонгох ёстой. Чи цэвэр амьдрахыг хүсдэг бол, хүсэшгүй нөлөө бүрээс өөрийгөө хамгаал. Хөгжим чиний нүүрэн талын хамгаалалтыг эвдэж ороод... оюунд чинь суурьшаад авна. Дууных нь үгийг амаараа хэлээгүй байлаа ч, цаад санаа нь толгой дотор чинь ахин дахин, ахин дахин тоглогдоно. “Энэ дуу толгойноос гарахгүй нь!” гэж ярьдаг биз дээ.

Тиймээс цэвэр бус дууг тэнгэрлэг дуугаар орлуул. Дэлхийн дуу бүгдээрээ муу байх албагүй ч, Бурхан руу ойртуулдаг нь цөөхөн. Тэгвэл тэнгэрийн дуу ойртуулна. Бид тэнгэрийн дууг дуулахдаа, Бурханд хайр, хүслээ илчилдэг. Энэ нь хүндэтгэл бөгөөд хүндэтгэл нь ямагт хүндэтгэл үзүүлэгч хүний хүслийг ухаж илчилдэг. Чи хөгжмийн хүчээр Бурханы оршихуйд дулаацаж болох ч, хөгжим чамайг Бурхан руу ойртуулахдаа л ойртуулна.

Эзэн минь, дуу хөгжмийн төлөө Танд баярлалаа. Дуугаар зүрхээ өргөх үед минь надтай ойр байж, хөгжмийн хүчээр сэтгэлээ хатжуулж сурахад минь туслаач. Зүрхний минь дуу бүр Таныг алдариуулах болтугай.

— Би хүчирхэг —

ТЭНГЭРИЙН ДУУГ ДУУЛАХААР
ДУУ ХООЛОЙГОО ӨРГӨХДӨӨ,
БИ ХҮЧИРХЭГ.

ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ БӨГӨӨД ЧАДВАРТАЙ

Христээр дамжин Бурханд хандах ийм итгэл бидэнд бий. Бид чухамхүү аливааг өөрсдөөсөө мэт зүтгээж чадахгүй ч бидний чадвар Бурханаас юм.

2 КОРИНТ 3:4–5

Надад өөртөө төгс итгэлтэй юмуу төгс чадвартай байдаг тал байхгүй. Харин чиг дангаараа чадваргүй гэдэгтээ л итгэл төгс байна. Гэхдээ бид төгс итгэлтэй байх албагүй нь сайн мэдээ. Ариун Сүнсний удирдамжгүйгээр итгэлээр амьдарч чадах хүн байхгүй. Давид хаан “Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж, Миний дотор зөв сүнснийг шинэчлэн авчраач. Оршихуйгаасаа намайг бүү холдуулаач. Ариун Сүнсээ надаас бүү аваач. Авралынхаа баясгаланг надад сэргээж өгч, Хүсэл зоригийнхоо сүнсээр намайг тэтгээч” (Дуулал 51:10-11) хэмээн залбирсан.

Давид хаан Ариун Сүнс л түүний цэвэр зүрхний эх ундарга бөгөөд Түүний хүчээр л амьдрахаа ойлгодог байж. Иохан 20 дээр Есүс дагалдагч нартаа Ариун Сүнсээ дамжуулсан үйл явдал гардаг. Ариун Сүнсний хүчээр л тэд бусдыг уучилж чадах байв. 2Коринт 3:6 дээр “Тэр биднийг Шинэ гэрээний үсгийн бус харин Сүнсний үйлчлэгчид байх чадвартай болгосон. Учир нь үсэг хөнөөдөг бол,

Сүнс амь өгдөг аж” гэдэг. Уншсан Бичээсийг чинь амилуулж, амь, өөрчлөлтийг авчрахын төлөө Ариун Сүнсийг урьбал, яасан юм?

Ариун Сүнс болбоос Есүсийн хэлсэн бүгдийг зааж, сануулах үүрэгтэй, бидний Тайтгаруулагч, Зөвлөх болой. Энэ нандин бэлгийн ачаар бид Бурханы зүрхийг дагаж, Үг, зааврыг нь ойлгуулан заадаг хувийн Багштай байдаг. Сүнс бидэнд харуулахын тулд нүдийг минь, сонсуулахын тулд чихийг минь, итгүүлэхийн тулд зүрхийг минь нээдэг.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, би Таны дотор өөртөө
итгэлтэй бөгөөд чадвартай байдаг учраас, баярлалаа.*

*Ариун Сүнс ээ, намайг хөтөлж, миний дотор цэвэр
зүрх, шинэтгэгдсэн, зөв сүнсийг өгөөч. Намайг
Аавыг алдариуулж амьдрах хүчтэй болгооч.*

Би хүчирхэг

ХРИСТ НАМАЙГ ӨӨРТӨӨ
ИТГЭЛТЭЙ, ЧАДВАРТАЙ БОЛГОДОГ.

ЭРҮҮЛ ЗҮРХ

Баяр хөөртэй зүрх болбоос сайн эм.

Эмтэрсэн сүнс аваас ясны хувхай өвчин.

СУРГААЛТ ҮГС 17:22

Библи бидэнд эрүүл мэндийн эх ундаргыг харуулдаг. Ясны чөмөгт буюу төвд чийг байна. Тэнд дархлаа байх бөгөөд цусны эсүүд маань бэхлэгддэг. Бидний амь цусанд минь оршдог бөгөөд цус нь ясан дахь чөмөгнөөс бэхлэгдсэн байдаг. Яс хатбал, хүний амь асуудалд орно. Сургаалт үгс 14:29-30 дээр ч “Уурлахдаа удаан нь ухаан дүүрэн. Түргэн зантай нь мунхаглалыг дээдэлнэ. Махбодын амь нь уужуу зүрх. Ясыг ялзруулагч нь хүсэл тачаал” хэмээн батлан хэлдэг.

Библи тэвчээрийг түргэн зантай, амар тайвныг атаархалтай сөргүүлэн жишдэг. Тэвчээр нь ойлголт хайрладаг бол, түргэн зан нь мунхаглалын нотолгоо юм. Тайван зүрх нь биед амийг өгдөг бол, атаархал, ёрын хүсэл нь ясыг муутган ялзруулна. Зарим төрлийн хорт хавдрыг чөмөг шилжүүлэх мэс заслаар эмчилдэг нь гайхмаар биш үү? Эрүүл чөмөг амин чухал. Яс нь биеийн бүтцийг дэмждэг. Тэдгээр нь хүнийг салгаж унагахгүйгээр, тогтоодог хүрээ юм.

Сүнсний зүрх бөгөөд эрүүл мэнд хоёрын хооронд бодитой, биет харилцаа байдгийг Библи батлан хэлдэг. Би өвчтэй хүмүүсийг сүнсний суурь өвчтэй гэж хэлэх гэсэнгүй ээ. Бид өвчин, эмгэгээр харагдсан, нүгэлт ертөнцөд амьдарч буй. Зүгээр л хорсол, үл уучлал, шийдээгүй уур зэрэг зүрхний асуудал нь хүний дархлаанд шууд нөлөөлдгийг л хэлэх гэв. Нэйл Кларк Уоррен “*Make Anger Your Ally*” гэдэг номдоо өвчин эмгэг нь нэгдүгээрт гологдох, хоёрдугаарт гонсойхтой холбоотой байдгийг хэлжээ. Шийдвэрлээгүй уур хилэн

нь толгойн, гэдэсний өвчин, ханиад, колит, даралт зэрэг өвчний суурь болдог юмсанж.

Үүгээр тогтохгүй артрит, амьсгалын замын төрөл бүрийн өвчин, арьсны өвчин, хүзүү, нурууны өвчин, тэр бүү хэл хорт хавдартай холбоотой байдгийг ч тогтоосон судалгаа бий. Хүн төрөлхтний өнөөдөр нээж буй юмсыг Библи хэдэн зууны тэртээс мэдэгдсээр ирсэн. Сургаалт үгс 3:5-8 нь бидэнд хэрхэн амьдрахыг заасан, цэц ухааны уурхай болой:

Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Бүү түшиглэ, өөрийнхөө ойлголтод. Түүнийг мэдэхэд зам бүхэн чинь байг Тэрээр зам харгуйг чинь шулуутгана. Өөрийнхөө нүдэнд бүү мэргэн бол ЭЗЭНээс эмээ, ёрын муугаас эргэ. Энэ нь маханд чинь эм, ясанд чинь шим болно.

Энд нэгэн амлалт байна: Бурханы тэнгэрлэг эрүүл төлөвлөгөөний дагуу амьдарбаас, Бурхан бидний биед эрүүл мэндийг, ясанд минь тэжээл өгнө.

*Эзэн минь, Та зүрхийг эрүүл мэндтэй зориуд холбосон.
Надад эрүүл сүнсээр амьдрахад туслаач. Тийнхүү
би шаардлагагүй үр дагавраас сэргийлнэ. Таны цэц
ухаанаар биеэ ч, сэтгэлээ ч тэжээхэд туслаач.*

— Би хүчирхэг —

БАЯР ХӨӨРТЭЙ, ЭРҮҮЛ ЗҮРХТЭЙН
УЧИР, БИ ХҮЧИРХЭГ.

4

БҮСГҮЙ ХҮНИЙ МӨН ЧАНАРАА ХАЙРЛАХУЙ

... үнэнийг барьж, ингэхдээ харин хайранд, тэргүүн болох Түүн өөд, Христ өөд бүх талаар өсцгөөе.

ЕФЕС 4:15

Эмэгтэй хүн цаанаасаа л бусдыг бөөцийлөгч, уян зөөлөн бодол, сэтгэлтэй бүтээгдсэн. Биднийг хурц шовх бус, харин уян налархай хэлбэрээр бүтээсэн. Бид эрчүүдээс илүү зөөлөн, энэрэнгүй чанартай. Бид цээжиндээ гүн хайр, энэрлийг тээж явдаг. Бид эрчүүдээс сэтгэл хөдлөл ихтэй бөгөөд шал танихгүй хүний зовлон, зөрчил, гарзын төлөө ч уйлж унждаг улс. Тэгэхээр, энэ их сэтгэл хэлбэлзлийг зөв зүйтэйгээр илэрхийлэхгүй бол, дотроо юмуу гаднаа дэлбэ үсрэх эрсдэлтэй.

Тэгвэл юу болох уу? Тухай нь, гэрлэлтийн амьдрал дээр юу болохыг миний хамгийн хайртай хоёр Бичээс өгүүлрүүн. Би гэрлээд удаагүй байхдаа, энэ хоёр ишлэлийг байнга санадаг байж билээ: “Дэндүү яншаа эхнэртэй нэг байшинд сууснаас дээврийн буланд амьдарсан нь дээр” (Сургаалт үгс 25:24). Хатуухан хэлбэл “Ууртай, яншаа эмтэй цуг байснаас цөлд амьдарсан нь дээр” (Сургаалт үгс 21:19).

Ээ, яана аа. Дээврийн хонгилд амьдарч байгаа хүн цаг агаарын бүх эрсдлийг үзнэ. Дээвэр бороо шороо, цас, салхи, халуун нарнаас

хамгаалах үүрэгтэй. Тэгэхээр, Соломон хэрүүлч авгайн дэргэд аж төрснөөс байгалийн гамшигт өртөж амьдарсан нь дээр л гэжээ. Дээр үед дээвэр чинь алжаал тайлж, амрах зориулалттай довжоо, тагтархуу юм байсан гэж би нөхөртэйгээ их маргадаг байж билээ. Гэвч ийм маягаар Бичээсийн санааг будлиулах арга байхгүй. Хилэнтэй, дошгин, хэрүүлч эмтэй амьдарснаас хилэнцэт хорхой, могойтой цөлд амьдрах нь дээр аж. Тэмцэл нь бусдыг ч, биднийг ч туйлдаах.

Эмэгтэйчүүд эрүүл бөгөөд халуун, хайрлагч, энэрэнгүй байхаар бүтээгдсэн. Бид бүтээгдсэн анхны хэв маяг бүхий зорилгоосоо гажих аваас, өөрийнхөө биед дайн зарлана. Амь өгдөг, бэхжүүлдэг, дэмждэг үүргээ хөсөрдүүлнэ. Эмэгтэйчүүд хань ижилтэй юмуу ганц бие байхаасаа үл хамааран, энэ үүргээ биелүүлж чадна.

Хага үсэртэл нь нөөшилсөн мэдрэмж, бодол хэнд ч ямар ч сайн юм авчрахгүй. Биднийг зөрчлөөс аврахгүйгээр үл барам, биднийг ч, бусдыг ч шархлуулах, ёрын муу авирыг л төрүүлнэ. Үнэнийг хайр дотор эгшиглүүлж, Бурханы өгсөн халуун, хайрын, эрүүл мөн чанартайгаа эвтэй амьдарцгаая.

*Эзэн минь, надад эмэгтэй хүн байхыг тодорхой зааж өгөөч.
Зөөлөн атлаа хүчтэй байхыг, Танд үйлчлэхийг, Таны өгсөн
дуу хоолойгоор үнэнийг хайр дотор өгүүлэхийг сургаач.*

Би хүчирхэг

ӨӨРИЙНХӨӨ МӨН ЧАНАРТ ДУРЛАН,
МӨН ЧАНАРЫНХАА ЭЗЭН НЬ
БАЙЖ, ХАЙР ДОТОР ҮНЭНИЙГ
ЯРИХДАА, БИ ХҮЧИРХЭГ.

ТАЙВАН БӨГӨӨД ХҮЧИРХЭГ

Эелдэг хариулт уурыг зайлуулах. Эвгүй үгс хилэнг хөдөлгөх.

СУРГААЛТ ҮГС 15:1

Заримдаа харилцан яриа сайнаас муу, муугаас сайн болж хувирдаг. Заримдаа Ариун Сүнс надад “Тайван бай, дуугаа намсга, зөөлөн хариул. Хүссэнээ хэлэх биш, Миний намуун, зөөлөн дууг сонсож, Миний үгийг хэл” гэдэг. Би ч заримдаа дуулгавартай нь аргагүй сонсдог бол, заримдаа дагахаасаа өмнө амжиж үг унагаад, араас нь тэр тэнэглэлийнхээ горьг амсдаг.

Одоо би бусдад дуу хоолойгоо хүргэхийн нууцыг мэддэг болсон. Тун энгийн: хүнд сонсогдмоор байгаа бол, өөрөө сонсмоор байгаа тэр янзаараа л ярь. Яг ийм янзаар ярих үед хөвгүүд маань, нөхөр минь, ажилчид маань, нохой минь - бүгдээрээ л жигтэйхэн сайхан сонсдог. Би мэдээж хүн надтай хүндэтгэлтэй, зөөлөн өнгө аясаар яриасай л гэж хүснэ. Хашхичаагүй хүнийг би илүү сайн сонсдог. Чанга, сул дуу юмуу үгийн давтамж бус, харин ярьж байгаа зүйлийн минь утга жин, хүргэж байгаа өнгө аяс л хүний анхаарлыг татна. Аашаараа түрэмгий хүмүүсийг хэн ч нухацтай хүлээж авахгүй. Тухайн үедээ санасандаа хүрч болох ч, хожим өртгийг нь төлөхдөө л төлнө. Хүн олон шалтгаанаар ааш авир гаргаж, дуугаа өндөрсгөдөг. Жишээ нь:

1. Хэн ч намайг сонсохгүй байна гэж айсандаа.
2. Орилж чарлах байдлаар санаандаа хүрээд сурчихсандаа.
3. Бусдыг айлган сүрдүүлэхийг хүссэндээ.

4. Хүүхэд байхаасаа тэгж авирлаад сурчихсандаа.
5. Шийдэгдээгүй асуудалдаа цухалдсандаа.
6. Ингэх муу дадал хэвшилтэй болсондоо.

Ихэнх шалтгаан нь айдас дотор үндэслэдэг. Бурхан бидэнд айдсын сүнснийг бус, харин хүч, хайр, эрүүл ухааны сүнсний өгсөн (2Тимот 1:7). Бид хүчгүйдэхээрээ ааш гаргаж, хашхичдаг. Бид өөртөө үйлчлээд ирэхээрээ бусдыг айлган сүрдүүлж, хянан захиргаадахыг хүсдэг. Төгс хайр айдсыг зайлуулахгүй үед бид хуучин руугаа эргэдэг. Бид өчигдрийнхөө асуудлыг өнөөдөр рүү авчрахаараа шаардлагагүй ааш гаргадаг.

Оюун санаагаа шинэчлэх үед муу дадал хэвшил эвдэрч, айдсын дарангуйлал тасрах. Юмсыг би хянаж чадахгүй. Би өөрийгөө хянаж болох ч, эцсийн дүнд Бурхан л бүгдийг хянан захирдаг.

Энэ үнэнд суралцсан хүн бусдад дуу хоолойгоо эрүүл сэтгэлгээгээр хүргэнэ.

*Эзэн минь, хяналтаа алдахгүйн төлөө тэмцэлдэж,
зөрчилдөх үед минь ядаж л хэл ам, дууныхаа өнгийг
хянахад туслаарай. Таны намуун, зөөлөн дуу хоолойд
мэдрэг байж, дагахад минь нигүүлсэн туслаарай.*

— Би хүчирхэг —

ТАЙВАН БӨГӨӨД ХҮЧ ЧАДАЛТАЙ
ЯРИХДАА, БИ ХҮЧИРХЭГ.

ХҮСЭЛ ТЭМҮҮЛЭЛ

Хэрэв чи сайныг үйлдвэл тэргүүнээ өргөх биш үү? Хэрэв чи сайныг хийхгүй бол гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой.

ЭХЛЭЛ 4:7

Манай соёл хүсэл тэмүүллийг юм л бол секстэй уялдуулдаг ч, энэ нь хавьгүй өргөн утга агуулгатай юм. Хүний мэдрэмжийн хайр, үзэн ядалт гэсэн хоёр туйлыг агуулдаг энэ ойлголтыг оноож тодорхойлох бэрх. Хүсэл тэмүүлэл нь сэтгэл мэдрэмж, идэвхи хүсэл, баяр хөөр, хүслэн, бишрэл, хайр, дурлалтай холбоотой. Эдгээрт шунадаггүй хүн байх уу? Гэтэл нөгөөтэйгүүр, энэ нь мөн биднийг урхи, дур, тачаалаар хүлэх үгстэй холбоотой. Бүр лавшруулбал: тэсрэх, хилэгнэх, уурлах, дургүйцэх, дүрэлзэх, жадлан эсэргүүцэх, догшрох зэрэг үгстэй ч холбоотой.

Хайр, үзэн ядалтын гэдэг хоёр туйлын хооронд яаж шатчихгүйгээр хүсэл тэмүүлэлтэй, гал халуун амьдрах вэ?

Хүсэл тэмүүлэл нь буруудсан анхны нэгэн түүхээс шипи авч болох юм: Энэ нь Эхлэл 4 дээрх Каин, Абел хоёрын түүх. Бурхан Абелын зүрхний өргөлийг хүлээж авчихаад, Каины дутуу сэтгэлийн өргөлөөс татгалзжээ. Тиймд Каин хилэгнэсэн. Бурхан Каиныг дүүдээ уурлахыг нь үзээд “ЭЗЭН, Каинд —Чи юунд уурлана вэ? Юуны учир уруу царайлна вэ? Хэрэв чи сайныг үйлдвэл тэргүүнээ өргөх биш үү? Хэрэв чи сайныг хийхгүй бол гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой.” (Эхлэл 4:6-7) хэмээн айлдруун.

Харамсалтай нь Каин Бурхантай эвлэрээгүй. Тэгээд нүглээ захирахын оронд уурандаа дийлдээд, дүүгээ алчихдаг.

Каинд айлдсан Бурханы анхааруулга бидэнд ч хамаатай. Тийм ээ, бид хүн алахгүй байж болох ч, “зөвийг үйлдэхгүй бол”, нүгэл үүдэн дээр гэтээд л байж байгаа. Бид сэтгэл мэдрэмжээ хяналтандаа аваад, дарж сөнөөх бус, бүтээн босгох ёстой.

Үнэндээ, хүсэл тэмүүлэл нь спектрумын аль туйл дээр байхаасаа үл хамааран, үнэ цэнэтэй хүчин зүйл мөн. Хүн хүсэл тэмүүллээр ханддаг зүйлээ өмгөөлөн хамгаалах үед хүсэл тэмүүлэл нь биеийн болоод сэтгэл санааны өндөр төвшинд өөрийгөө илэрхийлдэг. Хүн өөрт чухал юмандаа үлэмж хүслээр хандах. Аливаа зүйл нь бидний хувьд ач холбогдолгүй бол, бид хөл хөөрцөг болохгүй. Хүсэл тэмүүллийнхээ эрч хүчийг Каин шиг самууруулж орхилгүй, харин амь амьдрал руу цутгах сонголт нь бидний гарт. Сэтгэл санааны савалгаатай үедээ ч сонголт хийх хүч нь бидэнд бий. Хүсэл тэмүүллээ хянан захирч, амийн сонголт хийх эсэх нь биднээс л хамаарах.

*Аав аа, хүсэл тэмүүлээ сонсож, Танаар ариусгуулахыг
зааж өгөөч. Чухалчилж буй юмсаа Таны чухал
юмстай зэрэгцүүлж сурахад минь туслаач.*

Би хүчирхэг

ДУР ХҮСЭЛДЭЭ ТОЛГОЙ
МЭДҮҮЛЭЛГҮЙ, СЭТГЭЛЭЭ ЗАХИРЧ
ЧАДДАГ ТУЛ, БИ ХҮЧИРХЭГ.

ХҮНДЭТГЭЛ НЬ МАГТАН ДУУЛАХЫН НЭР БИШ

Дарсанд бүү согтуур. Эс бөгөөс хэт самуурал буй.

Харин Сүнсээр дүүр. Ингэхдээ дуулал, магтуу

ба сүнслэг дуунуудаар өөр хоорондоо ярилцаж,

Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохио.

ЕФЕС 5:18–19

Магтаал хүндэтгэл нь сүнсний сахилга батаас хавьгүй том зүйл буюу хүсэл тэмүүлэл, таашаал тэгээд Бурханд дурлах түлхүүр болой. Чи Бурханд зориулагдсан дууг сонсож дуулснаараа, Бурханд улам л ойртоно.

Өнөөдрийн эшлэл магтан хүндэтгэж байхдаа Сүнсээр дүүрэхийг ятгажээ. Бид чангаар дуулах юмуу зүрхэндээ дуулахдаа бялхдаг ч, энэ эшлэл бидэнд өөр нэгэн түлхүүрийг танилцуулж байна... Бурхантай тогтоох харилцаагаараа бусдад нөлөөх. Магтаал хүндэтгэл нь дуу дуулахын нэр биш юм. Хүн юугаар халина, түүгээ л амаараа асгадаг нь жам тул магтаал хүндэтгэлээр бидний дотор уудлагдах. Хүн хайртай хүнийхээ тухай зогсолтгүй ярьдаг. Хүнийг хайрлах үзэсгэлэнт мэдрэмжээ хүмүүстэй хуваалцахыг хүсэлгүй яхав.

Анд нөхдийн дунд барилдлага тогтоно. Хүмүүсийг холбодог нийтлэг хүсэл тэмүүлэл нь түүдгийн дэргэд илчинд нь ээгдэж, ер бусын сайхныг нь бишрэн зогсох найзуудын тойрог шиг. Энэ барилдлага биднийг нэг нэгнээ үнэн дотор босгон байгуулахад хүргэнэ. Тиймээс л хамтын хүндэтгэл нь маш хүчирхэг; чи анд нөхдийнхөө хүрээ дунд Бурханд хайраа илчилдэг.

Жинхэнэ нөхөд бие биеэ өргөж, Эзэнд таалагдах замаар амьдрахад нь уриалан дуудах. Найз нөхөд чинь Есүсийг дагахад, та бүхэн бүгдээрээ нэгэн зүгийг чиглэнэ. Чамтай сүнсээр ч, зорилгоор ч нэг хүмүүсээр л өөрийгөө хүрээлүүлээрэй. Та нар заавал бүх юманд дээр санаа нийлээд байх албагүй. Ердөө суралцах дуртай байж, нөхөрлөлөө хамгаалж явахад л хангалттай.

Харилцан ярихдаа ч, дуулахдаа ч итгэл нэгт нөхдийнхөө дунд ч Сүнсээр ч, хүндэтгэлээр ч дүүр.

*Эзэн минь, амьдралаас минь магтаал ч, үг ч
ундрах болтугай. Таны хайрын тухай ярихгүй л бол
болохгүй болтол минь хайраараа халиагаач.*

Би хүчирхэг

МАГТААЛ ХҮНДЭТГЭЛ
АМЬДРАЛЫГ МИНЬ БЭХЖҮҮЛДЭГ
УЧИР, БИ ХҮЧИРХЭГ.

СҮНСНИЙ ЭРХ МЭДЭЛ

*Учир нь Бурхан бидэнд айдсын бус, харин хүч,
хайр ба биеэ захирах сүнсийг өгсөн.*

2 ТИМОТ 1:7

Ариун Сүнс бидэнд эрх хүч, хайр, сахилга бат суулгадаг. Энэ гурван чанарын хольц нь хүчирхэг эмэгтэйг бүтээнэ. Сүнсний эдгээр бэлэг нь ажиллаагүй нөхцөлд хувь хүн бүрийн амьдралд суулгасан Бурханы бэлэг цэцэглэхгүй гэдэг нь эргэлзээгүй. Дээрх эшлэлийг өөр нэгэн хувилбар дээр “Учир нь Бурхан айдсын сүнсийг бус, харин хайрын бөгөөд саруул ухааны сүнсийг өгсөн” (2Тимот 1:7) гэдэг.

Бидний хамаг эрх хүч, хайр, саруул ухааныг айдас шиг хөнөөдөг зүйл үгүй. Тухай нь, айдас нь биднийг дээрх гурван чанарыг доош хийсэн асуултаар тамладаг. Эхлээд эрх хүчийг авч үзье. Үүнийг өөрөөр сүнсний эрх мэдэл гэж болно. Бидэнд өөрийн гэх бас өөрөөсөө төрүүлдэг “хувийн” эрх хүч гээд байх юм байхгүй. Бурхан Еден цэцэрлэг дотор Адам, Ева хоёрт эрх хүчийг соёрхсон боловч, тэд үүнээс нь татгалзсан. Ийнхүү Адамын дуулгаваргүй авираараа тавиад туучихсан зүйлийг Есүс дуулгавартай зангаараа эргүүлж авчирсан билээ. “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн.” (Матай 28:18).

Бидний эрх мэдэл ба эрх хүч нь Христийн дотор л бодит болно. Амьдрал маань Христийн дотор нууцлагдсан байхад, бид юунаас айх билээ?

2Тимот дээр Паул Есүсийн дагалдагч, үйлчлэгч залуу Тимотод амьдралдаа буй итгэлийнхээ бэлгийг хөгжөөн цэцэглүүлээрэй хэмээн зориг оруулсан. Учир нь өмнөх эшлэл дээрээ Паул түүнд “Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулъя.” (2Тимот 1:6) хэмээн сануулжээ.

Дээрээ гар тавиулсан эсэхээсээ үл хамааран, хүн болгон арчилж ургуулах ёстой, тодорхой хэмжээний итгэл хүлээж авсан. Шинэ гэрээнд итгэлийн талаар 300 гаруй удаа дурьдагдсан буй. Тухай нь, Еврей ном дээр тун анхаарал татмаар итгэлийн тунхаг бий: “Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурханд ойртон буй нь Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгчдад Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой.” (Еврей 11:6).

Бурхан байдагт дийлэнх маань итгэдэг атлаа Бурханыг үнэн голоосоо хайдаг хүнийг Бурхан шагнадаг гэдэг дээр л бүд үсэрчихээд байдаг. Айдас нь бидэн дундаасаа хамгийн хүчирхэг нэгнийг минь л буруушаалтаар цохих. *Чи хангалттай хийхгүй байна. Хангалттай эрх хүчтэй биш байна. Өөрөө ч хангалтгүй байна.* Харин үүнд нь бид Есүсийн ачаар Христийн дотор би төгс хангалттай болсон гэж л хариулах ёстой.

*Тэнгэрийн Аав минь ээ, надад Христийн дотор хайр,
эрх мэдэл, амар тайван, саруул ухаан дотор амьдарч
чадахыг минь сануулдаг Ариун Сүнсээ өгсөнд баярлалаа.*

Би хүчирхэг

ХРИСТИЙН АЧААР ЭРХ ХҮЧ,
ХАЙР, САРУУЛ УХААН ХҮЛЭЭЖ
АВСАН ТУЛ БИ ХҮЧИРХЭГ.

СҮНСНИЙ ДАГУУ ЗАЛБИР

Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. Үүний тулд хамаг ариун хүмүүсийн төлөө бүхий л цөхрөлтгүй оролдлого, гуйлтаараа сэргээг бай.

ЕФЕС 6:18

Сүнсний тулаанд залбирал хийгээд дуулгавартай чанар шиг чухал зэвсэг үгүй. Паул бидэнд тодорхой нэг нөхцөлд бус, харин бүх нөхцөлд Сүнс дотор залбир гэсэн. Сүнсний дагуу хэрхэн залбирах вэ? Нэг арга нь Бурханы Үгийг залбирах. Бичээсийг уншихдаа, тэндээс хэрэгцээтэй бүх төрлийн залбирлаа олно. “Тэнгэрт орших бидний Аав минь ээ...” нь өдөр тутамд сайн залбирал мөн боловч, амьдрал дээр бид эсэн бусын юмны төлөө залбирах ёстой болно. Гачигдсан хүмүүс, хямарсан улс үндэстэн, цэц ухаан, гэгээрэл шаардлагатай удирдагч нар. Найз нөхөд, гэр бүл, дайсныхаа төлөө ч залбирах хэрэгтэй болно.

Сүнс дотор залбирах өөр нэгэн арга нь залбирахдаа Ариун Сүнсний удирдамжийг сонсох. Заримдаа хэн нэгний төлөө залбирах хэрэгтэй ч юм шиг, хүнд хэцүү нөхцөлд ороод байгаа ч юм шиг санагдана. Тэдний төлөө залбир. Тэгээд яагаад залбирсан учраа хожим олж мэдэх нь олонтаа.

Залбирал нь албан бөгөөд албан бус гэж байна. Зогсоогоороо, суугаагаараа, хэвтээгээрээ, сөгдөөд ч залбирч болно. Хашхираа залбирал, зүрхний чимээгүй залбирал ч хэлж болно. Гол нь залбирал нь амьсгал шиг л аясаараа байх ёстой. “Бүх зүйлд талархалаа өргө.

Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс дэх Бурханы хүсэл мөн. Үргэлж баяртай бай. Тасралтгүй залбир.” (1Тесалоник 5:16-18).

Гэгээн Августин “Хамаг юм Бурханаас л шалтгаалах юм шиг залбирч, хамаг юм танаас л шалтгаалах юм шиг ажилла” гэсэн.

Бид залбирлынхаа дайтай л эрх хүчтэй байна. Хүчтэй эмэгтэй залбирлынхаа олсыг бөхлөхдөө анхаардаг. Би магтаал сонсонгоо залбирах дуртай. Түүнчлэн залбирлын тэмдэглэл хөтөлдөг бөгөөд энэ нь он жилүүдийн явцад Бурханы итгэмжтэй чанарыг гэрчлэх баталгаа болдог.

Бидэнд нүүрлэх тулааныг тэнгэрийн Аав минь урьдаас мэддэг учраас, тэсч үлдэх төдийгүй, ялж гарахад минь хэрэгцээтэй бүхнээр хангаж өгдөг. Дайсны довтолгоо дуусахгүй. Гэхдээ тэр ялахгүй.

Тэнгэрийн Аав минь ээ, амьсгалахтай адил аясаараа залбирахад сургаач. Ариун Сүнсний тань удирдамжинд баярлалаа.

Би хүчирхэг

ЗАЛБИРАЛ МИНЬ ХҮЧИРХЭГ
УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

Үзвэр дайган
готол
хуульчээг

ЦЭВЭР

*Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын
оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр
зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын
ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар
суу, сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь бүх цагаас
өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен.*

ИУДА 24-25

Бид мундагтаа бус, Бурхан л биднийг ариун байлгадаг. Эхлээд харахад цэвэр байдал нь ариун байдалтай нэг мэт санагддаг ч, үгүй юм. Ариун байдал нь ариунаар тусгаарлагдах гэсэн утгатай бол, цэвэр байдал нь ариунаар тусгаарлагдсан хүмүүсийн биеэ сахихтай хамааралтай асуудал юм. Цэвэр байдал нь ариун байдлын дайвар бүтээгдэхүүн мөн. Бид Бурханы амьд Үг дээр сүндэрлэсэн суурийг байгуулснаараа, биеэ авч явахад суралцдаг.

Бурхан бидний амь амьдралын ундарга байхыг хүсдэг. Зүрх зориг хүрч байвал, Бурханы нэвт исгэдэг Үгээр дамжуулан Ариун Сүнсээр зүрхээ шалгуул. Еврей 4:12-13:

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм. Түүний хараанаас нуугдах нэг ч бүтээл үгүй. Харин Түүний мэлмийн өмнө бүгд нүцгэн бөгөөд ил болой. Түүнд бид тооцоотой.

Чанга үг шүү. Бурханы Үг нь цаасан дээрх үсэг бус, харин амьд үг болой. Үнэнээр амьдрахуйг дагаж ургадаг жинхэнэ хүчийг хүсч байвал, Бурханы Үгд итгэж, Түүн рүү ойртоорой. Бурханы амьд Үг чиний зүрхэнд бүжиж, шөнийн харанхуйд чамд шивэгнэнэ. Бурханы Үг нь сэтгэл сүнснийг өвчих чадалтай хурц бөгөөд явцын дунд далд бодол хандлагыг илчилдэг.

Бурханаас юу ч нуугдахгүйг мэдээрэй. Бид харахгүй ч, Бурхан бүгдийг харна. Зүрх минь биднийг олонтаа мэхэлдэг ч, үнэнийг гуйваас, Бурхан Үгээрээ дамжуулан бидэнтэй Өөрийнхөө үзэл бодлыг хуваалцах. Бидэнд хүний зөвлөгөө хэрэггүй. Бид Бурханы цэц ухаан, гэгээрлийг л хүснэ. Хүний зөвлөгөө нь хэзээд энэ цагийн соёл, жишээний нөлөөнд автана. Үеийн үед нөгөө л нийгмийнхээ ёс суртахууны хэм хэмжээн дээр л дэнжигнэсээр байх нь мунхаглал. Бид чинь мөнхөд тогтнох Бурханы Үгийн жишгээр л амьдрах ёстой.

Анх харахад боломжгүй юмуу хийсвэр санагдмаар амлалт, үнэн Библи дээр олон чиг... үнэндээ тийм биш ээ. Үгийг хүлээж авах үедээ бид цэвэр байдал ч, ариун байдал ч боломжтойг харна. Учир нь ариун байдалд уриалсан Бурханы дуудлагын утга учир нь гүйцэтгэлдээ бус, харин Бурханы хүүхэд шиг амьдрахад л оршино.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны Үгийг амьдралдаа урьж байна. Та л намайг ариун болгож, ариун амьдрах боломжгүй гэдэг худлаас салгана. Хүмүүс намайг харахдаа, Хэний охин гэдгийг минь таньтал амьдармаар байна.

— Би хүчирхэг —

БУРХАНЫ ҮГ МИНИЙ АМЬДРАЛД
АМЬД БӨГӨӨД ИДЭВХИТЭЙ
УЧИР, БИ ХҮЧИРХЭГ!

ЗОРИУЛАГДСАН

Бурханы хардалтаар би та нарыг хардаж байна. Учир нь би та нарыг Христийн өмнө ариун онгон охин мэт аваачих гэж ганц нөхөртэй сүй тавиулсан. Могой, залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ дор [цэвэр] эгэл байдлаас чинь та нарын санаа бодлыг төөрүүлчих вий гэхээс би харин айж байна.

2 КОРИНТ 11:2-3

Миний бие хөгшин залуу, гэрлэсэн гэрлээгүй бүсгүй хүн болгон цэвэр байдал ноёрхсон, хүчирхэг амьдрал анхилуулж яваасай хэмээн хүсэх. Цэвэр байдал гэхээр л Чуулган ихэвчлэн бэлгийн сонголт, үйлдэлтэй холбож сэтгэдэг ч, өнөөдрийн эшлэл дээр цэвэр байдлыг “Христэд цэврээр зориулагдах” явдал болохыг хэлжээ. Цэвэр байдал нь хүний оюунаас л эхэлнэ. Түүнчлэн бид мэхлэгчийн хөтөлгөөнд орохгүйн тулд цэвэр байдлынхаа төлөө тулалддаг. Өөрөөр хэлбэл, үнэний Үгийг эрэлхийлэн, үнэн худлыг ялгаж салгуулахын төлөө Ариун Сүнсийг зүрхэндээ урьдаг.

Өнөөдрийн эшлэл дээр Паул “Христэд бүрэн зориулагдах замаасаа төөрөлдөх боломжтойг” өгүүлрүүн. Хэний үгийг сонсохоо хүн өөрөө сонгоно: Аврагчийнхаа Үгийг сонсох уу, амийг минь агнагч өдөөгчийн үгийг сонсох уу. Бурханы Үг л туйлын эрх мэдэл болой. Бурханаас гуйх аваас, Тэрбээр чиний амьдрал дахь бүхий л худал хуурмагийг Сүнснийхээ илдээр цавчина.

Тодорхой нэгэн нөхцөл дор хүчтэйхэн шиг дарах үед хүн дотроо ялж чадаагүй алив тулаандаа бууж өгнө. Тиймээс оюун бодлоо цэвэрлэхээс л эхэл. Бодол бүрээ олзлоод, Христэд захируулах аваас

(2Коринт 10:5), амьдралын маань хэсэг болгон руу цэвэр байдал урсан орж ирнэ.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Та - хамаг цэвэр байдал, ариун байдлын үндэс мөн. Би Таных бөгөөд Таны Үгд бүрэн захирагдаж, Үгийн хүндэтгэл, эрх дарх, эрх мэдлийг амьдралынхаа хэсэг бүр дээр залж байна. Таны Үгийн илд миний доторх бурханлаг бус, эрүүл бус холбоо нэг бүрийг тасалж, дотор гадаргүй цэвэрлэх болтугай.

Би хүчирхэг

ЦЭВЭР БАЙДЛЫГ ЭРДЭНЭ
МЭТ ЭРЭЛХИЙЛЖ, ХРИСТИЙН
ОХЬ МЭТ ҮГЭЭС ХҮЧЭЭ
АВДАГ ТУЛ БИ ХҮЧИРХЭГ.

ҮЗЭМЖ

Гэвч ЭЗЭН, Самуелд айлдан —Түүний гаднах байдлыг болон нурууных нь өндрийг бүү хар. Би түүнийг нь үл хэрэгсэв. Учир нь Бурхан мөхөс нэгэнтэй адил хүний гаднах төрхийг хардаггүй. ЭЗЭН зүрхийг нь хардаг гэв.

1 САМУЕЛ 16:7

Энэ эшлэлийг үзээд, Бурхан зүрхийг хардаг болохоор, үзэмж падгүй хэмээж магадгүй. Тэгэхээр, тэнгэр бидний зүрхийг хардаг байж болох ч, бид чинь одоохондоо газар дээр амьдран суугаа бөгөөд газар дээр хүн бүр гадаад төрхийг л үзэж, үзсэнээрээ л хөдөлдөг.

Тиймээс өөрийнхөө баглаа боодолд анхаарч явахыг анхааруулдаг. Үзэмж нь хоосон найдвар тул үзэмжинд найдах нь мунхаглал гэдэг. Гэхдээ найдахгүй гээд орхигдуулж бас болохгүй.

Хүн үнэндээ санаатай байна уу, санаандгүй байна уу - байдал үйлдлээрээ заавал нэгийг хэлж явдаг. Мессеж маань дараах гурван сувгийн аль нэгээр нь дамжина: яриагаараа (үг, дууныхаа өнгөөр), үйлдлээрээ (зан авир, үйлсээрээ) үзэмжээрээ (биеэ авч явах байдал, өөрийгөө танилцуулж буй байдал). Хүмүүс ч сонссоноороо бус, харснаараа нөлөөлөгдөх нь олонтаа.

Үүнийг ойлгосон хүн давуу тал болгон, санаагаа илүү үр нөлөөтэй дамжуулж чадна. “Хосгүй сэтгэгдэл үлдээх хоёр дахь боломж байдаггүй” гэдэг санаа бүхий хуучны онч мэргэн үг олон бий. Хуучны энэ үгийн санаа нь хөдлөшгүй үнэн. Өөрийгөө илэрхийлэх сонголт олон ч, чухам юу илэрхийлэх вэ?

Чиний хувцаслалт бусдад шуурхай мессеж илгээгээд зогсохгүй,

хэлье гэж бодоогүй зүйлийг чинь ч илэрхийлэх боломжтой. Өөрийнхөө талаар бодож, итгэж явдгаас чинь эсвэл үлгэр жишээ авдаг зүйлээс чинь тэс өөр санааг ч илэрхийлж болох. Тэгээд мэдээж хэний охин болохыг чинь ч буруугаар таниулж чадна.

Би чамд загварын зөвлөгөө өгөхгүй. Учир нь “Би яг одоо өөрийгөө хэрхэн таниулж байна? Ямар мессеж дамжуулж байна? Яг жинхэнэ өөрийгөө тусгаж байна уу эсвэл зүгээр л дүр эсгэж, зарлалын самбар шиг амьдарч байна уу?” гэдэг асуултад чи өөрөө л хариулна.

Тэгэхээр, чиний хувцаслалт, гадаад төрх яг жинхэнэ чамайг тусгаж байна гэж бодъё. Чи “Би мэргэжлийн хүн бөгөөд би албан ёсны хувцасласан” гэж хэлж болох. Эсвэл чи оюутан болохоороо оюутан шиг л хувцаслаж байна гэж бодож байж болох. Тэгвэл жаахан ухаж үзье. Чиний хувцасны хэв маяг бусдад хэрхэн нөлөөлж байгаа бол? Хүмүүс чамайг харж байгаа болов уу эвсэл хувцсыг чинь л харж байгаа болов уу? Хүмүүс чамаас яг юу харж байгаа бол?

Үзэмжинд найдалтгүй хэдий ч, харилцааны энэ хэлбэрийг үг, үйлдэлтэй л адил бурханлагаар бөгөөд мэргэнээр ашиглах боломжтой.

*Эзэн минь, харилцааныхаа хэлбэр бүр дээр, тэр тусмаа
өөрийгөө танилцуулах тал дээрээ мэргэн байхыг
зааж өгөөч. Үзэмжээрээ яг юу хэлээд байгааг минь
илчилж өгөөч. Таны алдрын төлөө байх болтугай.*

— Би хүчирхэг —

БИ ГАДНАА Ч, ДОТРОО Ч БУРХАНД
ҮНЭНЧ УЧИР, ХҮЧИРХЭГ.

УРНААР ШАГЛАГДСАН

*Эхийн хэвлийд чамайг бүрэлдүүлэхээсээ өмнө Би чамайг
мэдэж байсан. Төрөхөөс чинь өмнө Би чамайг ариусгаж,
Үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон чамайг томилсон...*

ИЕРЕМИА 1:5

Бурхан бидний мэдээлэлд аминчлан оролцдог. Ээж минь биднийг мэдрээ ч үгүй байхад түүний умайд Бурхан биднийг шаглаж эхэлжээ. Өөрийгөө мэдрээ ч үгүй байхад минь... Бурхан биднийг мэдэж байсан. Биднийг нууцаар бойжиж байхад, Бурхан бидний амьдралын өдөр хоногийг төлөвлөж, туулах тавилангийн минь замыг тавьж өгчээ. Чи санамсаргүй нийлсэн эс биш; Бурханы бодон байж амьдруулсан санаа болой.

Мэндэлж буй хүүхэд болгон нь бидний хайр халамжинд даалгагдсан найдварын бэлэг болой. Чи хүн мэндэлхийн гайхамшгийг үзсэн бол, нярай болгон гайхамшигт хүчин чадлаар өлгийлүүлж төрдийг мэдэх байх.

Би гурав дахь хүүгээ гэдсэндээ хөдлөх үед нь л бие давхар болсноо мэдэж билээ. Жон Нью Йоркийн Рочестерт үйлчилж байсан бөгөөд хүндэтгэлийн цуглааны үеэр миний бие нэг л сульдаад, толгой дайвалзаад байхаар нь би суув. Тэгтэл Ариун Сүнс “Чиний дотор амь байна... Чиний дотор хүү өсч байна.” гэв. Тэр үед би Бурханы ер бусын оршихуйг мэдэрч билээ. Энэ бол Бурхан эхийнхээ умайд бойжиж буй ургийг хичнээн аминчилж үздэгийн нэгэн жишээ.

Гэхдээ чи хэзээ ч ийм үг сонсож яваагүй бол, яах уу? Чамайг Бүтээгчийнхээ оюунд тийм уран яруугаар урлагдсаныг хэн ч хэлээгүй бол, яах уу? Харин ч алдаа, бүтэлгүйтлээрээ дуудуулж өссөн бол, яах уу? Ямар гайхамшигтай бүтээгдсэнээ ухаараагүй хүн бусдын гайхмшигийг ч ухаарахгүй. Өөрөө алдаанд тооцогдож өссөн хүн өөр хүүхдийг ч алдаанд тооцно.

Капиталист энэ нийгэм эх хүний эрх үүргийг үнэгүйдүүлсэн учраас, эмэгтэйчүүд ажил мэргэжил, ээжийн үүрэг, бас бус нэмэлт үүргээ зохицуулах гэж зүдэрсээр. Амьдрал нь олон талаараа цагийн шалгалт юм. Ажилтай эмэгтэй хүн ажиллангаа ээжийнхээ эрх үүргийг эдлэх хэцүү. Миний хувьд, бүх ололт амжилт дундаас минь хөвгүүд минь л надад хамгийн том аз жаргал, боломжийг авчирсан гэж хэлнэ. Чи ээж баймаар байгаа бол, ичих хэрэггүй. Энэ эрх үүрэг санаснаас чинь ч ихийг шаардаж магадгүй. Гэхдээ эргүүлээд санаснаас ч ихийг өгнө.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Амь төрүүлэгч нь
Та. Та намайг урнаар шаглан, амьдралын минь
өдрүүдийг инээмсэглэн байж, төлөвлөсөн гэдэгт
итгэж байна. Үр хүүхэд - Таны бэлэг учраас, Та
ийм л сурвалжит үүргийг ээж хүнд даалгажээ.*

Би хүчирхэг

БИ ТҮҮНИЙ ТӨЛӨӨ ТҮҮГЭЭР
БҮТЭЭГДСЭНДЭЭ, ХҮЧИРХЭГ.

СЭТГЭЛИЙН ХОЛБОО

*Намайг газар дээр энх тайвныг авчрахаар ирсэн гэж бүү
бод. Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм.*

МАТАЙ 10:34

Есүс биднийг Өөрөөс нь хорьж байгаа бүхнээс чөлөөлөхийг хүснэ. Сүнсний тулаан нь Есүстэй харилцахад саад бологч алив шүтээн, саадтай нүүр тулах үйлдэл юм.

Бид аль ч талаараа боолчогдсон бай, үүнийг шийдвэрлэх боломжтой гэдэгт би итгэдэг. Есүс гинжийг үзэхдээ, тасар татсан. Есүс чөтгөрийг үзэхдээ, хөөсөн. Есүс өвдөж зовсон хүмүүсийг үзэхдээ, эдгээсэн. Нүгэлдээ боолчлуулсан хүнийг үзэхдээ, уучлаад, дахиад нүгэл хийхгүй байх хүчийг өгсөн. Есүсийн үйлдэл ийм л ач холбогдолтой, бодитой, практик байсан.

Миний хувьд, нэгэнтээ нэгэн төрлийн эрүүл бус сэтгэлийн холбооноос болж ихээхэн хохирч яваа тул үүнийг таслах шаардлагатай гэдгийг ухаарч билээ. Сэтгэлийн холбоо гэж юугаа яриад байна? Энэ нэршлээр бидний сэтгэл өөр нэгэн сэтгэлтэй холбогдохыг л нэрлэсэн хэрэг. Энэ нь сайн ч байж болно, муу ч байж болно. Эх хүн үртэйгээ сэтгэлээрээ холбоотой. Гэхдээ үр нь өсч бойжоод, эрийн цээнд хүрэх үедээ сэтгэлээ гэргийдээ өгөхийн тулд эх - хүүгийн харилцаа өөрчлөгдөх ёстой. Эр нөхөр, сүйт бүсгүй хоёрын бие нэг болохын тулд хоёр сэтгэл ч нийлэх ёстой. Эдгээр нь хүмүүн бидний сэтгэлийг хайраар нэгтгэж байдаг эрүүл бөгөөд сайн холбоо юм. Ийм эрүүл холбоо нь Давид, Ионатан хоёрынх шиг анд нөхдийн

барилдлага болж бэхжих ч боломжтой. Тухай нь эгч дүүс, дотно найзын холбоо байна. Энэ мэтчилэн тайлбарлах ч шаардлагагүй харилцаа олон бий.

Гэтэл эрүүл бус холбоонд нөхөрлөл, нэгдэл бус, айдас, захиргаадалт оршино. Ийм холбоо нь ёс бус бэлгийн харилцаа, эрүүл бус хамаарал юмуу зүй бус, хүчирхийлэлтэй харилцаанаас үүдэн бий болж болно. Эрүүл бус сэтгэлийн холбоо нь эцсийн дүндээ биднийг эрэмдэглэдэг. Бид өөрийнхөө хүчээр зугтах гэж оролддог л доо. Гэхдээ хүлээсээ Эзэний илдээр таслуулсан нь хавьгүй үр дүнтэй байдгийг би одоо мэднэ. Эрэмдэг зэрэмдэг хэсгийг минь гагцхүү Бурхан л бүрэн бүтэн болгож сэргээнэ.

Бидний Тэргүүн тахилч биднийг аминчлан мэддэг. Биднийг Түүнээс хорьж байгаа алив бүхнийг Тэр илдээрээ тасдана. Эрүүл хэсгийг нь авч үлдэхийн төлөө эрүүл бус сэтгэлийн холбоо бүрийг тасдана. Тэгээд Үгээрээ сэтгэлийг чинь эдгээж сэргээнэ. Бурханаар амьдралаа цэвэрлүүлэхийн төлөө тусгайлан залбир. Чиний амьдралд эрүүл бус сэтгэлийн холбоо байгаа эсэхийг Ариун Сүнснээс асуугаад, дараа нь Бурханы Үгээр таслуул. Амлагч нь итгэмжит.

Эзэн минь, амьдралд минь байгаа эрүүл бус бүх холбоог илчлээд, Ариун Сүнснийхээ хүчээр таслаач. Сэтгэлийг минь эдгээж сэргээгээч. Амьдралд минь байгаа сайн холбоог тордож, эрүүл байлгахыг зааж өгөөч.

— Би хүчирхэг —

СЭТГЭЛЭЭ ҮНЭНТЭЙ ХОЛБОСОН
УЧИР, БИ ХҮЧИРХЭГ.

ХАРУУСЛЫГ ЭДГЭЭХҮЙ

*Учир нь Та гэдэс дотрыг минь хэлбэржүүлж эхийн минь хэвлийд
намайг бүрдүүлжээ. Би аймишгтай болоод гайхамшигтай
бүтээгдсэн тул Танд талархал өргөнө. Таны үйлс гайхалтай
бөгөөд сэтгэл минь ч сайн мэднэ. Аяа Бурхан, надад хандсан
бодлууд тань хичнээн нандин бэ! Нийлбэр нь хичнээн их вэ!
Төрхөө олоогүй хөврөл байхад минь Таны нүд харж л байсан.
Надад тогтоогдсон өдрүүд болоогүй байхад бүгд номд тань
бичигдсэн байжээ. Намайг нууц дотор бүрэлдэж, газрын гүнд
урнаар шаглагдаж байхад ч яс минь Танаас нууцлагдаагүй.*

ДУУЛАЛ 139:13-17

Давид энд эхийнхээ умайд ургах амийг тун уран нарийн
найраглан өгүүлрүүн. Гэхдээ чи үр хөндөлтийн аймшгийг
үзсэн бол, яах уу? Тийм бол, би чамд эдгэрлийг өгүүлмээр байна.
Чи худалд итгэсэн, айдаст автсан бүсгүй юмуу ач зээгээ алдахын
айшгийг үзсэн эмээ байж болох. Юу ч байлаа гэсэн, Бурхан Аав
маань: Чи уучлагдсан, нөгөө талд чамайг амьдрал хүлээж байна”
гэж байна.

Үр хөндөлтийг нээлттэй гашуудах нь ховор. Бяцхан амьтны
амийг тэрүүхэнд нь далдуур янзалчихдаг. Гагцхүү бүх юм болоод
өнгөрсөн хойно л ичгүүрийн ял аав, ээж тэргүүтэй гар бие оролцсон
хүн бүрийг нь нөмрөх.

Бидний хачин амиа нийгэмд аж төрж байна. Хувь хүний аминч
үзэлд дийлдсэн болохоороо, хэзээ ч хүнд сайн сайхнаар амьдрах хүч

өгөхгүй. Хажуугаар нь гэрлээгүй атлаа жирэмсэлсэн эмэгтэйчүүдэд хатуурхаж, шүүдэг чуулгануудын зовлон их байна. Би саяхан чуулганы зүгээс ирэх шүүмжийг давж гарах зориг хүрээгүйдээ үр хөндөлт хийлгэсэн таван итгэгч эмэгтэйн хоёртой нь ярилцлага хийж билээ. Үр хөндөлтийн талаар нийгэм тэс өөрөөр зөвлөдөг:

“Өө, чи залуу байна, гоё байна... хамаг амьдрал чинь өмнө чинь байна. Хэзээ нэгэн өдөр чи мундаг ээж болно. Гэхдээ одоо цаг нь биш. Бэлэн болохоороо хүүхэд төрүүлнэ. Хүсээгүй хүүхдийг төрүүлж болохгүй. Хүн хүсэн хүлээсэн хүүхдээ л төрүүлэх ёстой.”

Яг ийм зөвлөгөөг дагалдан баясаад, хожим нь насаараа харууссан хөгшин залуу олон эмэгтэйн яриаг сонсож явсан би. Тэд эмнэлэгт хоёр бие бүтэн ороод, нэг нь үхээд, нөгөө нь гэмтээд ганцаараа гарч ирдэг. Есүсийн хайр өршөөлийг үзсэн бид үр хөндөлтийн эмнэлгээс илүү дэмтэй байх ёсгүй гэж үү? Pro-life (про-лайф) нь зүгээр нэг хөдөлгөөн биш, харин үр хөндөлт зэрэг эрс тэс үйлдлийг дэмжсэн амьдралын хэв маяг юм.

Харууслаа харууслаа гээд, буцаж очоод өнгөрснийг өөрчлөхгүйгээс хойш. Урагшаа харах нь л бидний найдвар. Бурханы уучлал, үнэнийг л тэвэрч ав. Үр хөндөлт хийлгэсэн бол, өөрийгөө уучлаад эдгэрлийг эхлүүл.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, шүүхийн бус эдгэрлийн зэмсэг байхад минь туслаач. Хүний амь ямар үнэт, үзэсгэлэнтэй болохыг Таны нүдээр харж ойлгоход минь туслаач.

— Би хүчирхэг —

ХАРУУСАЛ ИЧГҮҮРИЙГ БУС,
АМЬ НАЙДВАРЫГ СОНГОЖ
БУЙ БИ ХҮЧИРХЭГ.

ГЭРЛЭЛТИЙГ ХҮНДЭТГЭХҮЙ

Гэрлэлтийг бүгд хүндлэгтүн. Ор дэр нь ч бүү бузартаг. Учир нь янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ.

ЕВРЕЙ 13:4

Эхлээд хүндэтгэл гэдэг үгийг ойлгож байж л энэ эшлэлийг ойлгох. Бид нилээд үнэ цэнэ, жин өгдөг хүнээ юмуу зүйлээ л хүндэтгэдэг. Тухай нь, би эр нөхрөө хүндэтгэдэг учраас, хүндэтгэлтэй харилцаж, түүний эсрэг биш, түүнтэй гар нийлж ажилладаг. Нөгөөтэйгүүр, хүн хүндэтгэдэггүй хүнээ эсвэл юмаа огт хайхралгүй, хаа хамаагүй ханддаг. Гэрлэлтийн тал дээр хүндэтгэлийн зарчмыг мэддэггүй нөхөр, эхнэр хоёр бие биеэ үл хүндэтгэнэ. Еврей ном дээр “гэрлэлтийн ор дэрээ” буюу дотнослын газраа хүндэтгэхийг тусгайлан өгүүлжээ.

Бид гэрлэхээсээ өмнө биеэ цэврээр хадгалснаараа гэрлэлтээ хүндэтгэдэг. Гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаа нь гэрлэлтийн гэрээг, гэрээнд хамаарал бүхий хүмүүсийг тэгээд мэдээж Бурханыг үл хүндэтгэсэн хэрэг. Эсрэгээрээ, гэрлэлтийн гэрээндээ багтсан бэлгийн харилцаа нь Бурханыг ч, хань ижлээ ч, гэрлэлтээ ч хүндэтгэсэн хэрэг юм. Гэрлэлтээ хүндэтгэх өөр нэгэн арга зам нь дотнослын газартаа өөр хүнийг юмуу юмыг хэзээ ч нэвтрүүлэхгүй байх. Энэ нь зөвхөн та хоёрын үзэсгэлэнт нэгдлээс сарниах зүйлд оролцохгүй байх гэсэн үг. Тодруулбал, порно, гар хангалга, завхрал, янхандах, цэвэр бус байдал.

Миний бие гэрлэхээсээ өмнө эдгээр үнэнээр амьдраагүй учраас,

гэрлэсэн хойноо олон олон харанхуйтай нүүр тулах шаардлагатай болж билээ. Өөрийгөө эр нөхөртөө эрх дураараа зориулах ёстой байтал, өнгөрсөн амьдралынхаа сонголтонд хүлэгддэг байлаа.

Бэлгийн дотносол нь гэрлэлтийн гэрээгээр дамжин нэгэн цул болсон хоёр хүнд л хадгалагдсан зүйл учраас, бид бэлгийн харилцаагаар нэг хүнтэй л нэгдэхээр бүтээгдсэн буюу. Хүн дотно ганц хүнтэйгээ л биеэрээ дотносох ёстой. Биеэрээ олон хүнтэй дотносох нь дотно хүнээ үл хүндэтгэсэн явдал болно.

Манай нийгэмд завхайрал бүх талаараа задгайрсан нь үл хүндэтгэлтэй л холбоотой гэдэгт итгэлтэй байна. Гэрээг ойлгодоггүй хүмүүс гэрлэлтийг хуудас цаас л гэж үздэг. Гэрлэлт нь зүгээр нэг хоёр хүн нийлж байгаа явдал биш, харин Бурхан тэднийг нийлүүлж буй үйл хэрэг болой. Гэрлэлт нь хоёрыг бус, гурван хүнийг багтаагаад ирэхээрээ л... хуудас цаас болдог.

Бурханы Үгийг хүндэтгэхүй нь гэрлэлтэд хүч, гэрээ, дотнослыг авчирна. Бурхан сэглэсэн зүйлийг сэргээн засварлаж, үл хүндэтгэснийг нь эдгээж байна.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, гэрлэлтийг хүндэтгэхийг
зааж өгөөч. Ариун Сүнс ээ, гэрлэлтийн минь амьдрал,
гэрлэлтийнхээ амьдралд хандах үзэл бодолд минь гэж
буруу хандлага, үл хүндэтгэл байвал, илчилж өгөөч. (Энэ
залбирлыг заавал гэр бүлтэй хүн бус, ганц бие хүн ч залбирч
болно.) Би дотнослын гэрээгээ хүндэтгэхийг хүснэ.*

— Би хүчирхэг —

БИ ГЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭГЭЭ
ЗӨРЧИЛГҮЙ, ДОТНОСЛЫН
ГЭРЭЭГЭЭ САХИН
ХАМГААЛАХДАА, ХҮЧИРХЭГ.

ХАМГААЛАГДСАН

*ЭЗЭН бол миний хад, миний цайз, миний аврагч,
миний Бурхан, миний хоргодох хад, миний бамбай,
миний авралын эвэр, миний бэхлэлт юм.*

ДУУЛАЛ 18:2

Хамаг бие минь салганасаар. Пастор намайг охидын бүлэгт биеэ цэврээр сахих талаар үг хуваалцахыг даалгах үед би барьц алдав. Юугаа ярихаа мэдэхгүйгээс гадна жигтэйхэн айх нь тэр. Яах нь энэ вэ? Олон жил дэлхийгээр аялж, нас насны танхим дүүрэн эмэгтэйчүүдэд номлож яваа хүн шүү дээ. Гэтэл хотынхоо өсвөр насны охидын бүлэгт ярихаасаа юундаа ингэтэл айгаа вэ? Гүн амьсгаа авлаа. Тайвшрах хэрэгтэй. Тэгээд ч нөхөр минь залуусын цуглаанд үйлчилж явсан хүн. Би тэр үеийг туулаад л гарсан. Тэгж байтал би үнэндээ сонсогчдоосоо бус, ярианыхаа сэдвээс болж тэгтэл балмагдсанаа ойлгов. Хөвгүүдтэй үерхэж байхдаа яаж болох, яаж болохгүйг охид надаас заалттай асуухыг би зоолттой мэдэж байлаа.

Сургуулийн өсвөр насны охидод “хязгаарын” талаар юугаа ярих билээ? Би охингүй хүн. Дээрээс нь бэлтгэх цаг ч хомс.

Тэгээд шалан дээрээ сөгдөөд залбирлаа: *Аав аа, тэр охидод өгөх хариулт хэрэгтэй байна. Өөрийнхөө юмуу өрөөлийн үзэл бодлыг бус, Таны л цэц ухааныг хэлмээр байна. Надад хурдхан хариулаач.*

Тэгээд хүлээлээ. Таг. Шалан дээрээс босоод шүршүүрт орохоор явлаа. Маргааш заана. Элдвийг бодон шүршүүрт зогстол, Ариун Сүнс ярив: “Чи тэдэнд зан үйлдлийн дүрэм зааж өгөх гээд байна. Дүрэм нэмэргүй. Хүч нь харилцаанаас төрөх ёстой. “Болохгүй” юмсыг заахын оронд “болох” юмсыг зааж өг. Хөвгүүдтэй хамт

байхдаа төрсөн аавынхаа нүдэн дээр хийж чадах зүйлсээ л хийж байхыг хэлж өг!”

Бурхан ингэж хариулав. Аав хүн охин үрийнхээ нандин чанарын сахиул байх ёстой. Гэхдээ чамд сахиул байгаагүй байж болох. Аавгүй өссөн ч юмуу. Тийм байлаа ч, чамд одоо тэнгэрийн Аав бий. Тэр чамайг хэн нэгний гарын шүүс, золиос болгохыг хэзээ ч хүсэхгүй. Эсвэл чи энэ бүхнийг хэдийнээ үзсэн байж мэдэх. Тэгвэл өнгөрсөн чинь ямар байснаас үл хамааран, Бурхан чиний ирээдүйг сахиж байна. Энэ хариулт өсвөр насны охидод төдийгүй, цэвэр бус соёл дунд цэврээр амьдрах гэж тэмцэлдэж яваа бүсгүй хүн бүрт хамаатай.

Дүрэм журам хүний зүрхийг өөрчилдөггүй. Бид үүнээс өндөр зарлигаар амьдардаг улс. Бид хайраар амьдардаг улс. Тэнгэрийн Аавтайгаа тогтоох харилцаагаар амьдардаг улс. Хүйтэн чулуун дээр зорогдсон хязгаар, ёс суртахуун, ёс зүйн коодоор бус, харин зүрхэнд минь тамгалагдсан амьд үнэнээр амьдардаг улс. Бид итгэлийг “болно, болохгүйн” жагсаалт болгох үедээ бидэнд хамгийн сайн сайхныг хүсдэг Нэгэнтэй тогтоох харилцаагаа алддаг.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, би Танд хайртай учраас
л цэвэр амьдармаар байна. Өнгөрсөн амьдрал минь
дүүрсэн ч, би Таныг амьдралынхаа хамгийн нарийн нандин
хэсэг бүрийг сахин хамгаалуулахаар урьж байна.*

Би хүчирхэг

БИ ДҮРЭМ ЖУРАМ САХИДАГТАА
БУС, ХАРИН ААВДАА ХАЙРТАЙ
УЧРААС, ХҮЧИРХЭГ.

СҮЙТ БҮСГҮЙ

*Залуу хүн онгон охинтой гэрлэдэг шиг хөвгүүд
чинь чамтай гэрлэнэ. Сүйт залуу сүйт бүсгүйдээ
баярладаг шиг Бурхан чинь чамд баярлана.*

ИСАИА 62:5

Бурхан биднийг Сүйт бүсгүйгээр зүйрлэсэн нь гоё. Саяхан миний хоёр хүү гэрлэлээ. Эхний эгнээнд суугаад харж байхад, хөвгүүд маань хоёулаа айсуй сүйт бүсгүйгээ хараад уйлчихаж билээ. Цагаанаар цацарсан, биширмээр сүйт бүсгүйчүүд. Есүс биднийг ингэж л хардаг болов уу. Илчлэл 19:7 дээр “сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв.” гэдэг.

Хэрхэн ингэх вэ? Үүнд хариулахын тулд жаахан лавшруулж үзье. Сүйт бүсгүй өөрийгөө сүйт хархүүдээ хэрхэн бэлтгэдэг вэ? Энэ нь гоё сайхан даашинз, үс, будалтаас давсан, зүрхэнд өрнөдөг бэлтгэл юм. Доор би өөрийнхөө бодлыг бичлээ. Болгооно уу:

- Сүйт бүсгүй сүйт хархүүдээ бүх талаараа таалагдахыг хүснэ.
- Сүйт бүсгүй үйлс бүхэндээ цэвэр бөгөөд гал халуун байхыг хүснэ.
- Сүйт бүсгүй өөрийнх нь үгээр илэрхийлж чадахгүй гүн хэсгийг ч ойлгодог байгаасай гэж хүснэ.
- Сүйт бүсгүй хамгийн эмзэг нандин хэсгээ ч бүрэн зориулж байгаа учраас, аюулгүй байдал, хамгаалалтыг хүснэ.
- Сүйт бүсгүй өөрийгөө айдасгүйгээр илэрхийлэх эрх чөлөөнд хайртай.
- Сүйт бүсгүй гэнэтийн, ер бусын бэлэгт дуртай.
- Сүйт бүсгүй сүйт хархүүтэйгээ нууцаа хуваалцах дуртай.

- Сүйт бүсгүй хайртаараа араасаа гүйлгүүлж, хайртынхаа араас гүйх дуртай.
- Сүйт бүсгүй хүнд хамааралтай байхын сайханд дуртай.
- Сүйт бүсгүй тордуулж, хамгаалуулж, чиглүүлэг авч мөн зөөлнөөр засуулах дуртай.
- Сүйт бүсгүй эр нөхрөө гал халуунаар хайрлах дуртай.

Ийм хүсэл Бурханы охин болгоны зүрхэнд бадарч явдаг байх аа. Бурхан биднийг хэн байлгахаар бүтээсэн - түүнийх нь дагуу тултал амьдрахыг үнэн голоосоо хүсдэг учраас, ийм хүслийг зүрхэндээ өрдөхөд буруугүй. Бидний Сүйт хархүү Есүс “Би чамайг хайрлая!” гэдэг.

Хэн ч биднийг ингэж хайрлахгүй. Ийм гүн санаашрлыг газрын хүн гүйцэт биелүүлж чадахгүй. Бидний хүслэн болсон хайрыг хангаж чадах газрын хайр байхгүй. Тэнгэрийн Ханхүү чинь л чамайг гомдоохгүй, гонсойлгохгүй. Тэр л чиний гүн гүнзгий хүсэл санаашралын эзэн бөгөөд Тэр л түүнийг чинь хангаж чадна.

Тэр л чиний бүх хэрэгцээг хангасан. Тиймээс яагаад Түүний зөвтгөлөөр өөрийгөө өлгийдэхгүй гэж? Түүгээр л өөрийгөө бишрүүл. Түүний тэвэрт амарч, Түүний өмнө л зүрхээ бүжүүл.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, намайг Таны бүтээсэн
тэр нэгэн болж хувиртал минь хайрлаач. Би Таны
л сүйт бүсгүй байж, Тандаа л өөрийгөө бэлтгэе.
Намайг зүрхэндээ тамгалаач. Таны хүслийг дагах
зам минь Танд инээмсэглэл авчрах болтугай.*

— Би хүчирхэг —

НАМАЙГ ХАРААД БАЯРЛАДАГ
СҮЙТ ХАРХҮҮТЭЙ УЧРААС,
БИ ХҮЧИРХЭГ.

Үнэн
дотоо
хүчирхэг

ЦЭЦЭН ҮГТЭЙ

Тааламжит үгс зөгийн балтай сархинаг

мэт. Сэтгэлд бурам, ясанд эм буюу.

СУРГААЛТ ҮГС 16:24

Элч Иохан анд Гаидаа ийн бичжээ: “Хайрт минь, сэтгэл чинь сайн сайхан буйн адил бүх зүйл чинь сайн сайхан, эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна (3Иохан 1:2).

Хүний эрүүл мэнд сэтгэлтэйгээ нягт холбоотойг Иохан мэдэж байжээ. Энэ хоёрыг салгах арга үгүй. Нягт нарийн холбоотой. Хэдийгээр үг хүний биеийг шууд утгаараа гэмтээдэггүй ч, үгийг хөнөөгч зэвсэгтэй бас эдгээгч тостой зүйрлэдэг. “Бодлогогүй яриа нь илдээр дүрэх мэт. Харин мэргэн хүний хэл илааршлыг авчрах” (Сургаалт үгс 12:18).

Биднийг чиглүүлсэн хилэнт, хурц үгс нь яг л илдээр дүрэхтэй ижил. Халдагч мөр рүү, гэдэс рүү, гарын булчин руу лүг лүг дүрчихээд, өөрөө арилаад өгнө. Бид ч юу болсныг ойлгож амжилгүй цочирдон, дэмий л цустай хувцсаа харан зогсоно. Толгой манаран, хэсэгхэн нүдээ анихдаа, үг ийм аюултай байдаг аа хэмээн гайхах.

Тэгтэл өөр нэгэн дуу гарна. Зөөлөн, эелдэг дуу. Дулаахан тэр дуу хоолойны алтлаг цацраг нь өмнөх харанхуйн аймшгийг үргээв. Амийн үг, эдгэрэл нь биднийг шархлуулсан үгийг хүчингүй болгоно. *Би чамд хайртай. Би чамтай хамт. Чи Минийх.* Зөөлөн илч нь улайссан зовиурыг намжаана. Таатай үг бүр сэргээгч шиг үйлчилдэг.

Үгийн хүч сэтгэлд ингэж л ажилладаг. Үг нь шархлуулах бас эдгээх чадалтай. Үүнийг мэддэг болсон болохоороо, үгээрээ

өрөөлийг дүрж шархлуулах бус, харин чөлөөлж эдгээдэг байя. Хайхрамжгүй үг хэлэхийн оронд үгэндээ болгоомжтой хандаж, зөв үг сонгоё. Хэлэх үгээ хянах нь үгийн хүчийг хүндэтгэж буй явдал болой.

Урам, энэрлийн энгийн үг нь хэн нэгний хувьд өөрчлөлтийг авчирдаг. Бурханы Үгийг ярих нь тэнхрүүлэгч эм уулгахтай л адил. Бурхан л эдгээгч учраас, Үг нь эдгэрлийг авчирдаг гэдэгт гайхалтгүй. Бусдыг урамшуулж, бидний санаснаас ч том ач хүргэлээ гээд биднээс юу унааж дээ.

Сонголт нь чинийх. Тэгэхээр, чи өнөөдөр эдгээх үү, шархдуулах уу?

*Бурхан минь ээ, надад үгийн хүчийг зааж
өгөөд, амьдралдаа учирсан хүмүүсийг
үгээрээ эдгээж, урамшуулахад туслаач.*

Би хүчирхэг

ЭДГЭРЭЛ, ЦЭЦ УХААН, АМЬ
АВЧРАХ ҮГИЙГ ЯРЬДАГ
ТУЛ БИ ХҮЧИРХЭГ.

НЭГ Л ЦУЛ СЭТГЭЛ

Аяа ЭЗЭН, замаа надад зааж өгөөч. Би Таны үнэнээр явах болно. Таны нэрээс эмээхэд зүрхийг минь нэгтгээч!

ДУУЛАЛ 86:11

Олон жилийн өмнө Жон, бид хоёрыг Израильд очиход хөтөч маань Ромчуудын талаар нэг зүйл ярьсныг би мартдаггүй юм. Тэд булаан эзэлсэн газраа дарлалгүйгээр захирч байсан бөгөөд Еврейчүүдэд Ромын соёлыг л даган дууриаж байгаа нөхцөлд өөрийнхөө шашныг дагахыг ч зөвшөөрдөг байжээ. Зүгээр л харахад яг Ром хүн шиг хувцаслаж, үйлдэж, амьдрахыг л шаарддаг байж. Булаан эзлэх энэ арга барил нь өнөө ч хэвээрээ мэт.

Орчин цагийн мэргэн ухаан ч “Та нар манай итгэлийн системийг дагаж байгаа нөхцөлд өөрийнхөө шашныг сахиж болно. Үнэн ганц байдаггүй юм. Үнэн чинь олон янз. Юунд итгэх нь та нарын хэрэг. Гол нь бидэн шиг үйлд” л гэдэг.

Гэхдээ ийм ухаан бидэнд таарахгүй. Бурхан биднийг соёлдоо уусаарай гэж хэлээгүй. Бид Түүний дотор нэгдэх ёстой. Энэ нь Есүсийн “Зам, үнэн, амь бол Би байгаа юм. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.” (Иохан 14:6) гэдэг үгд итгэнэ гэсэн үг.

Бид өнөөгийн трэндийг бус, Эзэнээ дагана. Түүний Үнэн л биднийг өөрийнхөө үнэнийг хойш тавиад, Түүнийг үзэл бодлыг авахад зоригжуулна. Бурхан хүнээс тэс өөрөөр бодож сэтгэдэг. Найрааны хоосон үг нь биднийг зан үйлдлээ шалтаглан зөвтгөж, бахь байдгаараа үлдэхэд хүргэх. Дэлхий бидний гэр биш, дамжин өнгөрөх газар учраас, бид соёлынхоо нөлөөлгөөр хэлбэршилгүй,

Ариун Бурхантай тогтоосон харилцаагаараа хувьсан өөрчлөгдөх ёстой юм.

Өнөөгийн оюун ухаан, цэц ухаанаас зөвлөгөө эрэлгүй, Бурханы Үгээс эр. Христийн дагалдагч - бид бие биенээ урамшуулан зоригжуулах дуудлагатай. Үүнийг Бурханы амлалтыг ярьснаар л хийнэ. Дэлхий “Хүссэнээ л хий. Өөрийнхөөрөө л бай” гэдэг. Гэвч тэнгэрийн элч төлөөлөгч - бид эдүгээ самуурсан дэлхийн дээр явж явна. Тиймээс бид өөрийнхөө төлөө бус, Түүний төлөө амьдрах ёстой.

Эзэний Үгийг энэ цагийн мэргэн ухаантай хутгаж болохгүй. Бурханы Үг хэзээд ганцаараа тогтоно. Хоёрдмол санаагаар аль алин дээр нь алхлах гэвээс, зөрчилдөнө. Өнөөдрийн эшлэл дээр Давид хоёргүй сэтгэлтэй байхын амин учрыг ухуулжээ. Чи ч мөн Бурханд л цул зүрхээр бүрэн үйлчлэх хүсэлтэйдээ үүнийг уншиж суугаа гэдэгт итгэлтэй байна. Бурхан биднийг сэтгэлээ хоёрдуулж, зөрчилдөхийг таалахгүй. Бурхан биднийг зүрхээ Өөрийнх нь бат хайр халамж дор тавиад, сэтгэлийнхээ дайсантай дайн зар зарлахыг л хүснэ.

Эзэн минь, Таны хаанчлал - миний соёл. Таны нэрээс эмээж, хоёрдоогүй сэтгэлээр амьдрахад туслаач.

Би хүчирхэг

БИ ХОЁРДООГҮЙ СЭТГЭЛТЭЙ
ТУЛ ХҮЧИРХЭГ.

ХАНА

Тэр өдөр Иудагийн нутагт энэ дуу дуулагдана. “Бидэнд хүчирхэг хот байна. Авралд зориулан Тэрээр Хэрэм, бэхлэлт босгожээ.

ИСАИА 26:1

Эрт дээр үед хотыг хана хэрмээр бүслүүрдэн хамгаалдаг байжээ. Хана хэрэм нь зэрлэг араатан юмуу дайсныг тогтоох үүрэгтэй. Энэ нь өнөөгийн бидэнд хөндлөнгийн ойлголт боловч, эрт үед хотууд өөрсдийгөө ингэж л хамгаалдаг байж. Хана хэрэм нь гадны хүнд “Сайн санаалж яваа эсэхээ батлан харуулахаас нааш, манай руу нэвтрэхгүй” гэсэн дохио болно. Хана нь мөн ард иргэдийн хувьд хамгаалалт нь болно. Хотын иргэд ч гадны халдлага, түрэмгийллээс хамгаалдаг хана хэрэм, сахиулууддаа итгэнэ. Хана хэрэм нь мөн халдварт өвчин тахлаас ч сэргийлнэ, салхи, бороо, цөлийн шуурга зэрэг байгалийн гамшгаас ч хамгаална.

Тэгвэл булаан эзлэгдээд, нурж сүйдсэн, хана хэрэмгүй хотыг төсөөлнө үү. Дайсан хүссэн цагтаа орж гарна. Нөмөргүй, аюултай тийм хотод хэн амьдрахыг хүсэх билээ?

Сүнсээ хамгаалаагүй хүн яг л ийм янзтай аж төрөх. Зүрх маань тэнгэрийн улс, хорогдох газар, амар амгалангийн газар бус, дайн дажны хөл болно. Бид чихний хажуугаар өнгөрөх хөнөөлт үг, худал, ааш авир, цочир үйл хөдлөл болгоны золиос болно. Гутрал гонсойлтоор өдөр тутам хооллож, гуниг харууслаар амьсгална.

Тэгэхээр, хамгаалалтын ханаа хэрхэн дахин босгох вэ? Амныхаа үгд анхаарч, эдгээж, босгох үгийг л хэрэглэж хэвшсэнээрээ. Бурханы Үгд суралцаж, үүнийгээ гэрлэлт, ажил, үр хүүхэд, нөхөрлөл дээрээ хэрэгжүүлж сур. Амьдралынхаа аль ч талыг хараахаас татгалзаж,

ерөөж сур. Бурханы Үгээр сэтгэлээ өөрчлүүлбэл, та ач тусыг нь хураана.

Бурхан чамайг өнгөрсөн амьдралдаа сонссон хатуу харгис, хараал үгийн хүлээснээс чинь чөлөөлөг. Эдгээр нь чиний өөрийн бодлогогүй үгс юмуу гаднаас харвасан пуужин мэт үгс байж болно. “Хэн ч намайг тоодоггүй. Эцсийн эцэст бүгд л урвана, би ганцаараа үлдэнэ. Би бүдүүн, царай муутай. Надад бүгдээрээ дургүй.” гэх зэрэг өөрийгөө сөнөөгч аюулт үгсээс болгоомжил. Ийм үг нь биднийг дотроос маань шархдуулж, ханыг маань цуулж байдаг. Үүний оронд барьдаг байгуулдаг, бэхжүүлдэг Үгийг хай - чиний талаар хэлсэн Бурханы үнэн Үгийг хэрэглээд, үүгээр зүрхээ хүрээлэн хүчирхэг хамгаалалтыг босго.

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, миний талаар, миний амьдралын талаар хэлсэн Таны үнэнийг харуулаач. Нөмөр дор нь цэцэглэхийн тулд зүрхээ тойруулан үнэний хүчирхэг хана барихад туслаач.

— Би хүчирхэг —

БИ БУРХАНЫ ҮГЭЭР ЗҮРХЭЭ
ХАМГААЛАХДАА, ХҮЧИРХЭГ.

ЭРГҮҮЛЖ ТОЙРУУЛЖ

*Илчлэгдэхгүй байхаар халхлагдсан, мэдэгдэхгүй
байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй билээ.*

ЛУК 8:17

Би анх Колорагод нүүж очоод, гэртээ буйдан худалдаж авахаар дэлгүүр орсон юм. Нэг буйдан маш их таалагдав. “Төгс буйдан!” Тэр буйдан үзэсгэлэнгийн танхимд олон төрлийн тавилга, чимэглэл, уран зургийн дунд янзтай харагдаж байлаа. Гэтэл би буйдангаа хана дагуулж биш, өрөөнийхөө голд тавих гэж байгаагаа санах. Тэгээд нөгөө үзэсгэлэнт буйдангаа хананаас татаад, арыг нь хартал, миний санасан шиг буйдан биш байв. Нүүрэн талд нь дурлаад, шууд л авчихмаар байсан ч... ар нь арай л биш ээ.

Хүн нүглийн нүүрэн талыг л хардаг. Нэг л хөөрхөн харагдаад л, санагдаад л... “Авдаг хэрэг ээ!” гээд л. Гэвч дараа нь ар талыг нь үзээд, шившигт унана.

Нүглийг нууцаар үйлдэхэд, Бурхан биднийг ичээдэггүй, бид өөрөө өөрийгөө л шившиглэдэг. Яг л нууцаар үр суулгачихаад, үр нь ургахаар Бурханд уурлахтай л ижил. Бид юмыг сайтар нууцалж чадна гэж бодож байж болох ч, өнөөдрийн эшлэл өөрийг өгүүлж байна. Бичээс нэг ч зүйл нуугдахгүй гэсэн л бол, нэг ч зүйл нуугдахгүй л гэсэн үг.

Үүнийг ойлгосон бол, сэрэмжтэйхэн шиг амьдрах нь чухал. Ефес ном биднийг үүнд л ятгажээ: “Харин бүх зүйл гэрлээр илчлэгдэхдээ

харагддаг. ... Тиймээс та нар мэргэн бусчууд шиг биш, мэргэн хүмүүсийн ёсоор, хэрхэн алхаж буйгаа хянаж бай.” (Ефес 5:13,15).

Сэрэмжтэй амьдрах гэдэг нь хүний амьдрал нь нэгэн цул хэлхээ бөгөөд өнгөрсөнд болсон аль нэг явдал нь ирээдүйд болох үйл явдалд заавал нөлөөлөхийг ухаарч амьдрах л гэсэн үг. Хэлхээ гэдэг нь тойрог, цагираг гэсэн утгыг илэрхийлэх. Мөн нүдээ том болгон анхааралтай нарийн харж хянах гэсэн утга ч илэрхийлнэ. Яг л шинээр орон сууц худалдаж авах гэж байгаа худалдан авагчийн нүд шиг л. Үүнтэй адил бид амьдралынхаа шийдвэрийг тал бүрээс нь янз бүрээр жинлэж байж л гаргах үүрэг хариуцлагатай ажээ. Шийдвэр дундуураа яваад, өрөө бүрээр нь ороод, тал бүрээсээ таалагдлаа гэдгээ бат болгох. Тэр цагт л мэргэн үйлдэл хийж, биднийг хүчитгэх сайн шийдвэр гаргана.

Эзэн минь, юу ч нууж чадахгүйг минь сануулж байгаач.

Тэр тусмаа Танаас. Үйлдэл шийдэл, шийдвэр болгондоо

сэрэмжтэй байж, Таныг л алдаршуулмаар байна.

Би хүчирхэг

БИ ӨНӨӨДРӨӨРӨӨ АМЬДАРДАГГҮЙ
УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ХАРУУСЛЫН НУТГАА ОРХИХ

*Гулдан хаалганы үүдэн дээр уяман өвчтэй
дөрвөн хүн байжээ. Тэд нэг нэгэндээ —Яагаад
бид үхэх хүртлээ энд суух ёстой юм бэ?*

2 ХААД 7:3

Гүйцээ, одоо хангалттай гэдэг шийдвэрт хүн бүр хүрэх л ёстой. Уяман өвчин хүний биеийг иддэг шиг харуусал зүрхийг иднэ. Хэзээ босоод явчихаа хүчирхэг эмэгтэй мэднэ. Харуусч амьдрахаас сэргийлэхийн тулд алсыг харж, зорилготой амьдар. Толгойдоо хувь тавилангаа тээж амьдар. Очих газаргүй амьдрал нь тэнүүчлэл болж хувирна. Зорих газартаа хүрэх өөр зам үгүй. Магадгүй чи өнөөдөр босмооргүй байж болох. Харууслын бүрэнхий дунд хэвтэж байж болох. Тэгвэл чамд хэлэх нууц байна: Харуусал чамайг тэндээс чинь тавьж явуулахгүй.

Тиймээс “Тэгэх юм бол... тэгнэ!” гэдэг үгээ “Хэдийгээр ийм байгаа ч... би тэгнэ!” гэдэг үгээр орлуулах цаг нь иржээ. Толгой дотроо цэг тавихаас нааш харуусал амьдралд минь ульсаар байна.

Залгамжлал халаа болгон удаах үеийнхэндээ үнэнийг өгүүлж, анхааруулснаараа алдаагаа ялах боломж, эрх үүрэгтэй гэдэгт би итгэдэг. Харин харуулсалдаа живсэн хүн үүнийг хэзээ ч хийхгүй л болов уу. Харуулсыг ялсан хүн сургамжаа өвлүүлдэг. Энэ нь удаах үеийнхэн нь илүү толгой өндөр зогсож, тод харж, бидний бүдэрч унасан нүхнээс зайлсхийнэ гэсэн үг. Өнөөдөр өнгөрсөн

амьдралынхаа харуусан гөлийж суух юмуу зүг чиггүй бэдрэх цаг биш. Өнөөдөр урагш явах цаг.

*Бурхан минь, би харууслын гамшигт дундаа
үлдмээргүй байна. Үйлдлээрээ бусдыгаа
зоригжуулахын тулд босоод, урагш явмаар
байна. “Тэгсэн цагт л... тэгнэ!” гэдэг үгээ
хэдийгээр “одоо ийм байгаа ч... би тэгнэ!”
гэдэг үгээр сольж, өнгөрснийхөө харуулсыг бус,
ирээдүйд минь хандсан Таны харааг тээе.*

Би хүчирхэг

БИ ХАРУУСЛАА ЗОРИЛГООР
СОЛЬСОН ТУЛ ХҮЧИРХЭГ.

ХАЙРЛУУЛСАН

Учир нь чамайг Бүтээгч нь чиний нөхөр мөн. Нэр нь түг түмдийн ЭЗЭН. Чиний Аврагч нь Израилийн Ариун Нэгэн бөгөөд бүх дэлхийн Бурхан хэмээн нэрлэгдсэн билээ. ЭЗЭН чамайг хаягдсан, сэтгэлээр гашуудсан эхнэр ...мэт дуудсан” гэж Бурхан чинь айлдаж байна.

ИСАИА 54:5-6

Ө нөөдрийн эшлэл эмэгтэйчүүдэд онцгой амлалт өгчээ. Бурхан “Чиний Бүтээгч Аав” гэж хэлж чадах байсан ч, тэгж хэлсэнгүй. Бурхан Өөрийгөө ааш авиртай гэргийгээ хайраараа сэргээж буй эр нөхрийн байр сууринд тавьжээ. Тэр бүү хэл “Уулс ганхаж, толгод доргивч, энэрэл хайр минь чамаас салахгүй, амар тайвны гэрээ минь хөндөгдөхгүй” гэж Энэрэгч ЭЗЭН чинь айлдаж байна.” (10-р эшлэл) хэмээн амлалтаа баталгаажуулсан байна. Амьдрал чинь хичнээн өндөр баллаар доргиж байсан ч, чамайг гэх Бурханы хайр өчүүхэн ч ганхахгүй. Үүнийг нэг мөр тогтоож аваарай.

Энэ Бичээст цоорхой байхгүй! Энд ганцбие, салсан, үр хүүхэдгүй, бэлбэсэн бүх эмэгтэй багтана. Энд шархалсан, хангалтгүй, зохисгүй эсвэл ямар ч авралгүй гэгдэх эмэгтэйчүүд ч багтана. Энэ амлалт бүх насны эмэгтэйчүүдийг хамарна. Энэ үгийг Бурхан хайртай нандин охиддоо хандаж хэлсэн. Бурхан эмэгтэйчүүдэд амар тайвныг өгүүлдэг. Тиймээс Түүний энэ амар тайвныг дотроо оруулаад, зүрхэн дэхь уур, зовнил, айдсаа намжаа.

Эмэгтэйчүүдэд онцгой боломж олгожээ. Бидний угийн чанар бусдыг тордож, бусдад үйлчлэх. Гэхдээ тэнгэрийн Аавдаа үл таалагдахаас айсандаа, яваандаа сайныг үйлдэхээс цуцдаг нэг гэмтэй. Хүчин зүтгэл минь хангалтгүй, золиос минь ч хангалтгүй

байх бий хэмээн эмээсээр. Гэхдээ чи өөрийнхөө байгуулсан гавъяагаар бус, Бурханы байгуулсан гавъяагаар л амьдарч яваагаа бүү март. Бурханы статуст тултал амьдарч чадах хүн байх уу? Бид Бурханы зүрхтэй хөөцөлддөг эмэгтэйчүүд байх ёстой. Гэхдээ Бурханыг уурлуулж, гологдохоос айгаад байвал, яаж хөөцөлдөх билээ. Гутарч, гонсойсоор л дуусна. Бурхан охидоо хүнд ачаанаас чөлөөлөх л хүсэлтэй.

Чи Бурханы тэнгэрлэг ур хийц, зорилгоор бүтээгдсэн бүсгүй. Чи аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдэж, ганхашгүй хайрлуулсан гэдэгтээ хөөрөх ёстой.

*Бурхан Эзэн минь, надад яг ямар эмэгтэй байхыг минь
зааж өгөөч. Би Таны ганхашгүй хайр, миний төлөө
хийсэн үйлсийг хүлээн авч байна. Намайг Өөртөө
ойртуулж, яг байх ёстой байр сууринд минь тавиач.*

— Би хүчирхэг —

БИ ТЭНГЭРИЙН УХААНААР УРЛАГДСАН
УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ХОЁРДУГААР ЗЭРГИЙНХ БИШ

*“Би та нарын Эцэг болж Та нар Миний хөвгүүд,
охид болно” гэж Төгс хүчит Эзэн айлддаг.*

2 КОРИНТ 6:18

Би Есүст итгээд, Бурхан надад хайртай гэдгийг мэдсэн ч, Түүний энэ их үзэсгэлэнт хайр өршөөлийг ойлгоход ухаан хүрэхгүй байсан болохоор, тэр их хайр халамж руу зүгээр л харайгаад орчихож билээ. Эмэгтэй хүн ингэх бүрэн эрхтэй гэдэгт би огт эргэлзээгүй юм.

Гэвч хожим янз бүрийн чуулган, конференцэд сууж элдвийг сонсохдоо, Бурхан надад хайртай гэдэг ойлголт минь булингартаж эхэлж билээ. Аврагдсан хэдий ч, яагаад ч юм хаанчлалд хоёрдугаар зэргийн иргэн мэт санагдах болов. Мэдээж хэн ч шууд ингэж хэлээгүй ч, ярианд нь “эмэгтэйчүүдэд найдвар муутай улс, өөрчлөгдөхдөө тааруу улс” гэсэн санаа л цухалзаад байна.

Анх коллежид байхдаа ийм эргэлзээтэй тулгарсан юм. Христэч конференц дээр гоё магтаалын дараа нэг пастор цуглааныг нээж залбираад, гэргийгээ тайзан дээр урив. Мянга мянган хүнээр хүрээлүүлсэн тайзан дээр нэгэн сайхан бүсгүй гараад ирлээ. Тэгтэл нөхөр нь гэргийгээ цуврал хошигнол, явуулгаар нялж эхлэв. Гэргий нь ч мөчөөгөө өгөлгүй, хэдэнтээ хариу барив. Чуулган даяараа инээлдэж байсан ч, миний дотор муухайрч байлаа. Гэргий нь тоотой тоглож байхад, нөхөр нь хавьгүй хорон, хүчтэй цохилтоор өөд уруугүй нүдсээр.

Мань нөхөр: “Эмэгтэйчүүд байгаагүй бол, өнөөдөр эрчүүд хаана

байх байсан бол?” хэмээн нухацтай гэгч асуухаар нь тэр олон хорон үгийн дараа ганц мэргэн үг хэлэх нь үү гэж горьдлоо.

Гэтэл: “Эрчүүд цэцэрлэгтээ байх байсан.” гэж хариулав. Танхим пир хийв. Тэгэхээр, би ганцаараа л эргэлзэж, эгдүүцээд байгаа хэрэг үү? Би энэ ертөнцөд шоолуулах гэж нөгөө ертөнцийн шившгээс чөлөөлөгдсөн хэрэг үү? Нүүр халуу оргиж, нулимсаа барьж ядав.

Маргааш нь би цуглаанд суулгүй, харин хүүхэд харах үйлчлэлд сайн дураараа хамрагдав. Уйлагнах нярайг бүүвэйлээд, Бурхан надад зүгээр л хайртай гэдэгт итгэх нь хавьгүй сайхан байлаа. Тэднийг элгэндээ тэврэхдээ, Бурхан надад ингэж л ханддаг гэж төсөөлөх жаргал байлаа. Дотор минь Бурхан надтай зөөлөн ярьж, харин би уйлж байлаа. Би Түүний охин, Тэр миний Аав. Надад мэдэх юм тийм их байгаагүй ч, Бурхан надад хайртай гэдгийг л мэдэж байлаа.

Өөрсдийг нь алгадсан, хүйсийг нь доош хийсэн үгд эмэгтэйчүүд яагаад итгэдэг юм бол? Айсандаа тэр үү? Үгүй байх аа, илүү гүн учиртай байх. Энэ үг үнэний ортой гэж итгэдэг учраас л хүчирхийллийг тэвчдэг байх. Гэхдээ ингэж болохгүй. Бурхан эмэгтэй хүнийг эмэгтэй гэдгээр нь голдоггүй. Бурхан биднийг хоёрдугаар зэргийн байлгахаар бүтээгээгүй. Аав хүн охин үрээ хайрладаг шиг л хайрладаг. Бурханы хайр баталгаатай.

Эзэн минь, Та л намайг эмэгтэй хүн болгож бүтээсэн.

Миний жинхэнэ үнэ цэнийг, намайг яаж хайрладгаа харуулаач. Өнөөдөр охиноо зоригжуулан, хүчжүүлээч.

Би хүчирхэг

БИ БУРХАНЫ ОХИН УЧРААС, ХҮЧИРХЭГ. БИ “Б”
ТӨЛӨВЛӨГӨӨ БИШ. БИ ТҮҮНИЙ АНХНЫ ХАЙР.

БҮХ ХАЙРАА

Бурхан бол худал хэлдэг хүн биш...

ТООЛЛОГО 23:19

Маш олон бүсгүй нөхөрт гарч, мөрөөдлийнхөө хархүүгээр мөнхөд хайрлуулах хүртлээ хувь тавилангаа хүлээлэг дээр тавьчихдаг. Ингэж төөрөлдөж явахдаа өөрийгөө Бурханы мөрөөдөл болсон бүсгүй гэдгээ умартана. Бид чинь хайртайгаа учиртлаа хүлээх шаардлагагүй. Учир нь бид хайртайгаа хэдийнээ учирчихсан. Есүс биднийг түрүүлж хайрласан. Бурхан бидэнд хайртай юу, хайргүй юу гэдэг асуудлыг хэдийнээ нэг тийш нь болгох болсон.

Тийм боловч зуун зууны турш Евагийн охид Адамын хөвгүүдээс “Намайг хайрлаач. Намайг хамгаалаач. Аюулгүй байж, хамгаалуулах гэсэн гүн хүслийг минь хангаач.” хэмээн гуйж гувшсаар л. Гэвч Евагийн охидын үгээрээ ч илэрхийлж чадашгүй гүн хэрэгцээг нь хангаж чадна гэсэн баталгааг гаргаж өгч чадахгүй гэдэг хариултыг л Адамын хөвгүүд өгдөг. Эмэгтэйчүүдийн тэр гүн хэрэгцээг гагцхүү Бурхан л хангаж чадах учраас, хоёр талын нэхэмжлэл үндсэндээ талаар болдог.

Халуун зүрхтэн гэдэг номдоо Жон Элдреж сэтгэлээ хангахаар “алтан үст охидын” эрэлд гарсан эрчүүд адагтаа гонсоймоор үр дүнд хүрдэг талаар өгүүлдэг. Тэгвэл бүсгүйчүүдийн хувьд? Бид ч бас ийм зүйлд найддаггүй гэж үү? Бид сэтгэлийг минь хангаж өгөөч хэмээн Адамыг царайчилсаар. Гэтэл Адам биднийг гонсойлгохоос өөрийг хийж үл чадна. Евагийн хувьд Адам зүгээр нэг эр нөхөр гэхээсээ илүү нэг талаараа аавын үүрэгтэй байсан мэт. Учир нь Ева нь эр хүнээс төрсөн цорын ганц эмэгтэй. Ева могойд мэхлүүлээд, дараа нь

Адамын сонголтонд ч, өөрийнхөө сонголтонд ч гутарсан. Үнэндээ, эрчүүд маань эмэгтэйчүүд биднээс давсан том зүйлээс хүч чадлаа олдог байх ёстой.

Адамын хөвгүүд буруугүй ээ. Бидний хайгаад байгаа ерөөлийг тэд угаасаа өгч чадахгүй. Эмэгтэйчүүд өөрт нь хэт ахадсан том эрх хүч олгох үед тэд эмээдэг. Бидэнд хэрэгтэй, жинхэнэ ерөөл Бурханаас л ирдгийг мэд. Бурхан биднийг шинээр нэрлэхийг нь зөвшөөр. Учир нь эдүгээ бид сүүдэрт бөртөлзөх Евагийн охид бус, харин амлалт, гэрлийн охид, Түүний Сүйт бүсгүй болсон.

Эрчүүдтэй тогтоох харилцаанаас хайр дурлал, түншлэл, амьдралынхаа ханийг олж болох ч, тэд бидний Аврагч болж чадахгүй. Есүс л хэзээ ч худлаа ярьдаггүй Үнэн болой. Түүний Ариун Сүнс бидэнтэй хамрын амьсгалаас минь ч илүү ойр. Бид Есүсийн дотор л аврагдаж, хамгаалагдаж, үнэ цэнийг олж, Тэр л биднийг төгс хайраараа зөвхөн Түүнд л боломжтой аргаар бүрэн бүтэн болгосон.

*Эзэн минь, Та хэзээ ч худлаа ярьдаггүй Үнэн болой. Та
л ганцаараа намайг бүрэн бүтэн болгоно. Сэтгэлээ
Танаас өөр хүмүүнд даатгасныг минь уучлаарай.*

— Би хүчирхэг —

БИ УТГА УЧРАА ЭР ХҮНИЙ ДОТРООС БУС,
БУРХАНЫХАА ДОТРООС ОЛОХДОО, ХҮЧИРХЭГ.

ГЭРЭЛД АЛХАХ

*Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн
дотор явбал, бид бие биентэйгээ нөхөрлөж, Түүний
Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс цэвэрлэдэг.*

1 ИОХАН 1:7

Гэрэлд алхах гэдэг нь юу гэсэн үг вэ? Үүнд хариулахын тулд өмнөх эшлэлийг нь харах хэрэгтэй. 1Иохан 1:5: “Бурхан бол гэрэл, Түүний дотор харанхуй огт үгүй.” Бурхан гэрэлд яваад зогсохгүй, Өөрөө гэрэл болой. Энэ гэрэл нь гадаад өнгөлгөө бус, харин Бурханы бүр эхлэлээс л үүдэлтэй. Түүний дотор ямар ч харанхуй үгүй. Энэ нь бидний хувьд ойлгох нь бүү хэл, төсөөлөхөд ч бэрх ойлголт. Учир нь бидний харж байгаа бүхэн аль нэг талаараа сүүдэртэй, харанхуй. Бидний мэддэг гэрэл болгон аль нэг талаараа сүүдэр гаргадаг. Элч Иохан биднээс гадуурх юмуу биднийг хүрээлэгч, гадна талд асдаг гэрлийн эх үүсвэрийн талаар яриагүй, харин биднээс гардаг гэрлийн тухай ярьжээ.

Иохан бодит, байгалийн гэрлийн талаар яриагүй, харин бидний сүнсний гэрлийн талаар өгүүлсэн. (Гэхдээ Мосе дээр харагдсан шиг энэ гэрэл нь тэнгэрт бодитоор харагддаг байж болох юм.) Бид цэвэр зүрхээр амьдарснаараа өнөө цагийн сүүдэртэй, харанхуй дэлхий дээр гэрэл дотор явна. Бид Есүсийн цусаар цэвэрлүүлснээрээ, харанхуйн талбарыг амьдралаасаа хөөнө. Энэ нь Бурхантай тогтоосон нөхөрлөлийг минь ч, бусад итгэгч хүмүүстэй тогтоосон нөхөрлөлийг

минь ч сэргээнэ. Гэхдээ “Бид нүгэлгүй гэж хэлбэл өөрсдийгөө мэхэлж байгаа бөгөөд бидний дотор үнэн алга (1Иохан 1:8).

Өөрийгөө их бага мэддэг хүн өөрийгөө нүгэлгүй гэж хэлэхгүй байх. Гэхдээ заримдаа өөрийн мэдэлгүй өөрийгөө зөвтгөчихөөд байдаг. Буруугаа зөвтгөх юмуу зан үйлдлээ шалтаглан өмөөрөх нь үндсэндээ өөрийгөө гэмгүй л гэж байгаа хэрэг. Тухай нь “Уучлаарай. Би (ингэх, тэгэх) ёсгүй байсан юм. Гэхдээ... (хэмээн шалтаг тоочих!) Хүн бүр ийм маягаар шалтаглахыг мэднэ. Хүүхэд байхаасаа л аль нэг хэлбэрээр биеэ өмөөрсөөр ирсэн. Гэвч энэ нь уучлал гуйх явдал биш, харин ялаас мултрах л арга юм. Гэтэл хүн хийсэн хэргийнхээ хариуцлагыг бүрэн үүрэхээс нааш хэзээ ч жинхэнээсээ гэмшихгүй.

“Уучлаарай даа! Гэхдээ чамайг ингэхээр чинь уурлалгүй яахав дээ.” Энэ бол бурууг үйлдэхээс өөр арга байсангүй гэдэг ялын техник. 1Иохан 1:8 дээр бид “нүгэлгүй” гэх үлгэр загварыг дагах аваас, өөрсдийгөө мэхэлж байгаа бөгөөд “бидний дотор үнэн алга” гэсэн. Үнэнийг мэдэх нэг хэрэг, үнэнээр амьдрах өөр хэрэг.

Бурхан цэвэр гар, цэвэр зүрхийг хүсдэг. Энэ нь даруу зан, ил тод байдал, үнэн чанараар л ирнэ.

*Эзэн минь ээ, өчүүхэн ч харанхуйг шалтаглан
зөвтгөлгүй, үнэн дотор явахыг зааж өгөөч.*

Би хүчирхэг

ГЭРЛИЙН ЭХ ҮҮСВЭР ӨӨРӨӨ НАМАЙГ ҮНЭНИЙ
ЗАМААР ХӨТӨЛДӨГ УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

Баримцаандаа
хүчирхэг

ХЭЗЭЭ Ч ГОЛОГДОХГҮЙ

Түүний хилэн агшин зуурынх, таалал ивээл нь насан туршийнх.

Шөнөд уйлаан байж болох ч, өглөөд баярын уухай ирдэг.

ДУУЛАЛ 30:5

Чи өөрөө ч мэдэлгүй хэн нэгнийг гомдоож, гонсойлгосноо олж мэдэхээрээ яадаг уу? Миний хувьд тэр хүнээсээ дөлж, зугтах юмуу биеэ өмөөрөөд байвал, харилцаа маань дуусдгийг гашуунаар сурсан. Харин эсрэгээрээ, чин зүрхээрээ хандаад, гараа сунгаад, үнэн голоосоо уучлал гуйж чадбал (энэ хамгийн хэцүү хэсэг нь) харилцаа чинь эдгэрэх боломжтой. Заримдаа нөгөө хүн таатай хариу өгөхгүй ч байж мэднэ. Гэхдээ л энэ бол харилцааны хамгийн зөв арга. Нөгөө хүн чамайг уучлахгүй байлаа ч, “Бурхан хэзээд уучилна. Бурханы хайр, уучлал хэзээд хэвээрээ. Заримдаа Бурхан ч нүүрээ буруулчихсан мэт санагдаж байсан ч, Тэр чамайг хэзээ ч голохгүйг” мэдээрэй.

Заримдаа Бурхан бидний үйлдлийг таалахгүй. Гэхдээ өөртөө түс тас хандаж, гэмшиж, Бурханаас уучлал гуйбал, Бурханы гэрэл хайр зүрхийг минь дүүргэнэ. Шийтгүүлж байхдаа таарсан намайг Бурхан өршөөлөөрөө нөмөрдөг. Бурхан тэр дороо “Чи минийх. Би чамд хайртай. Чи өөрчлөгдөхийг хүсч байгааг чинь мэднэ. Би чамайг уучилсан. Одоо март” гэдэг. Тэгэхээр, би ч бас чамд үүнийг л хэлмээр байна.

Чи Бурханы хүүхэд. Бурхан чиний үйлдэл, үг, зан авирт дургүйлхэж болох ч, чамайг хэзээ ч голохгүй. Тиймээс Аавдаа таагүй

юм хийснээ мэдэж байгаа бол, зугталгүй, харин ч Аав дээрээ гүйгээд оч. Зайгаа авч нуугдах нь явцсыг сунжрааж, “Бурханы таалал насан турш” гэдгийг үзүүлэхгүй. Зүрхээ нээгээд Бурханы зүрхийг ч тань, авах сургамжаа ч ав.

Аав аа, Та надад хайртай учраас, бурууд хатуу байна. Таны өршөөлөөр цэвэршүүлэх шаардлагатай тал амьдралд минь байгаа эсэхийг Үгээрээ ч, Сүнсээрээ ч харуулаач. Би Танаас зугталгүй, Тан руу гүймээр байна.

Би хүчирхэг

БИ БУРУУ ҮЕДЭЭ ХЭН ДЭЭР ОЧИХОО
МЭДДЭГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ЗӨРЧИЛ ДУНДАХ АМАР ТАЙВАН

*Та нарын зүгээс боломж байгаа бол
бүх хүнтэй эвтэй байгтун.*

РОМ 12:18

Зөрчлийг шийдэх талаар ярих нь үйлдэхээсээ илүү амархан. Итгэгч хүмүүс зөрчилдлөө гэхэд, ядаж л зөрчлийг шийдэх жишиг, арга нь нэг ч, заримдаа хүмүүс эвлэрэхээс татгалздаг. Тэр үед яах вэ? Өдий наслахдаа хэд хэдэн ч удаа ийм явдалтай тулгарч байлаа. Миний бие яасныг бүү мэд, найзыгаа гомдоож, бидний дунд цав үүссэн юм. Би ч өөрийгөө шалгаад, найз дээрээ явж очоод, үгээрээ юмуу үйлдлээрээ гомдоосон эсэхийг асуув. Санаандгүй гомдоосон байж болзошгүй ба харилцаа маань надад чухал байгааг илэрхийлтэл, найз маань зүв зүгээр гэсэн ч, харилцаа сайжирсангүй. Би найздаа бэлэг худалдаж аваад, зурвас бичээд, дахин уучлал гуйсан ч, таг. Дахиад л биеэрээ очиж уулзлаа. Найз ч бүх юм зүгээр гэсэн боловч, хөндий хэвээрээ үлдэв. Тиймээс юунаас болоод надад тэгтэл гомдсоныг нь дундын найзаасаа лавлатал, тэрбээр юу ч мэдсэнгүй. Би ч хамаг зовлонгоо уудаллаа. Дундын найз минь сонсож дуусаад: “Лиза, чи түүнээс уучлал гуйсан уу?” л гэж байна.

“Гуйсан” л гэлээ.

“Уулзсан уу?” л гэж байна.

“Уулзсан. Ахин дахин.” л гэлээ.

“Тэгээд тэгээд хүлээж авахгүй байгаа бол, тэр хүнийг зүгээр л орхи.

Тэр үг намайг чөлөөлөв. Би Ром 12:18-ыг биелүүлснээ мэдэв: “Та нарын зүгээс боломж байгаа бол бүх хүнтэй эвтэй байгтун.” Би ямар буруутайгаа ойлгохгүй байсан болохоор, маш хэцүү, яах учраа олохгүй байсан юм. Үнэндээ, найз минь надтай цаашид нөхөрлөх сонирхолгүй болчихсон ч юмуу эсвэл зүгээр л бидний амьдралын улирал солигдчихсон байж болох. Бурханы нөлөөтэй ч, нөлөөгүй ч, зарим харилцаа алсарсаар алсарсаар холбоо тасрахыг би олонтаа харсан.

Бид эвлэрлийн төлөө залбираад, энэ үйл явц дунд ямар үүрэгтэй болохоо Бурханаас асуух хэрэгтэй. Заримдаа эвлэрмээр байгаа хүн дээрээ даруухнаар хайрласаар хүрч очсон ч, тэд татгалздаг. Энэ нь тэд адилхан хариу өгөхөд бэлэн болоогүй байна л гэсэн үг. Сэтгэл чинь өвдөж магадгүй. Гэхдээ Бурханы Үгийг дагаж байгаа хүн хэзээ ч буруудахгүй.

Бурхан минь ээ, эвлэрлийг зөөдөг хүн байх хүч хайрлаач. Хэзээд нь тухайн хүний хариу үйлдэл миний мэдлээс давсан хэрэг болохыг ойлгуулж байгаач. Надаас шалтгаалж байгаа нөхцөлд эвлэрлийг зөөдөг хүн байхад туслаач.

Би хүчирхэг

БУСАДТАЙГАА БӨГӨӨД БУРХАНТАЙ
ЭВТЭЙ УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

ТАТАГДАХ, ЧИГЛҮҮЛЭГДЭХ

*‘Намайг хамгаалаач Бурхан, ...Таны дотор би хоргоддог.
...“Та миний Эзэн Танаас өөр сайн сайхан гэж надад үгүй”...
ЭЗЭН өмнө минь үргэлж байсан. Тэр миний баруун талд
байдаг учраас би ганхахгүй. Тиймээс зүрх минь баярлаж,
алдар минь баясна. Бие махбод минь ч аюулгүй оршино.*

ДУУЛАЛ 16:1–2, 8–9

Юунд татагдаж байгаа нь хүний зүг чигт, яваандаа амьдралынх нь тал бүрт нөлөөлнө. Бурханд татагдахыг хүсч буй хүмүүс “Үл үзэгдэх Бурханд яаж татагдах вэ?” гэж асуух байх.

Ямар нэг юмыг хэрхэн хийхийг мэдэхийн тулд сайн хийдэг хүнээс нь асуух хэрэгтэй. Давид хаан Бурханыг гал халуунаар хайрладаг ч, араас нь гүйхийг ч мэддэг хүн байсан. Давид шиг Бурхантай хөөцөлддөг хүн түүнээс өмнө байгаагүй. Давид Бурханы хайр, итгэмжтэй чанарт нэг ч эргэлзэлгүй, ямагт талархал, хариутай амьдарчээ.

Өнөөдрийн эшлэл дээр Давид Бурханыг тэргүүнд тавьж, зүрхээ үгээрээ мэдэгджээ. Залбирал, зөрчил, харилцан яриан дунд амнаас гардаг үгс л зүрхийг илчилдэг. Эсрэгээрээ, амнаас гарах үгс зүрхийг ч хэлбэршүүлдэг. Бид ч Дуулал дээр Давидын хэлсэн үгийг өөрийн болгох хэрэгтэй:

1. Бурханыг хорогдох газраа болго... хаад ч амиа хамгаалах ёстой.

2. Эзэнийг өөрийнхөө Эзэн болго.
3. Түүнээс илүү юм гэж байхгүйг хэл.
4. Түүнийг мөнхөд тэргүүнд тавь.
5. Түүнийг амьдралаараа хүндэтгэж, өргөмжил.
6. Үйлдэл бүрээрээ Түүнийг дага.
7. Тэр хариуцлагатай учир, Түүний төлөө зогс.
8. Чи биш, Тэр хариуцлагатай учраас, уужуу тайван бай.
9. Эдгээр хүчирхэг үнэний төлөө Түүний дотор амар.

Бурханы гэрээ, хайрын тунхгийг хийх үед бидний хоорондын барилдлага бэхэждэг. Бид үгээрээ бас зохих үйлдлээрээ амьдрал дахь харилцаа бүрээ өргөжүүлж чадна. Үг нь бидний амин газрыг эдгээж, цэвэршүүлэх ч чадалтай, гүн шархлуулах ч чадалтай.

Бурханаар зүрхээ дасгалжуулахын тулд найзаа сонгодог шигээ... үгээ ч ухаалгаар сонго. Үг чинь цөөн байж болно. Гол нь үнэтэй байг. Үгээрээ Бурханыг мөшгибөл, Давидтай адил Бурханаар өсөхийн хүслэн болно.

Эзэн минь, би Таныг мэдмээр байна. Хамгийн хайртай хүнийхээ араас гүйдэг шигээ Таны араас ч санан санан гүймээр байна. Таныг гэх сэтгэл минь өсөх болтугай.

— Би хүчирхэг —

ҮГ МИНЬ АУГАА ХҮЧИРХЭГ БУРХАНЫ ХАЙРААР
БАЯЖДАГ УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

АЮУЛГҮЙ БӨГӨӨД ХАМГААЛАГДСАН

*ЭЗЭН бол дарлагдагсдыг хамгаалах бэхлэлт,
Бэрх цагийн бэхлэлт болно.*

ДУУЛАЛ 9:9

Бэлгийн ч, биеийн ч хүчирхийлэл аюулын төвшинд хүрчээ. Аав минь намайг яаж амьдраасай гэж хүсэх бол?

Бид ойр дотныхоо хүмүүстэй харилцахдаа, дээрх асуултыг өөрөөсөө асуух хэрэгтэй. Тэр харилцаанд эмч, багшаас чинь авахуулаад гэр бүл, найз нөхөд чинь ч багтана. Найз залуу, эр нөхөр чинь ч багтана. Гэхдээ анхаараарай: Аль нэг талаараа хүчирхийлэлд өртсөн хүн хүлцэнгүй, дуугүй явах нь эрүүл зөв явдал юмуу хайр майр огт биш шүү. Хүчирхийлэгч, ашигч хүмүүстэй бүү харилц. Эрүүл, бурханлаг аавууд охидоо амиараа хамгаалдаг шиг тэнгэрийн Аав чинь ч чиний аюулгүй байдлыг аминчилдаг.

Тэнгэрийн Аав чинь чамайг хүчирхийлүүлэх бус, харин аюулгүй байж, арчлуулж тордуулж явахыг л хүснэ. Хүмүүсээс юмуу өөрийнхөө тааруу шийдвэрээс бүү ай. Бурхан чиний ар тал болж, хамгаална. Бурхан “Үүнийг чи өөрөө л хүссэн. Ингэх гээд байсан юм” гэж хэзээ ч хэлэхгүй! Харин ч “Эндээс яв, харь. Аюулгүй бай” л гэнэ. Чи хүчирхийллийг мэдүүлэх ёстой газар нь мэдүүлэх бүрэн эрхтэй.

Энэ нь романтик харилцаа, нөхөрлөл, бизнесийн түншлэл зэрэг харилцаа холбооны бүх төрөлд хамаатай. Лук “та нарыг доромжлогсдын төлөө залбир” гэсэн ч, холын залбирал ч ялгаагүй

хүчтэй (Лук 6:28). Паул “Та нарын зүгээс боломж байгаа бол бүх хүнтэй эвтэй байгтун (Ром 12:18) гэсэн. “Боломжтой бол” гэдэг нь нөгөөдүүлээс ч хамаарах хэсэг байгааг илтгэнэ. Чамд хөнөөлтэй хүнээс зайгаа авч, эрүүл харилцагаа хадгалах эрх нь ч, чадвар нь ч чамд бий. Хянан захиргаадагч хүнтэй нүүрэлдэх хэцүү байвал, биеэрээ уулзах хэрэггүй. Тэгээд мэдээж ямар ч нөхцөлд бэлгийн ч, биеийн ч хүчирхийллийг хүлцэх ёсгүй.

Хүчирхийлэгчээс зайгаа барих нь өөрийгөө хамгаалахаас гадна нөгөө талд хүлээн зөвшөөрөх аргагүй зан авираа засахыг анхааруулсан дохио болно. Чи хүнийг цаашдынхаа амьдралд оролцуулахгүйгээр уучилж болно. Уучлал нь Бурханы нандигнадаг сэтгэлийн чинь эрүүл мэндийг хамгаална.

Чи Бурханы хайртай охин. Тэр чамайг яаж амьдраасай гэж хүсэх бол?

*Есүс ээ, амьдралд минь байгаа, алив хортой
харилцааг нэг мөр болгох хүч, цэц ухаан хайрлаач.
Та миний төлөө гэдэгт итгэж байна.*

Би хүчирхэг

БИ ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ, ХОРТОЙ ХАРИЛЦААНД
ХИЛ ХЯЗГААР ТОГТООХДОО, ХҮЧИРХЭГ.

ЗӨВ НӨХӨРЛӨЛ

Далдлагдсан хайраас ил зэмлэл дээр. Андын чинь учруулсан шарх сайныг. Дайсны чинь үнсэлт заль мэхийг.

СУРГААЛТ ҮГС 27:5–6

Нөхөрлөл бидэнд ер бусын нөлөөлөл үзүүлж чадна. Жинхэнэ найз бидний бардам занг хөндөв ч, эцэстээ эдгээх үгсийг л хэлдэг. Жинхэнэ найз бидний сонсохыг хүссэн үгийг бус, сонсох хэрэгтэй үгийг хэлдэг. Нөгөөтэйгүүр “муу нөхөрлөл сайн зан чанарыг завхруулдаг” (1Коринт 15:33). Даган дууриамаар байгаа хүмүүсээрээ л өөрийгөө хүрээлүүл.

Хүчирхэг эмэгтэйчүүд дараах байдлаар найз нөхдөө сонгодог:

Нэгдүгээрт - чиний эсрэг бус, чиний төлөө байдаг хүмүүстэй нөхөрлө. Гомдлын төвшинд л нөхөрлөж байна уу? Найзуудтайгаа уулзсаны дараа уур чинь хүрч, ядарч, туйлдаж байна уу? Өсөлтөд чинь хувь нэмрээ оруулдаг хүмүүстэй нөхөрлөдөг бай, өөрөө ч тийм хүн бай.

Хоёрдугаарт - чиний өсөлтийг дэмжиж, болмоор байгаа дүр дээрээ төвлөрөхөд чинь тусалдаг хүмүүстэй л нөхөрлө. “Төмөр төмрөө, хүн хүнээ хурцалдаг.” (Сургаалт үгс 27:17). Худлаа бялдуучилдаг, аргалдаг, чихэнд чимэгтэй үгс хэлдэг бус, харин хайраар үнэнийг хэлдэг найзтай байж, өөрөө ч тийм найз бай. Эрүүлээр санал зөрж, “андын учруулсан шарханд итгэх” боломжтой.

Тэвчээртэй бай. Итгэлцэлд цаг хугацаа шаардлагатай. Нөхөрлөлд цаг хугацаа хэрэгтэй. Дотносол нь хамаг байдгаа дэлгэхийн нэр биш. Чи хэн нэгний талаар мэдэх ёстойгоосоо илүүг мэддэг байлаа гээд, хүмүүс чиний талаар мэдэх ёстойгоосоо илүүг мэддэг байлаа гээд,

та нар үе зайгүй нөхөд гэсэн үг биш. Учиргүй дүрэлзээд л унтарч байгаа нөхөрлөлийг зөндөө харсан. Бүх үнэт зүйлтэй адил эрүүл саруул харилцаа нь хөдөлмөр шаардана. Үнэндээ санал зөрөлдөж, ам мурийх хүртэл нөгөө хүн жинхэнэ нөхөр эсэх нь үл мэдэгдэх.

Олон нийтийн сүлжээ нь нөхөрлөл байгуулдаг бус, туршлага хуримтлуулдаг хэрэгсэл. Тиймээс нөхдөө хянамгай сонго. Амьдралынхаа аль ч улиралд зөв нөхдийг Ааваасаа гуйж. Хэн нь жинхэнэ найз, хэн нь “Дүлзэн” болохыг Бурхан л харуулна. Чамайг цаг үргэлж доош хийж, урваж, гадуурхдаг хүнээс яагаад салахгүй байгаагаа нягтал. Сэдлээ шалга. Эрүүл бус тойрогт гагцхиаад байна уу? Алдартай байх гэсэндээ юу? Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хүслийг ялгаж салгахын төлөө залбир.

Бид ямар ч, хэдэн ч хүнтэй эелдэг, нөхөрсөг, сайхан харилцаатай байж болно. Харин дотно нөхөрлөж, хөрөнгө оруулахаар шийдсэн тэр хүн, та хоёрын дунд хайраар үнэнийг хэлдэг харилцаа л оршиг.

Бурхан минь, Та намайг хамт олонтой байлгаж, хамт олны дунд, хамт олноор минь дамжуулж өсгөхийг хүсдэг. Цагаа өнгөрөөх хүнээ зөв сонгоход туслаач.

— Би хүчирхэг —

НАДТАЙ ХАМТДАА ӨСДӨГ ХҮМҮҮСТЭЙ
НӨХӨРЛӨДӨГ УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

ШУДАРГА БУРХАН

*Хөрш нь ирж, шалгахаас нааш хэрэг явдлаа
түрүүлж хэлсэн хүний л зөв байдаг.*

СУРГААЛТ ҮГС 18:17

Олон нийтийн сүлжээнд, өрөөнд, ярилцлагад нэгээс олон хүн оролцож байгаа нөхцөлд санал зөрж, зөрчил үүсэх өндөр магадлалтай. Тэгээд хоёр тал өөр өөрийнхөө байр суурийг л зөв гэж үздэг болохоороо, нөгөө талаа сонсохын оронд нумарчихдаг.

Израилийн хүүхдүүд Египетийн дарлалаас чөлөөлөгдөх үедээ нүүрлэх зөрчлийг хүчирхийлэл сүрдүүлгээр шийдвэрлэж байхыг үзсэн. Гэхдээ чөлөөлөгдсөн хойноо зөрчлийг эрүүл саруулаар шийдвэрлэх шинэ улиралдаа хөл тавьжээ.

Тэд Египэд дэхь боолын амьдралаа Бурханы оршихуйн хамгаалалт, үүлэн дорх амьдралаар сольсон. Тэд үхмэл, чулуун шүтээний захиргаан дороос гарч, ариун бөгөөд зөвт, хайрын бөгөөд аймшигтай амьд Бурханы захиргаан дор орсон. Гал, хайр ассан Израилийн Бурхан нь тахилд баясдаг Египетийн бурхдаас анги байв. Израилийн Ариун Нэгэн нь сүнсээр бөгөөд үнэнээр үйлчлэхэд дуртай, үнэнээр захирдаг Бурхан байв. “Харин ЭЗЭН мөнхөд захиран сууж байдаг. Тэрээр шүүхийн төлөө сэнтийгээ зэхсэн.” (Дуулал 9:7).

Бид шударга бус хандлага үзэхдээ, шударга ёсны төлөө хашхирдаг. Хүн бүрийн дотор шударга ёсны төлөө орь дуу тавьсан, гүн шарх байдаг ч, үнэндээ бид бүгдээрээ л буруу зөрүүгээр шүүгдэж үзсэн. Нөгөө талын түүхийг сонсох хүртлээ би олон ч удаа, олон ч

хүн дээр өөрийгөө зөв бодож байна гэдэгтээ итгэлтэй явдаг. Иймээс л Паул “Иймд цагаас өмнө, Эзэнийг иртэл юуг ч бүү шүүгтүн. Эзэн харанхуйд нуугдсан юмсыг гэрэлд гаргах бөгөөд зүрхний санааг илрүүлнэ. Тэгээд Бурханаас хүн бүрд магтаал ирэх болно.” (1Коринт 4:5) хэмээн ятгажээ.

Бид зөрчил дунд Бурханы цэц ухааныг хайгаад, эцсийн дүнд аварч, шүүх нь Бурханы л мэдэл гэдгийг мэдээд, тайтгардаг. Хүн Бурханы удирдлага дор байвал гомдол мэдүүлэлгүйгээр, хонзон нэхэлгүйгээр, хатуу шийтгэл шаардалгүйгээр зөв байдал, өршөөлөөр хандаж чадна. Бид Бурханаас гуйвал, Түүний үйлдэл зөвлөгөөг харж чадна. Эцсийн эцэст Бурхан л бидний мөнхийн Дагуул, мөнхийн Зөвлөх.

Эзэн минь, дарамтыг авсанд баярлалаа. Зөрчил дунд Танд л итгэж, Таны удирдлага дор байдаг учраас, баярлалаа.

Би хүчирхэг

БИ ЗӨРЧИЛ ДУНД ШУДАРГА БУРХАНД
ИТГЭХДЭЭ, ХҮЧИРХЭГ.

ХОВ ЖИВЭЭС ХАМГААЛАГДСАН

Илүү үгтэн нууцыг задруулах.

Итгэлт сүнстэн хэргийг нууцлах.

СУРГААЛТ ҮГС 11:12-13

С айхан яриа өрнөж байтал, нэг нь хов эхлүүлчихэв. Таслан зогсоох хүн гарах нь уу хэмээн бусдыгаа гүйлгэж харна. Гэвч сонсох тусам, таслан зогсоох улам л хэцүү болно. Чи өөрийгөө төлөвшсөн, ухаантай хүн болохоороо, ийм мэтийн ярианд автахгүй гэж бодоод... дүнхийж сууна. Гэхдээ хов живийн хүч тухайн үедээ биш, бүр дараа нь ажилладаг увидастай. Хожим нөгөө ярианы сэдвийн гол “баатартай” тааралдахдаа, чи түүнийг өөр нүдээр харна. Эсвэл нэрийг нь сонсуутаа л үйлдлийг нь төдийгүй, сэдэл санааг нь хүртэл шүүмээр санагдана. Хов жив ярихгүй байхаас гадна сонсохгүй байх нь том даваа (Сургаалт үгс 17:4). Энэ нь ялангуяа өдөр тутам олон нийтийн сүлжээн дээр маш бодитой тэмцэл болдог.

Хов живд оролцохгүй байвал, хов жив яахыг мэдэх хэрэгтэй. Мирриам Уэбстер хов живийг “бусдын хувийн юмуу цочир мэдээг илчилдэг зуршилтай хүн” гэж тодорхойлдог. Хов жив нь өрөөлийн нарийн нандин мэдээллийг тухайн үйл явдалд шууд оролцоогүй хүмүүст дэлгэх дадал хэвшил ажээ.

Гэхдээ хов жив ярьдаг хүн үүнийгээ ямар ч бодолгүй үйлддэг. Үүнийгээ гэм хоргүй сэдлээс авахуулаад нэр хүнд олж, чухал хүн болох гэсэндээ юмуу нөгөө хүний нэр төрийг унагах гэсэн хорон санаагаар ч үйлдэж болно.

Хов жив нь харилцааг хордуулж, үнэнийг сүйтгэдэг. Хов жив нь итгэл найдварыг уландаа гишгэлдэг. Далд хадгалах ёстой нууц, явдал, зөрчлийг нь хэн нэгний ашиг сонирхлын төлөө ахин дахин давтах. Хамгаалалт, байр суурь, нөлөөллийн төлөө нөгөө хүнээ л худалдах үйлдэл юм даа. Зарим нь нөгөө хүнийг үгээрээ шүүх маягаар шийтгэх юмуу байх ёстой байранд нь тавьдаг.

Гэхдээ ингэх нь бидний ажил биш юм. Ариун Сүнс бидний зүрхийг зөөллөж, бусдын талаар ярьж байгаагаар минь бидний зүрхийг шалгадаг. Дайсан чамайг хэл амаа сахиж байгааг мэдэхээрээ, сонсож, үзэж, уншиж байгаа зүйлээр чинь унагах гэж оролдоно. Бүү зөвшөөр. Хов живээс сэргийлснээрээ, зүрхээ хамгаална. Ийм төрлийн харилцаанаас биеэ татаж сурахдаа, иймэрхүү нөхцөлд хэрхэн үйлдэх тал дээрээ Ариун Сүнсний цэц ухаанд найдаж сурцгаая. Заримдаа зүгээр л босоод яваад өг. Амаараа харанхуйн замаар бүү ор. Ямар ч хүний талаар дураараа ярихыг хэнд ч бүү зөвшөөр. Харин залбир, хайрла тэгээд шаардлагатай бол шууд хэл.

*Эзэн минь, зүрхээрээ татагдахгүйн тулд ам, чихэн дээр
минь сахиул тавиач. Итгэл үнэмшил дээрээ бат зогсож,
амьдралаа цэгцэлж, сүнсээ нягтлахыг зааж өгөөч.*

— Би хүчирхэг —

БИ ХОВ ЖИВ БУС, АМИЙН ҮГИЙГ
ЯРИХДАА ХҮЧИРХЭГ.

ЭВТЭЙ АМЬДРАХ

Өөр хоорондоо нэг санаатай байцгаа. Ухаан бодолдоо ч бүү ихэрх. Харин төлөв даруу байхыг эрхэмлэ. Өөрөө өөрийгөө ухаалаг бүү болго. Хэнд ч хэзээ ч мууг муугаар бүү хариул.

Бүх хүний өмнө юу нь зөв болохыг л харгалзан үзэж бай.

РОМ 12:16–17

Хоорондоо эв нэгдэлтэй амьдрах гэдэг нь Христийн бие дотор бусадтайгаа нөхөрлөл, дуу хоолойгоороо харилцан түшилцэж оршихыг хэлнэ. Эв нэгдэлтэй амьдрах энэ тушаал нь чуулганы гадна ч, дотор ч хүчинтэй. Христийн дотор бид бүгдээрээ нэг гэдгээ ойлгосон нөхцөлд миний өмч гэж бодож байгаа ялгарлаа хойш тавихад хялбар болно. Үүнийг ойлгосон нөхцөлд бид Бурханд үйлчлэх амьдралынхаа туршид амьдралын янз янзын улиралдаа яваа, санаанд оромгүй хүмүүстэй нөхөрлөнө. Өнөөдрийн эшлэл бидэнд биеэ тооосон, бардам зан нь биднийг бусадтайгаа эв түнжингүй амьдрахад хүргэдгийг анхааруулж байна. Биеэ тоох нь бидэнд мууг муугаар хариулах эрх олгодог. Гэтэл Бичээс өөрийг заадаг. Христийн дотор бид зарц хүний мөн чанарыг өмсдөг. Энэ нь зөвийг үйлдсэнээрээ зөвөөр амьдрахын үлгэр жишээ болж амьдарна гэсэн үг.

Бид бардам, хайхрамжгүй занг хойш тавьснаараа, нэг хацрыг минь алгадсан ч нөгөө хацраа тавьж өгдөг, цамцыг минь авах үед хүрмээ ч өгдөг бас хоёр бээр ч явдаг. Бусдынхаа тусын тулд, бусадтайгаа эв этэй амьдрахын төлөө зөвийг үйлдэх үүднээс явах

ёстойгоосоо ч хол явна. Энэ нь Аавдаа хүүхэд шиг найдах явдал юм. Аав л түүхийн бүх хуудсан дээрх бүх мөр, бүх талыг мэднэ. Аав найдвартай, үнэн Эх зохиолч.

Бид цөвүүн цаг үед аж төрж байгаа хэдий ч, хүмүүс эелдэг зөөлөн чанараа алдаагүй байна. Би өдөр тутамдаа хүмүүст анхаарал тавьсаар. Магтаал хайрладаг, тусалдаг, ядахнаа зүгээр л мэндэлдэг. Нөгөөтэйгүүр олон хүн өдөр тутам харцаа эргэлдүүлсээр, чихэвч зүүсээр амьдарч байна. Харин би чамайг хүчтэй бас эелдэг байхыг уриалъя. Арьс өнгөөр ялгаварлах, амьдралынх нь нөхцөл бололцоогоор ялгаварлах явдлыг няцаагаад нэмэргүй. Харилцан зүтгэлтэй байя. Зүрхэнд чинь нуугдаатай аливаа шүүмж болгон нь илчлэгдэхийн төлөө залбир. Ямар нэг юм байвал, гаргаж ирээд, гэмш. Өөрийгөө зөвтгөх юмуу шалтаг тоочигч бардамналын алив хаалт бүрийг авч хаяад, даруу занг нөмөр.

*Аав аа, бусадтайгаа эв эетэй бөгөөд амар жимэр
амьдрахын төлөө амьдралд минь байгаа алив
бардамнал, шүүмж бүрийг илчлээч.*

Би хүчирхэг

БУСАДТАЙГАА ЭВ ЭЕТЭЙ
АМЬДРАХДАА, БИ ХҮЧИРХЭГ.

БУРХАНЛАГ ХАМТ ОЛОН ДУНД ӨСӨХ

Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн.

ИОХАН 15:14

Христийн найзууд л чамд жинхэнэ нөхөд болно. Тэд сайн ч амьдарна, сайн ч ярина. Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн. (Иохан 15:14). Есүс энд тодорхой хэлжээ. Нөхөд тушаалыг сахиж, бусдыгаа ч ижил зүйлд уриалдаг. Тэд Есүст хайртайгаа батлах гэж тушаалыг сахидаг бус, харин хайртай учраас л сахидаг.

Жинхэнэ нөхөд чамайг ямагт өндөр өргөж, Эзэнд таалагдах арга замаар амьдрахад уриалдаг. Тэд чамтай цаг өнгөрөөж, чиний өсөлтөд анхаарна. Тэд чамтай хамт уйлж, инээнэ. Амьдралын улирал та нарыг салгаж болох ч, та нар зүрхний нөхөд учраас, учран золгохдоо ч урьдын адил тэврэлдээд л уулзана. Жинхэнэ нөхөд чамайг өсчихлөө, цойлчихлоо, амжилтанд хүрчихлээ гэж шээс алдалгүй, өөрөө хүрчихсэн юм шиг л өмнөөс чинь хөл алдана. Бид бүгдэд өмнөө, хойноо, дэргэдээ байлгах бүсгүйчүүдийн бүл хэрэгтэй. Залуу охидод ч тэр, настай бүсгүйчүүдэд ч тэр.

“Ганц хүнийг хэн нэг нь дайран дийлж чадах бол хоёр нь нэгийг няцаана. Гурамсалж гөрсөн сур тийм ч амар тасардаггүй. (Номлогчийн үгс 4:12). Найзууд чамтай хамт, чиний төлөө залбирлаар тулалддаг. Хүч дутах үед чинь зуучлан залбирч, хүчээ зээлдүүлдэг. Найзууд Есүсийн нэрээр цугларах үед “...Би тэдний

дунд байна” (Матай 18:20). Энэ болбоос юугаар ч нөхөшгүй, ер бусын ерөөл болой.

Найзууд Бичээсийг самнаж, бие биеийнхээ доторх Ариун Сүнсний хүчийг биширдэг. Урамтай бай. Бурхан газар дээрх охидынхоо дотор гайхамшгийг үйлдэж байна.

Найзууд санал зөрөх үе байдаг ч, ингэлээ гээд салахгүй. Бид хамт олон дунд өсөхөөр бүтээгдсэн болохоороо, бие биеэ хамгаалж, халхал. Өсөлт өрнөж буй газар бүрт алдаа, эндэл заавал гардаг ч, бие биедээ итгэмжтэй байхад, муу биш, сайн сайхан зүйл л ирнэ.

Амьдралд чинь ийм харилцаа байхгүй бол, зориудаар бий болгохын төлөө яв. Бурханлаг барилдлагыг чинь өсгөх шинэ арга замыг харуулж өгөхийг, удирдамжийг Бурханаас гуй. Зарим хүн ингэтэл бүрэн үнэнч зориулагдахыг хүсдэггүй болохоор, эхэндээ айна. Эрсдэл гаргаж, гараа сунга. Хамтдаа залбирдаг ч уу, суралцдаг ч уу, зугаацдаг ч уу - хатагтай нартай өнгөрөөх энэ цаггүйгээр та зүгээр л амьдарч чадахгүй.

Есүс ээ, би жинхэнээсээ нөхөрлөж чаддаг, жинхэнэ найз баймаар байна. Хаана яаж барьж байгуулахыг харуул.

— Би хүчирхэг —

ХРИСТИЙН ДОТОР ЭГЧ ДҮҮСТЭЙГЭЭ
ХАМТ ЗОГСОХДОО, БИ ХҮЧИРХЭГ.

Мулдаанг хүчирхэг

СЭРЭМЖТЭЙ БӨГӨӨД АНХААРАЛТАЙ БАЙХ

*Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй
бай. Та нарын өрсөлдөгч болох диавол
нь хэн нэгнийг залгихаар хайж буй
архирах арслан мэт гэтэн явдаг.*

1 ПЕТР 5:8

Дайсан сэрэмжгүй, унтаа байхад минь үмхэхээр шиншилж явна. Өөр орчуулга дээр эрүүл бөгөөд сэрэмжтэй гэдэг үгсийг хэрэглэдэг (КэйЖэйВи). Эрүүл гэдгийн эсрэг үг нь согтуу. Согтуу хүн эргэн тойрноо мэдэхгүй. Тэдний ойлголт, хараа нь бүрэлзэж, хариу үйлдэх хугацааг нь сааруулж, учирлаж ухах ухааныг нь бусниулдаг. Сэрэмжтэй бөгөөд сэргэг байх нь хамгаалалттай, сэрүүн, анхааралтай байхыг хэлнэ.

Петр дээр Диаволыг цулах идшээ хайн, архиран шиншлэх арслантай зүйрлэсэн. Диавол биднийг шууд идчихгүй ч, өөр арга замаар цусална. Бодитоор идчихгүй нь гэж баярлах хэрэггүй. Диавол бидний баяр хөөр, амар тайван, амралт, хүчийг сорж, эрүүл мэнд, харилцаа, бодол санаа руу довтолдог. Тэр эргэлзээ самуурал үүсгэхийн тулд ялаар архирдаг. Сатаны улайрсан, цуцашгүй мөрдөн

мөшгилтийг ойлгуулах үүднээс Бурхан харгис өлөн арслангийн дүр зургийг ашиглажээ. Арслан идшээ шиншилдэг шиг, дайсан өчүүхэн л гомдол, хорслын үнэрийг авдаг.

Арслан цусанд дуртай, цус нь шархнаас л гардаг. Бид өвчин зовиурыг үл хайхраад л, өнгөлөн далдлаад л, шархнаасаа цусаа гоожуулаад л яваад байж болохгүй. Сэрэмжтэй, сэргэг байхын нэг утга нь шархаа Ааваараа эдгээлгэх явдал юм. Аав маань бидний шархыг боож өгөөд, Ариун Сүнснийхээ хүчээр эдгээнэ. Аминд халгүй, жижиг шархандаа ч анхаарцгаая. Эртхэн анхаарбал, шөнийн манааны цагаар ойлголт минь ч, хараа минь ч тод байна.

*Аав аа, дайсны мөрдлөгө шиншилгээнд
сэрэмжтэй байхад туслаач. Шархыг минь
эдгээж туслаач. Хамгаалаач, эдгээгээч, тулаанд
биеэ хянаж, сэрэмжтэй байхад туслаач.*

Би хүчирхэг

БИ СЭРЭМЖТЭЙ БАЙЖ, НООТОЙ ЮМСЫГ
АНХААРАЛДАА АВАХ ҮЕДЭЭ ХҮЧИРХЭГ.

ХҮЙС ХООРОНДЫН ЭНХ ТАЙВАН

*“Би тэр эмэгтэй та хоёрын хооронд, Бас чиний үр,
тэр эмэгтэйн үрийн хооронд дайсагнал үүсгэнэ. Тэр үр
толгойг чинь бяцалж, түүний өсгийг чи няцална.”*

ЭХЛЭЛ 3:15

Хаашаа ч харсан эрчүүд эмэгтэйчүүдийн хооронд байлдаан болсоор. Хөмсгөө зангидаж, далхалзсан эрчүүд, шаралхаж, зэхэлзсэн хүүхнүүд нэг нэгнээсээ учруулсан шархаа эдгээж өгөхийг нэхэмжлэн шаардав ч, хэн нь эдгэрч ч, эдгээж ч чадалгүй явсаар. ... Үнэндээ Бурхан л ганцаараа биднийг сэргээж, мөрөөдлийн маань цэцэрлэгт хүрээлэнд хүргэж чадна.

Цэцэрлэгт могой Еваг онилсон цагаас могой - эмэгтэй хоёрын хооронд зөгнөсөн тулаан одоо ч өрнөсөөр (Эхлэл 3:15). Бурханы охид минь, Адамын газрын хөвгүүд та нарыг энэ могойноос аварч чадахгүй. ...Тэнгэрийн Ханхүү л аварна. Могой хэзээд нэг л зорилготой: Евагийн охидыг нэр төр, хүч, хүндэтгэлээс нь тайчаад, хүчгүй гэж дуудах. Эмэгтэйчүүд нэр төрөөсөө нүцгэрч, доош орох үед эрчүүд ч ялгаагүй шившиглэгдэнэ. Учир нь эмэгтэй хүн эр хүний алдар (1Коринт 11:7). Энэ зөрчлийн ард үнэндээ юу байгааг хар: Могой чиний хүч, нэр төр, хувцсыг тайчиж байна!

Үүнийг хараад хилэгнэх хэрэгтэй. Тэгсэн цагт л жинхэнэ дайсантайгаа тулалдаж, жинхэнэ итгэмжит Хаантайгаа бүрэн эвлэрнэ. Тэр цагт л чи чармаа нүцгэнээ сүр жавхлангаар халхална. Тэр цагт л чи эрчүүдтэй юмуу эр нөхөртэйгээ бус, харин сэтгэлийнхээ

дайсантай тулалдаж байгаагаа мэднэ. Хар дарсан зүүднээсээ сэрээд, мөрөөдлөө сэргээхийн төлөө дуугарч сурах хэрэгтэй.

Би чиний сэтгэлийн гүний хашхирааг л хэлээд байна. Чи эр хүний өгч чадахгүй гүн гүнзгий хайр, дотносол, нэгдлийг үгүйлж байгаа. Чи газраас олодошгүй, аюулгүй тэнгэрийг үгүйлж байгаа. Чи тэнгэрийн Ханхүүгийнхаа хайрыг үгүйлж байгаа. Тэгээд итгэх эсэхээс чинь үл хамааран, би чамд нэг нууцыг хэлмээр байна. ... Ханхүү чинь ч чамайг хүсч байгаа. Энэ хүслийн үрийг Тэр Өөрөө л чиний зүрхний цөмд суулгасан, зөвхөн Тэр л хангаж чадна.

Бид буруу газраасаа ханамж горилох бүрийдээ, гонсойж л хоцордог. Эрчүүд чиний асуудал ч, хариулт ч биш! “Харцаа би уулс өөд өргөнө. Хаанаас надад тусламж ирэх вэ? Тэрхүү тусламж минь тэнгэр газрыг бүтээгч ЭЗЭНээс.” (Дуулал 121:1-2). Тэгсэн цагт л бид баяр хөөрийнхөө ундаргыг олж, хүч, хүндэтгэлээ сэргээнэ.

*Аав аа, буруу дайсантайгаа тулалдаж, буруу газраасаа
аз жаргалыг хайх үед минь Тан руу харахыг сануулаач.
Та л миний Аврагч, баяр хөөрийн Эх ундарга!*

Би хүчирхэг

БИ БУРХАНЫ ХӨВГҮҮД, ОХИДЫН ХООРОНД
ЭНХ ТАЙВНЫГ ТОГТООХДОО, ХҮЧИРХЭГ.

ҮЛ УУЧЛАЛЫН ТУЛААН

...нэгэн хаан... тооцоо хийж эхлэх үед арван мянган талантын өртэй нэгнийг түүнд аваачив. Харин түүнд төлөх юм байхгүй тул эзэн нь түүнийг эхнэр, хүүхдүүдийнх нь хамт хамаг юмтай нь худалдаад өрийг нь барагдуулахыг тушаажээ. Зарц сөхрөн унаж түүнд мөргөөд “Эзэн, намайг тэвчиж хүлцэнэ үү. Би танд бүгдийг төлнө” гэж гуйхад тэрхүү зарцын эзэн ихэд өрөвдөн түүнийг суллаж, өрийг нь хэлтрүүлжээ.

МАТАЙ 18:23–27

Уучлал нь эдгэрлийн үйлдэл юм. Уучлал биднийг хорслоос, ялаас чөлөөлдөг. Нөгөөтэйгүүр уучлал нь сүнсний тулааны амин түлхүүр юм. Жинхэнэ тулаан нь чамд хор хохирол учруулсан нэгэнтэй бус, харин сэтггэлийн мөнхийн дайсантай өрнөдөг. Бид уучлахдаа, дайсны нэгэн зэвсгийг хураадаг. Учир нь үл уучлал дотор амьдардаг хүн довтолгооны бай болно.

Өнөөдрийн хэсэг биднийг үл уучлалын харанхуй хөндий рүү өнгийлгөж байна. Өөрийгөө зарцын байранд тавь. Та төлж чадахгүй өрөө төлөх ял үүрэн, хааны өмнө албадан авчруулжээ. Хорвоо хөмрөн, нүд чинь харанхуйлан, эцсийн горьдлогоо хааныхаа өршөөлд даатган, яаж ийгээд төлнө гэдгээ ахин дахин амлана. Гэтэл Хаан чамд өршөөлөө үзүүлэв. Хаан чинь чамайг яагаад ч, ийгээд ч төлж чадахгүйг мэдэж байгаа учраас, бүх өрийг чинь тэглэнэ. Чи даашгүй ачаанаасаа чөлөөлөгдөв! Хааны аврал өршөөлд талархаад барашгүй.

Гэтэл Хааныхаа өршөөлийн жишгийг дагахын оронд чи гараад, чамд өртэй нөхдийг санаад, уулгалан дайраад, чамтай л адил арга нь барагдсан хөөрхийсээс өрөө төлөхийг шаардана (Матай 18:28-31). Уучлагдсан зарцын энэ авир үйлдлийг хаан нь олж мэдээд: “Ёрын муу зарц, чи надаас гуйсан тул би бүх өрийг чинь хэлтрүүлсэн. Би чамайг өршөөсний адил чи бас анд чинь болох тэр зарцыг өршөөх ёстой байсан бус уу?” гэдэг! (Матай 18:32-33).

Энэ сургаалт үлгэр дээрх хаан нь бидний тэнгэрийн Аав бол, зарц нь бид, бусад зарц нар нь бидний итгэлийн ахан дүүс бөгөөд залхаан цээрлүүлэгч нь бидний сэтгэлийн дайсан юм. Бид үл уучлахдаа, бусдыгаа ял, буруутгалын гинжээр хүлээд, эргээд өөрсдөө ч хэзээ ч төлж чадахгүй зүйлээ төлөн төлтлөө яргачны гарт тушаагддаг. Энэ бүхэн нь нэг талаараа газар дээрх тамыг дүрсэлж байгаа гэх үү. Бусдыг үл уучилсан зүйлдээ өөрөө тамлуулж яваа хүмүүсийг бид бүгдээрээ л мэднэ. Ингэж авирлах нь дайсны талд ажиллаж байгаатай л ижил. Бие биеийнхээ гинжийг тайлах цаг нь болсон.

*Эзэн минь, надад үл уучлалаараа гинжилсэн хүн байвал,
илчилж өгөөч. Та намайг сулласан шиг би ч түүнийг суллая.*

Би хүчирхэг

ӨӨРӨӨ ХААНААРАА УУЧЛУУЛСАН ШИГЭЭ
БУСДЫГАА УУЧЛАХДАА, БИ ХҮЧИРХЭГ.

ЧИНИЙ ХОРОГДОХ ГАЗАР

“Тэрээр тэнгэрэлч нартаа

Чамайг хамгаалах талаар тушаана.”

ЛУК 4:10

Би тэнгэрийн хамгаалалттай гэдгээ байнга мартчихдаг зантай. Гэтэл Давид маш үзэсгэлэнтэй дүрслэл хэлсэн: “Намайг өршөөгөөч, Бурхан, Намайг өршөөгөөч Учир нь сэтгэл минь Таны дотор хоргодож байна. Таны жигүүрийн сүүдэрт би Хорлол өнгөртөл хоргодно” (Дуулал 57:1).

Бурхан - бидний хамгаалалт. Миний өөрөө өөрийгөө хамгаалах чадвар тун горьгүй болохыг би аль дээр ойлгосон. Бурхан руу гүйсэн нь л дээр. Худал хуурмагаар яллуулж, гүтгүүлж, шударга бус хандуулсан бол, утсаа тавиад, компьютераа хаагаад, хөгжмөө чангалаад, магтан хүндэтгэж эхэл. Юу хийхээ мэдэхгүй үед магтан хүндэтгэх шиг зөв хариу үйлдэл үгүй. Амьдралд дийлдээд ирэх үед ямар ч нөхцөл дунд Бурханы оршихуйд чи хэзээд хорогдох газартай.

Өөрийгөө хамгаалахаар оролдуулах дайсны элдэв урхинд орох аваас, зүгээр л бүтэлгүйтнэ. Шуурга өнгөрч, тэнгэр цэлмэтэл Бурхан биднийг Өөрийнхөө дотор хорогдохыг урьдаг.

Бурханы далавчин дор хорогдох. Өшөө авалт нь нөмөр болж байгаа мэт хуурдаг ч, тэнд нөмөр байхгүй. Бурханы оршихуй руу орохын тулд иймэрхүү хуурамч нөмрийг хойш тавих хэрэгтэй. Зугтах, өөрөө өөрийгөө эмнэх юмуу үгүйсгэх нь түр зуурын аргацаа

бөгөөд “100 хувийн баталгаатай юмуу өөрөө өөртөө туслах” бүх арга нь Бурханы дэргэд юу ч биш юм.

Тэгэхээр, аюул юу юугүй хөмрөх гэсээр айсуй юмуу тал бүрээс чинь отох үед баярла. Бурхан чиний талаар тэнгэрэлч нартаа тушаал өгөөд зогсохгүй, Өөрийн биеэр туслахад бэлэн байна. Дайсан дайрахад, “Тэднээс битгий ай! ЭЗЭН Бурхан чинь та нарын төлөө тэмцэгч...” хэмээн Дэд хууль 3:22 дээр амласан билээ.

Ахадсан тулаанд орохдоо Бурхандаа л ойр байгаарай.

*Эзэн минь, Та миний хамгаалалт. Би
Танд ойртож, айх үед минь миний төлөө
тулалдана гэдэгт итгээж байна.*

Би хүчирхэг

БУРХАНЫ ЖИГУҮРИЙН СҮҮДЭР ДОР АЮУЛГҮЙ
БӨГӨӨД ХАМГААЛАГДСАН УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

БИД ТУЛАЛДАЖ БАЙНА

*Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш,
харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид,
эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь
ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ.*

ЕФЕС 6:12

Дайсан биднийг үл үзэгдэх харанхуйн хүчнүүдтэй биш, харин нүдэнд харагддаг хүмүүстэй тулалдаж байна гэж мэхэлдэг. Үүнийг Паул бидэнд бодит байдлыг ойлгуулах үүднээс л хэлснээс биш, айлгах гэж хэлээгүй. Бидний хувьд хүнийхээ хүчээр тулалдаж чадахгүй, харанхуйн бүхэл бүтэн талбар бий. Паул цааш нь “Тиймээс тэр цөвүүн өдөрт, эсэргүүцэх чадвартай байж бүхнийг гүйцээн бат зогсохын тулд Бурханы өвч зэвсгийг ав.” (Ефес 6:13) хэмээн үргэлжлүүлжээ.

Бурхан бидэнд бат зогсоход хэрэгцээтэй бүхнийг хэдийнээ өгсөн. Паул бидэнд өөрийгөө бүрэн хуяглахыг ахин дахин үүрэгдэж байгаа нь зэр зэвсэгтээ хаа хамаагүй хандахгүй байхыг сануулах шиг. Хагас дутуу хувцаслаж, хуяглачихаад ялна гэж горьдолтгүйг л хэлээд байх шиг. Бат зогсох гэж юу гэсэн үг вэ? Үл ухрах байршлаа эзэлнэ л гэсэн үг. Паул цааш нь “Ингэхдээ та нар бэлхүүсээрээ үнэнийг бүсэлж, зөвт байдлын хуягийг өмсөж зогс. Амар тайвны сайнмэдээний бэлэн байдлыг хөлдөө өмс.” (Ефес 6:14-15) гэжээ.

Бид үнэнийг бүслээд, зүрх тэргүүтэй амин эрхтнээ Христийн зөвтгөлөөр хааж зогсоно. Бидний амьдран суугаа дэлхий амар

тайвнаар ангаж байна. Амар тайвны суурь нь үнэн бөгөөд зөвт байдал. Үнэнийг хөсөрдүүлснээр байршлаа алдаж, хэмжээнээсээ сох дутахад хүрнэ. Бид энх тайвнаар тулалдахдаа, хүчирхэг байна. Христийн дотор энх тайван нь шуургыг намжаах, зүрхийг эдгээх, сэтгэлийг сэргээх арга зам болно.

Тэнгэрийн Бурхан Аав минь, Таны доторх энх тайвнаар тулалдахыг зааж өгөөч. Намайг буулт хийхээс минь хамгаалахын тулд Таны Үгийг уншиж байхад үнэнээ сэтгэлд минь зангидаарай.

Би хүчирхэг

ҮНЭН, ЗӨВТ, ЭНХ ТАЙВАН ДОТОР
ЗОГСОХДОО, БИ ХҮЧИРХЭГ.

БАМБАЙ БА СУМ

*Энэ бүгд дээр ёрын муу нэгний бүх галт сумыг
унтрааж чадах итгэлийн бамбай...*

ЕФЕС 6:16

Ёрын муугийн зүгээс биднийг онилж харвадаг галт сум бүрээс хамгаалдаг бамбай бидэнд өгөгдсөн. Еврей 11:1 дээр “Итгэл бол найддаг зүйлсийн маань бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн.” гэдэг. Бид мэдээж биднийг хамгаалдаг энэ итгэлийг харж чадахгүй ч, хөгжүүлж чадна. Итгэл нь Бурханы Үгийг сонсож, сурахаас эхлэх. Би итгэлийг хүчээр төсөөлдөг. Итгэл өсөх тусам, хамгаалалт минь тэр хэрээрээ нэмэгдэнэ. Итгэл нь бидний хүлээн авсан хэмжээгээр эхэлж болох ч, ямагт бидний өгч чадах хэмжээнд тултал өсөх ёстой.

“...авралын дуулга болон Бурханы үг болох Сүнсний сэлмийг ав.” (Ефес 6:17). Аврал нь бидний оюун санааг бүрхэгч дуулга юм. Би дөнгөжхөн аврагдаад байхдаа, муу муухай бодол оюун санааг завхруулан орж ирдэг байлаа. Би ч хаанаас яахаараа ийм бодол төрдөг байна аа гээд л аймшигт автана. Тэгээд аврагдсаныхаа дараа тэдгээр бодол надаас биш гэдгийг таньдаг болсон. Аврал нь бидний оюунд амар тайвныг авчирдаг бөгөөд тамласан, зовоосон бодол дайрах үед бид илдээ сугална! Бурханы Үг нь бидний Сүнсний илд мөн. Диаволыг өдөх үед Есүсийн үйлдсэн шиг бид ч сэтгэлийн дайсан руу бичмэл үгийг хэлэх ёстой. Тэр бидний амар тайван руу

дайрах үед Исаиа 26:3 дээрх Бурханы үгийг тунхаглана: “Танд итгэдгийн улмаас санаа бат хүмүүнийг Та амрын амар байлгана.”

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, намайг
дайсны халдлагаас хамгаалдаг итгэлийн
бамбай, оюун дахь амар тайван, гарт минь
байдаг Сүнсний илдэнд тань баярлалаа.*

Би хүчирхэг

БИ ҮГИЙГ УНШИЖ, ҮГЭЭР ЯРЬЖ,
АМЬДРАХДАА ӨСДӨГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ЖИНХЭНЭ ДАЙН

*Учир нь бид махбодод алхдаг ч,
махбодын дагуу дайтдаггүй.*

2 КОРИНТ 10:3

Бид дэлхий дээр амьдарч байгаа хэдий ч, дэлхийн арга замаар дайтахгүй. Тэгэхээр, гол асуудал нь дайтах дайтахгүйдээ бус, харин хэрхэн дайтахад л оршино. Хамаг учир нь тулааны цаад “яагаад” буюу бидний сэдэлд оршино. Бид зүгээр л эсэргүүцэж тулалдаад байх бус, харин *төлөө* байлдах ёстой. Түүнчлэн бид энэ дэлхийн хуулиар дайтаж байгаа хүмүүсээс хавьгүй гүн үнэнийг мэднэ: Хүмүүс хэзээ ч бидний жинхэнэ дайсан байгаагүй. Заримдаа үнэн нь худал юм шиг санагдах үе байдгийг би мэднэ ээ. Гэхдээ Бурхан бүх хүнд хайртай. Есүс хүмүүстэй дайтахаар бус, аврахаар ирсэн. Бид олзны хүмүүстэй байлдах бус, тэднийг чөлөөлөхийн төлөө байлддаг. Бид шоронг нураах бус, харин хүмүүсийг хорьж байгаа хүчин зүйлстэй тэмцдэг. Учир нь: “Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм” (2Коринт 10:4).

Бидэнд буу шийдэм бус, харин тэнгэрийн зэвсэг зөвшөөрөгдсөн. Тэнгэрийн зэвсэг нь бүр ч хүчирхэг учраас, бүр ч болгоомжтой хэрэглэх хэрэгтэй. Үг л ерөөх юмуу хараах хүчтэй байхад, үйлдэл нь бүр ч хүчтэй байх нь тодорхой. Дэлхийн зэвсэг нь алдаг бол, тэнгэрийн зэвсэг нь амь өгөх хүчтэй. Дэлхийн зэвсэг нь хүмүүс, үндэстэн, соёлыг хагаралдуулдаг бол, залбирлын зэвсэг нь Бурханы хаанчлалын захиргаан дор биднийг нэгтгэдэг. Дэлхийн зэвсэг нь бидний дайсагнадаг хүмүүсийг шархлуулдаг бол, хоёр талдаа иртэй

тэнгэрийн илд нь сэргээлт, эдгэрлийн төлөө үнэн, худлыг ангилдаг. Дэлхийн зэвсгийг хүн өрөөлийг айлган сүрдүүлж, мөхөөх үүднээс бүтээсэн бол, тэнгэрийн зэвсэг нь айдаст боолчлуулсан олзны хүмүүсийг тэнгэрийн дуудлага дотор нь зорилготой амьдруулахын төлөө урмаар бөхлөхөөр тэнгэрт бүтээгдсэн буюу. Бид олзны хүмүүсийг чөлөөлөхийн төлөө цайзыг нураадаг.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, тулаанд
орох бүрийд юуны төлөө тулалдаж
байгааг минь харуулаач. Ариун Сүнс
минь, хоригдлыг шархдуулах бус, цайзыг
нураах ёстойг минь сануулаач.*

Би хүчирхэг

БИ БУСДЫГАА ЧӨЛӨӨЛӨХИЙН ТӨЛӨӨ
ТУЛАЛДАХДАА, ХҮЧИРХЭГ.

ГЭРЭЛ ДОТОР ТУЛАЛДАХ

Бурхан бол гэрэл, Түүний дотор харанхуй огт үгүй...

1 ИОХАН 1:5

Иошуа ном дээр Бурханы хүмүүсийн дайсантай хийсэн хүчирхэг тулаан гарна. Эзэн Өөрөө хүмүүстэйгээ мөр зэрэгцэн тулалдсан. Гэтэл тэдэнд гэрэл хэрэгтэй байгааг тулааны явцад удирдагч Иошуа мэдээд: "...нар минь, Гибен дээр, өө сар минь, Аиалоны хөндийн дээр тогтооч гэв. Тийнхүү ард олон дайснаасаа өшөөгөө автал нар тогтож, сар эс хөдлөв. ...нар тэнгэрийн тэхий дунд тогтож, Бүтэн өдрийн турш огт хэвийсэнгүй. ...Учир нь ЭЗЭН Израилийн төлөө дайтав!" (Иошуа 10:12-14).

Тулаанд амин чухал байсан гэрлийг нь Бурхан ч ер бусын гайхамшгаараа хангаж өгөв. Гэрэлтэйд хэн нь манай тал, хэн нь дайсан болох нь тодорхой танигдана. Харин харанхуйд найзаа дайсантайгаа андуурч, эрэмбээ алдах амархан. Үүний нэгэн адил сүнсний тулаанд ч гэрэл хэрэгтэй! Бурхан ч бидэнд тэр гэрлийг харамгүй өгдөг. Бурхан бидний тэнгэр дэхь нар бөгөөд биднийг самууруулж, эрч хүчийг минь сорогч харанхуйг сарниаж байдаг. "Үзэгтүн, газрыг харанхуй, Хүмүүсийг гүн харанхуй бүрхэнэ." Гэвч ЭЗЭН чиний дээр мандаж, алдар нь чиний дээр үзэгдэнэ." (Исаиа 60:2). Бурханы Хүү - Есүс Эзэн маань бидэн дээрээс мандаж байгаа учраас, бид ч Израилийн хүүхдүүдтэй адил харанхуйгаар хүрээлэгдэхгүй. Бидний Бурхан боломжгүй зүйлийг шийдвэрлэж,

“дэлхий болоод хүмүүс дээр харанхуй буувч, Би чамайг хучигч гэрэл учраас бүү ай” гэж хариулдаг.

Тулалдаж байхдаа чамайг бүсэлсэн харанхуйг бус, өөрийнхөө доторх гэрлийг хараарай. Өдөржин, шөнөжин үргэлжилсэн ч хамаагүй, Бурхан чиний төлөө дээрээс гэрэлтсээр, сүүдрийг хөөсөөр байна.

*Эзэн Бурхан минь, миний доторх
Таны гэрлээр би хүчирхэгждэг.
Тулаан дуусан дуустал дотроос
минь гэрэлтсээр байгаарай!*

Би хүчирхэг

БУРХАН МИНИЙ ГЭРЭЛ УЧРААС, БИ
ТУЛАЛДАХДАА ХҮЧИРХЭГ.

ШИЙДЭМГИЙ

*“...өөрсдийгөө жагсаан, зогсоож, та нарт
зориулсан ЭЗЭНий авралыг харагтун”*

2 ШАСТИР 20:17

Амьдралын аянд буугаад өгмөөр үе олон. Зүгээр л “больё, цаашид тэсэхгүй нь” хэмээн шалдаа буумаар үе бишгүй тохионо. Бууж өгсөн хүн, ялж гарсан хүнийг ялгаж өгдөг ганц л чанар байдаг нь тэдний өндийх чадвар юм. Зүгээр л дайснаасаа илүү тэссэнээрээ тулаанд ялах нь олонтаа. Бид бүгдээрээ л нокаутанд орж байсан. Дайсны цохилтыг тааварлашгүй ч, цохиулчихаад босоод ирэх эсэх нь чамаас л хамаарна. Бяр амтагдахгүй байсан ч, итгэл дотроо л явна гэж шийдээрэй. Хүн хүчээ ашиглахаас нааш хэр хүчтэй болохоо мэдэхгүй болохоор, мэдрэмж нь хүнийг хязгаарлах. Биднийг бат зогсох үед Эзэн минь бидний төлөө тулалддаг. “Хэцүү байна!” гэнэ. Тулаангүй, бэлэн ялалт ирдэг гэж хэн хэлээв? Чамд хойш сууж байгаа тулаан байна уу? Довтолгооны бус, ухрах байршлаа эзлээд байна уу? Тэгвэл Бурхан чамайг буцаад байранд чинь дуудаж байна. Амлагч нь итгэмжит. Амлагч нь хүчирхэг. Чамайг ч хүчтэй байлгахыг хүснэ. Бурхан хүчээ чамаар дамжуулж үзүүлэхийн тулд чамд хүчээ харуулна. Ядарч, цуцсан үедээ 2Шастир 20:17-г санаарай:

Та нар энэ тулалдаанд дайтах хэрэггүй. Иуда болон Иерусалим аа, өөрсдийгөө жагсаан, зогсоож, та нарт зориулсан ЭЗЭНий авралыг харагтун” гэв. Бүү ай, бүү шантрагтун. Маргааш тэдний өөдөөс хөдөл, ЭЗЭН та нартай хамт байна.

Эзэн бидний төлөө тулалдана. Заримдаа зүгээр л тууштай байхад л ялалт ирнэ. Хайрласаар, өгсөөр, үйлчилсээр, суралцсаар байхад л ялна. Бурханы Үгийг дуулахад, Сүнсний илдийг дуулна. Бурханы амлалыг залбирахад, илдийг гуйна. Заримдаа зүгээр л үг дуугүй Бурханд бууж өгөхөд л тулаандаа ялна. Бурхан бидний арыг даана гэдгийг бат мэдэн, инээсээр ялна. Бурханы дотор бид урам хугарах, ядрах, жадлан эсэргүүцэх зэрэг биднийг чиглэсэн үй олон чулуунаас айхгүй. “Би чамтай хамт, чи битгий ай! Би чиний Бурхан, чи бүү эмээ! Чамайг Би тэнхрүүлнэ Чамд үнэхээр тусална Зөвтийн баруун мутраараа заавал чамайг дэмнэнэ” (Исаиа 41:10).

*Аугаа хүчирхэг Бурхан минь, Та миний төлөө
тулалдаж байхад, би Таны дотор итгэмжтэй
зогсож, тулаанд ялан ятлаа өдөр бүр
шийдэмгий бөгөөд тууштай байна.*

Би хүчирхэг

ЭЗЭН ТА МИНИЙ ТӨЛӨӨ ТУЛАЛДАЖ БАЙГАА
ГЭДГИЙГ МЭДЭЖ, БАТ ЗОГСОХДОО БИ ХҮЧИРХЭГ.

Հարգուհի
Զարմա

ӨНГӨРСӨН НЬ ЧИНИЙ ИРЭЭДҮЙ БИШ

Есүс цэх зогсож, тэр эмэгтэйд “—Эмэгтэй, тэд хаана байна? Чамайг хэн ч шийтгэсэнгүй юу? гэсэнд тэр —Эзэн, хэн ч шийтгэсэнгүй гэв. Есүс —Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ.”

ИОХАН 8:10-11

Нүгэлгүй хүн үгүй бөгөөд бид жаахан ч болов хайр горьдсондоо энэ дэлхийн, шашны эсвэл нэг хар юмны өвөрт шургадаг. Гэхдээ тэглээ гээд улам л гонсойж хоцорно. Эцсийн эцэст нүгэл ч, шашин ч чамаас урвана. Иохан 8 дээр Есүс түмний нүдэн дээр шившиглэгдсэн эмэгтэйд нэр төр, эрх хүч, хүндэтгэл хайрласан байдаг. Есүс нүдэнд ил юмсыг нэвт хараад, эмэгтэйг тухайн байдлаар нь гүйцэт дүгнээгүй. Үндсэндээ Есүс “Өнгөрсөн чинь чиний ирээдүй биш! Яв, дахиж нүгэл бүү үйлд! Нүгэл чиний өнгөрсөн бол, бурханлаг чанар чиний ирээдүй. Хүлээс чиний өнгөрсөн бол, эрх чөлөө чиний ирээдүй. Нүцгэрэл чиний өнгөрсөн бол, сүр жавхлант өмсгөл чиний ирээдүй.” хэмээж.

Есүс тэр эмэгтэйг уучлаад зогсоогүй... чөлөөлж явуулсан. Уучлалаас эрх чөлөө эхлэх. Нигүүлсэл биднийг нүглийн хүлээсээс чөлөөлөөд, дахиж боол болгохгүйн тулд суллаж явуулдаг. Есүс эхлээд биднийг өршөөлөөрөө булхаад, дараа нь нигүүлслээрээ бэхжүүлдэг.

“Учир нь та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байгаа тул нүгэл та нарыг захирахгүй” Ром 6:14.

Өршөөл нь бидний өнгөрснийг эцэслэдэг бол, нигүүлсэл нь бидний төлөө Есүсийн үйлдсэн бүхнийг хүндэтгэж амьдрах хүчтэй болгодог. Бурханы өршөөл, нигүүлсэл нь биднийг нүгэлт амьдралаа хаяад, Түүний ирээдүй, найдвар руу хөл тавих хүчтэй болгодог.

Бидэнд нигүүлсэл өгөгдсөн. Өнгөрсөн хүлээсний хүч таслагдсан. Эдүгээ хүлээсний хүчинд бус, харин чөлөөлөгч Христийнхээ үгд итгэх цаг. Хүлээс чамайг Христээс хүчтэй атгана гэж байхгүй. Өнгөрснийхөө улбааг тэнд нь хаяад, итгэхийг зүрхэл!

*Тэнгэрийн Бурхан Аав аа, намайг уучилж, ирээдүйг
минь нигүүлссэнд баярлалаа. Би харанхуйн
худалд бус, Таны гэрлийн үгд итгэж байна.*

Би хүчирхэг

ӨНГӨРСНИЙХӨӨ БУС, ИРЭЭДҮЙНХЭЭ
УЛМААС БИ ХҮЧИРХЭГ.

УУЧЛАГДСАН

Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнээ энэрч аядуу зөөлөн сэтгэлээр ханд.

ЕФЕС 4:32

Миний бие ой тоймгүй олон зөрчил, бурууг үйлдсээр яваад, Христэд итгэж билээ. Ирээдүйд ханилан суух Жон гэдэг залуу намайг авралын залбиралд хөтлөхдөө: “Эзэн минь, би бүх нүглээ мэдэгдэж байна...” хэмээн дагуулан залбируулав.

Миний сандарсан гэж. “Би бүх нүглээ санахгүй шдээ!” Муухан ой санамжаасаа болоод аврагдаж чадахгүй бол яана ухааны л юм бодогдов.

Гэтэл Жон: “Бүгдийг нь нэг бүрчлэн мэдэгдэх шаардлагагүй. Зүгээр л нүгэл үйлдсэн гэдгээ л хүлээн зөвшөөрөхөд болно” хэмээн намайг тайвшрууллаа. Бурхан надаас сайн мэдлэг, ой тогтоолтойд санаа ч амрав. Би нүгэлтэй хүн учраас, надад өршөөл хэрэгтэйг би сайн мэдэж байлаа. Тийнхүү би Бурханы нигүүлслээр өршөөлийг олов.

Гэтэл итгээд удаагүй, миний бие итгэлийн ахан дүүсдээ тун өршөөлгүй хандаж байгаагаа ухаарсан юм. Тэд миний өмнө буруутай юм шиг л санагдана. Үүндээ ч итгэл төгс байлаа. Энэ үед би маш их сүнсний тэмцэл хийж билээ. Зүгээр л дайсны бай болчихсон байв. Хэдийгээр Есүст итгэдэг болсон ч, яаж ийж байгаад л диаволын схемээр л залбирчихдаг байлаа. Байнга л хүлж, суллах залбирал үйлдэв ч, тусгүй байв. Тэгж тэгж үнэнийг ойлгохдоо, үнэндээ хүмүүс намайг яах нь, миний зөв, тэдний буруу байх нь ямар ч хамаагүй.

Гол нь өөрөө уучлагдсан шигээ бусдыг уучлах Эзэний тушаалыг л дуулгавартай дагах нь чухал болохыг ойлгож билээ.

Би ихэд төөрөлджээ. Буруу атлаа өөрийгөө зөв гээд л. Энэ ухаарлын үр дүнд би хүмүүсийг чөлөөтэй уучилж, өршөөлийнхөө голд намайг шинэтгэн угааж өгөхийг Эзэнээс уйлан хайлан гуйсан бөгөөд Эзэн ч гуйлтад минь хариулсан юм. Товчхондоо, би хүлээснээсээ чөлөөлөгдсөн бөгөөд яаж ч бодсон эрх чөлөөтэй явах нь хавьгүй дээр буюу.

*Тэнгэрийн Бурхан Аав аа, миний амьдралд байж
мэдэх алив заль мэх, үл уучлалыг харуулж өгөөч.*

Би хүчирхэг

БИ ӨӨРИЙГӨӨ Ч,
БУСДЫГ Ч УУЧЛАХДАА, ХҮЧИРХЭГ.

НИГҮҮЛСЭНГҮЙ

Ухаалаг хүн ууранд удаан.

Гэмт дайралтыг өнгөрөөх нь түүний алдар суу.

СУРГААЛТ ҮГС 19:11

Сургаалт үгс ном хүний гэм, зөрчлийг өнгөрөөж сурах нь бидний “алдар” гэжээ. Христэд итгэдэг хүн өрөөлийн зөрчлийг өнгөрөөж сурах нь хүндэтгэл, магтаал, өргөмжлөл бөгөөд онцгойрол юм. Энэ нь Христэд итгэдэг хүний л үйлдэл.

Гэхдээ эхлээд жинхэнэ Шүүгч Аавдаа даатгагдсан хүн л элдэв доромжлол, шарх, заналхийллийг өнгөрүүлж чадна. Хөвгүүд маань муудалцахаараа аав, ээжийнхээ шүүхэд л найддаг байлаа. “Тэр өрөөгөө цэвэрлэсэнгүй, тэр компьютер дээр хэт удаан сууж байна” гээд л. Хөвгүүд маань хэргээ уламжилж, өөртөө таатай хариу гаргуулж, шударга ёсыг нэхнэ. Жон, бид хоёр хэрэндээ л шударга ёсыг тогтоох гэж оролдов ч, хөвгүүд маань бидний “шийдвэрт” голдуу гонсойдог байлаа. Тиймээс хэргээ өөрийн биеэр шийдвэрлэж, бүр ч том хэрэг мандуулна. Би зөрчил шийдвэрлэх талаар яриагүй шүү. Зөрчил шийдвэрлэх үйл явцсыг Жон, бид хоёр дэмжинэ. Гэтэл манай залуус зүгээр л өөрийн гараар өшөөгөө тайлж эхэлдэг байв. “Яагаад ахаа/дүүгээ зодож байгаа юм?” гэхээр, “Яадаг юм. Наадах чинь...” гээд л урсгаж өгнө. Тэгээд зодоон хийхийн оронд аав, ээждээ хэл гэхээр: “Та нар чинь яадаг ч үгүй шүү дээ” гэж хариулна. Үндсэндээ “Та нарын урьд урьдын шийдвэр таалагдаагүй учраас, энэ удаа би өөрийнхөөрөө шийдэв!” гэнэ.

Жон, бид хоёр аав, ээж байх гэж зөндөө бүтэлгүйтсэн. Гэхдээ Бурхан алдаа гаргахгүй! Бурхан төгс зөвт Шүүгч. Бурхан бидний

цаг, хэв маягаар шийдэхгүй байж болох ч, Түүний арга зам биднийх шиг согогтой бус, хэзээд зөв байдаг. Гомдсон үедээ: “Аав аа, энэ хэргийг Тандаа даатгаж байна. Надад үнэхээр хэцүү байна. Гэхдээ би тэр хүмүүстэй өөрөө үзэлцэлгүй, энэ асуудлыг Таны хөлд тавиад, тэднийг уучилъя.” гэж хэлэх. Энэ бол язгууртны шинж. Бид чинь газар дээр амьдарсан Бурханы Хүүг хуулан дууриаж яваа улс. Есүс дагалдагч нартаа: “Хэрэв тэр чиний эсрэг өдөрт долоон удаа нүгэл үйлдчихээд, чам дээр долоон удаа эргэн ирж, “Би гэмшиж байна” гэвэл түүнийг уучил” (Лук 17:4) хэмээн сургасан.

Бид зарим зөрчлийг өнгөрөөх л ёстой болно. Өчүүхэн хэргийг өнгөрүүлж, илүү өндөр төвшний зүйлийг харах. Шүүхийг гүйцэлдүүлэхийн оронд нигүүлсэж, өршөөнө гэсэн үг.

*Эзэн минь, гомдолтойгоо зууралдаад байлгүй, бусдад
нигүүлсэнгүй хандахад туслаач. Үйлдэл болгон минь
Таны нигүүлсэл, өршөөлийг тусгах болтугай.*

Би хүчирхэг

БУРХАН НАДАД НИГҮҮЛСЭНГҮЙ
ХАНДСАНЫ АДИЛ, БУСДАД НИГҮҮЛСЭНГҮЙ
ХАНДАХДАА БИ ХҮЧИРХЭГ.

ЯЛЛАХ БИШ, ӨСӨХ

Иймд эдүгээ Христ Есүс дор байгаа хүмүүст ямар ч ял үгүй.

РОМ 8:1

Бид яагаад өөртөө хатуурхдаг вэ? Хатуурхлаа гээд юунд хүрэх? Би орондоо ороод тухайн өдөр гаргасан алдаа болгоноо ширхэглэн бүртгэдэг байсан сан. Тэгээд санаанд орсон алдаа бүрийгээ төлөх үүднээс алдаа болгоноороо өөрийгөө гөвшиж, ичгүүрээр шавхуурддаг байлаа. Өдөр жаргахад өөртөө гонсойсондоо, өөрийгөө шийтгэснээрээ өөрчлөлт, сайжралтыг авчирна гэж бодоо юу? Үгүй ээ. Энэ чинь бүтээгч бус, сөнөөгч хэв маяг.

Алдаа гаргаснаа ойлгож, засч залруулах нь зөв. Толгой эргэсэн үг, үйлдлээ Ариун Сүнсээр засуулсан нь дээр. Энэ эргэцүүлэл нь яллах бус, өсгөх зорилготой. Би шөнө бүр өөрийгөө алдаагаараа сэхээ сөхөөгүй болтол жанчдаг байлаа. Тэгсэн хойноо л залбирч, уучлал гуйна. Гэхдээ навсайтлаа гөвүүлчихсэн хүн чинь миний зөрчлийг цагаатгахаар буух маргаашийн шинэхэн нигүүлсэлд итгэхүйеэ бэрх болсон байна.

Жишээ нь, би хүүхдүүддээ зохисгүй авир үйлдэл гаргасандаа гутраад: “Би яасан тэвчээргүй юм бэ?” хэмээн өөрийгөө тоншино.

Яавал илүү тэвчээр гаргахад суралцахын оронд өөрийгөө бүтэлгүй муугаар цоллох нь цааш цаашдын бүтэлгүйтлийг л дуудах.

Өөртөө уурлаж, өөрийгөө яллах нь сүйрэлд дагуулах ялын үлгэр загварыг л бүтээн босгоно..

Хүн бид ялын жинг даахгүйг мэдсэн учраас л биднийг ялыг

бидний өмнөөс Есүс үүрсэн буюу. Бид алдаагаа Бурханы Үгийн гэрэлд гаргах хэрэгтэй. Тэндээс ял, буруутгалыг бус, зөвлөгөө, гэгээрлийг олно. Гэрлийн илчилсэн зүйл нь мөн эдгээх ч хүчтэй. Ял нь харанхуйлал бол, нигүүлсэл нь гэрэл болой. Буруугаа давтаж байхаар, зөв болгодог хариултыг нь давтацгаая.

*Тэнгэрийн Бурхан Аав аа, өөрийгөө
ялласанд минь уучлаарай. Таны Үгийн
гэрэл зүрхийг минь үнэнээрээ гийгүүлэх
болтугай. Өөрийгөө яллахаа больж,
Таны өршөөлд найдахыг зааж өгөөч.*

Би хүчирхэг

ЯЛЛАХЫГ БУС, ӨСӨХИЙГ СОНГОДОГ
УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

ЗҮРХЭН ЦЭЦЭРЛЭГ

*Хэн чинь ч Бурханы нигүүлслээс хоцрохгүйн тулд
болон аливаа гашуун үндэс урган хор учруулж,
түүгээр олноороо бузарлагдахгүйн тулд сэрэмжил.*

ЕВРЕЙ 12:15

Жаахан байхад зэрлэг зулгаах ажилд их дайчлагдана. Би ч хурдхан гарч тоглох гэсэндээ бушуу туулай царайлан, ургамлыг үндсээр нь сугалалгүй, толгойгоор нь тастаад хаячихна. Үндсээр нь сугалах гэж гараа шороотой хутгана. Тэгж заваармааргүй байдаг. Ишгүй ургамал хатаад үхчихнэ, ээж ч гадарлахгүй гэж бяцхан тархиндаа сэтгэнэ. Миний хувьд газар ухаж, заваартаж байснаас, гүний асуудлыг дээгүүр нь шороогоор дарчих нь илүү ухаантай арга байв. Хэдэн долоо хоногийн дараа нөгөө газарт дахиад л хогийн ургамал шинээр ургаад ирнэ. Миний зулгааснаас хавьгүй жижиг атлаа жигтэйхэн чанга үндэстэй. Ээж надад ургамлын үндсийг тойруулж ухаад, гарт атгагдах хэмжээний үндэс гаргахыг үзүүлэнтэй зааж өгнө. Анх ийм хялбар байсан ажил эдүгээ бэрх хөдөлмөр болжээ.

Бид зүрхнийхээ цэцэрлэгийг яг ийм янзаар арчилдаггүй юу?

Бурханы Үгийн шимт үндсийг хорслын үндсээр ороож боомилтол Сатан бидэн дотор цөхрөл, буруу сэтгэлгээ, уур хилэнгийн үрийг цацсаар байдаг.

Хогийн ургамал жинхэнэ ургамлаас хурдан ургах. Хогийн ургамал нь ямар ч хөрсөнд идээшин зоргоороо ургадаг зэрлэг

ургамал. Нөгөөтэйгүүр, нарийн чанд боловсруулах ёстой жинхэнэ үр жимс, хүнсний ногооны амьтай үр нь хөрс нь таарахгүй байх юмуу хогийн ургамлын үндсэнд амархан боогдчих гээд байдаг.

Шийдвэрлэлгүй орхисон хорслын үндэс нь хамгийн эгзэгтэй үед л хүчээ авна. Тухайн үедээ шийдвэрлээгүй, хойш тавьсан энэ асуудал нь хожим үхэлд хүргэх асуудлын хэмжээнд ч томрох аюултай. Асуудлыг аргалж нуух юмуу нааш цухуйсан өнгөн талыг нь шийдвэрлээд орхиж огт болохгүй. Тэгсэн нөхцөлд үндэс нь үлдээд зогсохгүй, улам бүдүүрээд гарч ирнэ. Заримдаа бид асуудлаа Ариун Сүнсээр уг үндсээр нь шийдвэрлүүлэхийн оронд асуудлыг хяналтандаа авсан хэмээн өөрийгөө хуураад орхидог.

Ухаалаг цэцэрлэгч байя. Зүрхэнд чинь хорсол илэрбэл (энэ нь улирал тутам гарч ирнэ), үндсээр нь сугалж хаях Мастер цэцэрлэгчдээ аваачиж өг. Бурханы Үг бидний зүрхний хөрсөнд гүн нэвчбэл, үзэсгэлэнтэй цэцэрлэг ургана.

*Аав аа, сэтгэлээ нарийн чанд боловсруулахын төлөө
өчүүхэн хумсын чинээ ч хорслыг таягдан хаядаг,
гарамгай цэцэрлэгч байхад минь туслаач. Өчүүхэн
шинж олдох бүрий анхааруулж, байх ёсгүй юмсыг хайр
найргүй сугалж, харин намайгаа хүчээрээ бэхжүүлээч.*

— Би хүчирхэг —

ЗҮРХЭЭ ЖИНХЭНЭ ЦЭЦЭРЛЭГЧ ШИГ
АРЧЛАХДАА, БИ ХҮЧИРХЭГ.

ХАЙРЦАГЛАН ШҮҮХ

*Бүү шүү, тэгвэл шүүгдэхгүй. Та нар хэрхэн шүүнэ,
түүнчлэн шүүгдэнэ. Өөрсдийнхөө хэмжсэн
хэмжээсээр та нар хэмжигдэх болно.*

МАТАЙ 7:1-2

Бид эд хогшлоо хайрцганд эмхлэх дуртай. Аль хайрцагт юу байгааг мэдэж байх нь тун эвтэйхэн. Харин хүнийг юмуу юмыг хайрцаглаж дийлэхгүй болоод ирэхээрээ, шүүж эхэлнэ. Энэ зан маань тухайн хүний тухай гэхээсээ илүү бидний тухай л нэгийг илчилдэг. Итгээд удаагүй байхад минь тохиолдсон нэгэн явдал намайг хэсэгтээ л овоо хөөрхөн зовоож билээ. Миний хайрцаглаж дийлээгүй явдал гэх үү.

Бурханы ерөөлөөр л учирч гэрлэснээ нээлттэй гэрчилдэг нэгэн хос байв. Бид ч хэн хэнтэй нь нөхөрлөдөг болохоороо, тэднийг Бурханд ч, Бурханы хүмүүст ч үнэн голоосоо хайртайг нь мэддэг байлаа. Гэтэл удалгүй тэр хосын талаар таагүй цуурхал дэгдэж, хос ч салж нийлэх дээрээ тулав. Гэр бүлээс гадуурх асуудал үүсээгүй, зүгээр л тэд хоорондоо огт таараагүй гэнэ. Энэ явдал намайг тас алгадав. Би гэдэг хүн өөрөө гэр бүлийн асуудалтай байсан ч, Жон, бид хоёрыг Бурхан л нийлүүлсэн хэмээн Бурханы авралд л найдаж байлаа. Гэтэл Бурханы тааллаар нийлснээ зарладаг байсан хос маань жигтэйхэн хурдан салчихав.

Энэ явдлаас болоод Бурхан миний гэрлэлтийг аварна гэсэн бат найдвар маань догонцсон тул би бурууг нөгөө хосод нялзаахыг

хичээв. Тэгээд тэдэн дээр “брак” гэсэн тэмдэглэгээ бүхий хайрцганд хийгээд, нэг тийш нь болгохыг хүсэв.

Тиймээс Библийн ул суурь, даацтай хариу сонсохоор, итгэл даасан зөвлөх дээрээ дотоод зөрчлөө барьсаар орлоо. Гэтэл зөвлөх маань санаа алдсанаа “Ярвигтай асуудал юм. Гэхдээ Бурханы авралаар бид шүүгч биш нь сайн хэрэг.” гэж хариулав.

Бул чулуу өнхрөөд л явчихлаа. Зөвлөхийн энгийн үг намайг түмэн зовлонгоос аврав. Түүний зөв. Би Сатаны үгээр үг хийж, бусдыг шүүгээд, Бурханы итгэмжтэй чанарт эргэлзжээ. Өөрийнхөө гэрлэлтийг бусдын үйлдлээр хэмжээд, Бурхан тэдний төлөө хийгээгүй учраас, миний төлөө ч хийхгүй хэмээн төөрөлдсөн байв. Айдсаасаа болж шүүжээ.

Бид өөрийгөө шарх, шүүхээс хамгаалах гэсэндээ л шүүдэг боловч, хэрэг дээрээ бид бүгдээрээ л буруутай. Матай 7:3 дээр “Нүдэн дэх дүнзээ анзаараагүй атлаа юунд чи ах дүүгийнхээ нүдэн дэх үртсийг харна вэ?” гэдэг.

Тод харж, өөртөө ч, өрөөлд ч тус болох үүднээс нүдэн доторх дүнзээ авч хаяхыг Есүс айлдруун. Аливаа зүйлийг хайрцаглаж чадахгүй байвал, зүрхээ шалгаад, шүүх нь бидний үүрэг биш учраас, талархах хэрэгтэй.

*Аав аа, бусдыг шүүх гээд унабал, бусдыг
шүүсэн хэмжээгээрээ өөрөө шүүгдэхийг минь
сануулаарай. Надад өршөөл хэрэгтэй учир, бусдад
ч өршөөнгүй хандахад минь туслаарай.*

— Би хүчирхэг —

БИ ХАЙРЦАГЛАЖ ШҮҮДЭГГҮЙ
УЧРААС, ХҮЧИРХЭГ.

БУРУУГАА ХҮЛЭЭГЭЭД, ТАВЬЖ ЯВУУЛАХ

*Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг
маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ.*

1 ИОХАН 1:9

Дүүрэн эрх чөлөө амтагдсан амлалт байна. Биднийг нүглээ мэдэгдэх үед Бурхан уучлаад зогсохгүй, сонголтын минь хор хохирлоос ч цэвэрлэдэг байх нь. Тийм байтал бид яахаараа шалтаг тоочиж, буруутгалыг өөрөөсөө зайлуулах гэж? Буруугаа хүлээсэн хүн буруугаасаа чөлөөлөгддөг болохыг би сурсан. Есүс бидний бурууг Өөр дээрээ авчихаад байхад, хулгайчийг барьж “тоглолгүй”, буруугаа хүлээгээд, цааш хөдөлсөн нь дээр.

Нэгдүгээрт - буруугаа хүлээх талаар өгүүлье. Намайг жаахан байхад Флип Уилсон гэдэг алдартай хошин жүжигчин байлаа. Түүний бүтээсэн Жералдин гэдэг дүр юм бол “Би биш, Дявол л надаар хийлгэчихсэн!” гэдэг үгээрээ алдартай байв. Тэгэхээр, чи ёоз ёозын шалтаг зохиож болох. Гэхдээ Дявол хүнийг юунд ч хүчилж чадахгүй. “Би өөрийн мэдэлгүй хийчихлээ”, “Өөрийгөө хянаж чадсангүй.” гэх мэтээр булзаж болох. Гэхдээ энэ нь бид нүглийн өмнө хүчин мөхөсдөж, захирагддаг гэсэн үг бөгөөд намайг хүчжүүлэгч Христээр бүгдийг хийж чадна гэдэг Бурханы үгийг няцааж байгаа

хэрэг. Тэгвэл гэмшил нь: “Тийм ээ, би ийм хэрэг хийсэндээ гэмшиж байна. Танаар угаалгахаар өмнө тань ирж байна.” гэдэг.

Буруугаа хүлээсний дараа бүр ч хэцүү алхам хүлээнэ: тавьж явуулах. Үүнийг чи өөрөө л хийнэ. Энэ нь чиний сэтгэл, бие, сүнсний эрүүл мэндэд амин чухал. Бурханы хэдийнээ уучлаад, мартчихсан зүйлийн төлөө өөрийгөө шийтгэх оролдлогоос ямар ч бүтэлтэй юм гарахгүй. Бурхан “Өрнө нь дорноос хол байдаг адил гэмт үйлдлийг маань... тийн холдуулсан” (Дуулал 103:12) байхад, бид ахин дахин сөхөөд байх утгагүй.

Бурханы сайн сайхан, энэрэл л биднийг гэмшүүлдэг. Гэхдээ бид ингэж заалгаж өсөөгүй. Бид төлөөс үзэж байж л ялаас чөлөөлөгддөг. Бид хүүхэд байхдаа: “Өөрчлөгдсөн хойно чинь л итгэе” гэдэг сургаалаар л өссөн. Гэтэл Бурхан биднийг өөрчлөхийн тулд өршөөгдөх зохисгүй бидэнд өршөөлөө сунгасан. Хүртэх зохисгүй зүйлээ хүртэхийг өршөөл гэнэ. Үүнийг хүний ухаанаар ойлгохгүй. Хүн “нүдийг нүдээр, шүдийг шүдээр” гэхийг л амархан ойлгодог. Хууль, дайсан, бидний толгой доторх яллагч нь шийтгэл нэхдэг бол, Сүнс өршөөлийг л тогтоодог. Найз минь, өршөөлийг хүлээж ав. Нүглээс чөлөөлөгч Бурханы замыг хүлээж ав.

*Эзэн минь, нүглээс чөлөөлөх Таны
замыг хүлээж авалгүй, эсэргүүцэж
байгаа явдал байгаа эсэхийг илчилж
өгөөч. Юун дээр буруугаа хүлээгээд,
тавьж явуулах ёстойг харуулаач.*

Би хүчирхэг

БИ БУРУУГАА ХҮЛЭЭГЭЭД, ХҮЛЭЭЖ
АВАХ ЗОХИСГҮЙ ӨРШӨӨЛӨӨ
ХҮЛЭЭЖ АВАХДАА, ХҮЧИРХЭГ.

ТЭСЭЭД ГАРАХ ХҮЧТЭЙ

“Ах дүүгээ үзэн яддаг бүхэн алуурчин мөн. Ямар ч алуурчны дотор мөнх амь байдаггүйг та нар мэднэ.”

1 ИОХАН 3:15

Дэлхий дүүрэн үзэн ядалт. Тиймээс энэ эшлэлийг зүрхэндээ хүлээж авах цаг болжээ. Ахан дүүгээ үзэн ядагч нь... юу гэнэ үү? Аллага үзэн ядалтаар л нэвтэрдэг. Нэгдүгээрт - дээрх эшлэл нь “хэн болов ч” гэдэг үгээр эхэлснийг хараарай. Үүнд чи, бид хоёр ч багтана. “Ахан дүүсдээ ад үзэгдсэн бол, тооцохгүй” гэж хэлээгүй байна. Бичээс хэн болов ч, хэн ч, хүн болгон гэсэн л бол, энэ нь хүн бүрт хамаатай гэсэн үг. Ар, өврийн хаалга байхгүй.

Гэхдээ энэ нь бидний хувьд хүчийг олж, нигүүлслээр өсөх боломж гэдэг нь сайхан. Бурханы Үгэнд орох үед Бурхан биднийг үнэнээр амьдрахад сургана. Ахан дүүгээ үзэн ядагч нь алуурчин гэсэн. Энэ нь найраагүй хатуу үг. Би алуурчнаараа дуудуулмааргүй байна. Гэхдээ зүрхний минь мухарт үзэн ядалт сүүмэгнэх үе надад бишгүй тохиож байсан. Тэгэхээр, би хууль зөрчигч юмуу алуурчнаараа цоллуулаад, мөнхөд цөлөгдөх хэрэг үү? Гэмшээд, харанхуйгаас татгалзсан нөхцөлд үгүй юм.

Миний бие Бурханы хүчжүүлэгч нигүүлсэл, хаацайлагч өршөөлийг үзсэн хүн. Бурханд уучилж хүчиршгүй хүнд, хар нүгэл гэж байхгүй. Бурхан гэмшсэн алуурчдыг уучилдаг.

Бид амьдралыг дэлхийн шүүхийн системээр бус, хаанчлалын нүдээр харна. Бид зүгээр нэг энэ дэлхийн иргэд бус. Учир нь Бичээс

“...та нар цаашид гаднынхан болон ирмэл хүн бус, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм” (Ефес 2:19) гэдэг.

Бид дэлхийн хууль, шүүх танхимаар бус, харин тэнгэрийн дээд захиргааны өмнө хариуцлага хүлээсэн, захирагдсан хүмүүс. Тэнгэр нь чулуун дээр сийлэгдсэн гадаад дүрэм, журмаар засаглагдашгүй, бидний зүрхэн дээр бичигдсэн нууц коодоор биднийг өөрчилдөг. Амьгүй, үхмэл дүрэм нь хатуу, үхлүүт зүрхэнд зориулагдах. Эрх чөлөөний хууль нь махан биеийн зүрхэнд зориулагдсан. Тиймээс бодитоор хүний амь хөнөөсөн хүнийг л энэ дэлхийн шүүх алуурчнаар нь дууддаг бол, хаанчлал дотор үзэн ядах төдийд л алуурчин болдог байх нь. Зүрхнийхээ хир буртаг бүрийг хүлээн зөвшөөрч, аллагын сүнстэй нүүр тулах цаг иржээ.

*Тэнгэрийн Бурхан Аав аа, миний зүрхэн дэхь үзэн
ядалтыг илчлээч. Энэ нь аллагын нүгэл гэдгийг би хүлээн
зөвшөөрье. Тэднийг уучилсан шиг минь намайг уучлаач.*

Би хүчирхэг

БИ БУРХАНЫ ЕР БУСЫН ХҮЧ, ӨРШӨӨЛ,
НИГҮҮЛСЭЛД НАЙДАХДАА, ХҮЧИРХЭГ.

ЯЛГҮЙ

*Есүс — Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс
хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ.*

ИОХАН 8:11

Эзэн энэ үгийг илт ялтай бүсгүйчүүлд хэлжээ. Харамсалтай нь, Евагийн охидын эсрэг ашигладаг Сатаны хамгийн хорон арга нь шашны өнгөлгөөтэй байдаг. Иохан 8 дээр хууль, шашны харгислал, Бурханы өршөөл, хайрын үзэсгэлэн тод ялгарч байна. Энэ үйл явдал дээр очоод, өөр гэрлээр харцгаая.

Өглөөний хөх манан дунд залуу рабби Есүсийг сонсохоор бум бужигнана. Есүс нэг л өөр. Түүний амнаас Бурхан Аавын Үг гардаг.

Үүрийн гэгээ татахтай зэрэгцэн Есүс ба түүний дагалдагч нар гарч ирэв. Есүс ч хэсэг хүмүүстэй мэндлээд, сургаалаа эхлүүлэв. Хүмүүс анхааралтай сонсож, үг бүрийг нь сорно. Тэгж байтал тэртээ мандалд хэрэг мандав.

Үзтэл, Есүс болоод түүний дагалдагч нарын зүг өөр нэгэн бүлэг айсуй. Чанга догшин дуу хоолой, багширалдсан бараан дүрсүүд нь ямар нэг юмтай зууралдана. Ичгүүрийн орноосоо суга татуулаад, нүцгэн шахуу биеэ хувцасныхаа тасархайгаар нуух гэж оролдох, арчаагүй эмэгтэйг чирч яваа нь тэр байв. Гэхдээ хамт хэвтсэн эр нь сураггүй.

Тэгээд тэд Есүст “—Багш аа, энэ эмэгтэйг завхайрч байхад нь үйлдэл дээр нь барьсан юм. “Ийм эмэгтэйчүүд уруу чулуу шидэгтүн” гэж Мосегийн хуульд тушаасан. Харин Та юу гэж хэлэх вэ?” (Иохан 8:4-5) гэв.

Есүс ийм эмэгтэйд юу гэх бол? Есүс эмэгтэй рүү ч харах гэж, тэдэнд ч хариу өгөх гэж түвдэлгүй, доош суугаад, газар дээр юм бичжээ.

Дараа нь тэдний дундаас нүгэлгүй нь эхний чулууг шидэхийг уриалсан. Яллагч нар нэг нэгээрээ явсаар, Есүс, хүмүүс, ялтай эмэгтэй л үлдэв. Есүс Өөрөө нүгэлгүй болов ч, нөгөө эмэгтэй рүү чулуу нүүлгээгүй. Есүс эмэгтэйг яллах гэж биш, аврах гэж ирсэн, цорын ганц үнэн зөв Шүүгч.

Есүс яллагч нарыг явж дуустал чимээгүй байв.

Дараа нь босч, цэх зогсоод, эмэгтэйгээс: “—Эмэгтэй, тэд хаана байна? Чамайг хэн ч шийтгэсэнгүй юу?” гэж асуусан.

Эмэгтэй ч: “—Эзэн, хэн ч шийтгэсэнгүй” гэж хариулсан.

“Есүс —Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ.” (Иохан 8:10-11).

Эмэгтэй толгойгоо өргөөд, Есүсийн уучлал, хайр, шаналал дүүрэн харцтай тулгарсан. Эмэгтэй одоо үхэл, харанхуйн охин биш, амь, гэрлийн охин болов.

Могой бидний ичгүүрийг дэлгээд, ичгүүрээр биднийг яллах үед бид Есүсийн нүд рүү ширтээд, Тэр биднийг яллахгүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Түүний өршөөл биднийг өмгөөлж, нигүүсэл нь “яв... дахиж нүгэл бүү хий” гэж хэлнэ.

Эзэн минь, өөрийгөө өмгөөлж чадахгүй байхад минь биднийг өмгөөлсөнд баярлалаа. Ялалгүй, аварсанд баярлалаа.

Би хүчирхэг

БИ ЯЛЛАГЧИЙН ӨМНӨ АВРАГЧААРАА
ӨМГӨӨЛҮҮЛЖ, ИЧГҮҮРЭЭСЭЭ
ӨНДИЙХДӨӨ, ХҮЧИРХЭГ.

Бүгд хянан
захирагдаа
хүчирхэг

АНХААРАЛТАЙ СОНСОХ

Бурханы оршихуйд... хэл чинь ч бас бүү яараг. Учир нь Бурхан тэнгэрт, чи газарт байна. Иймд үгээ цөөн байлга.

НОМЛОГЧИЙН ҮГС 5:2

Бичээс хэл амаа засаглах талаар болоод үгийн хүчийн талаар ихийг өгүүлдэг. Гэхдээ сонсохуйн хүчинд ч анхаарахгүй байж болохгүй. Сонсоход сахилга бат ч, цаг хугацаа, тэвчээр ч хэрэгтэй. Хүний санааг илүү лав ойлгохын төлөө зөв асуулт тавьж сурах. Хүмүүс дуулдахыг хүсдэг.

Иймээс хүмүүс юу бодож байгааг мэдэхийн төлөө тэмцэх шаардлагатай бөгөөд хүмүүс ч юу бодож явдаг нь алмайрмаар. “Учирсан болгон нэгийг сургадаг” гэдэг дээ. Тасралтгүй суралцагч л өснө. Хүнийг ярьж байхад нь хэлэх хариултаа боловсруулахаа боль (хосууд муудалцахдаа ингэдэг дээ). Хүний зүрхийг үнэнээсээ сонсоход нэгэн зүйлийн хүндэтгэл орших. Чамайг сонсохгүй байгааг хүмүүс мэдэрнэ. Миний бие маш их аялдаг агаад нислэгийн үеэр Бурхан Өөрийнх нь хайр, гэрлийн талаар хуваалцах боломжийг олонтаа олгоно. Чи хүмүүсийн үгийг жинхэнээсээ сонсбол, хүмүүс ч чиний үгийг жинхэнээсээ сонсоно. Тэдний хэрэгцээ, шарх, бодлыг сонс. Дараа нь чамаар дамжуулж ярихыг Ариун Сүнснээс гуй.

Бусдыг сайн сонсох нь чиний дотор ч нэгэн зүйлийг сэрээнэ. Мэддэг зүйлээ бушуу хэлэх гэж яарснаасаа болоод суралцах боломжоо алдах бий.

Сургаалт үгс: “Үг олшроход гэмт үйлдэл зайлшгүй. Хэлээ

захирагч хэрсүүгээс зайлбаргүй. Зөвтийн хэл цэвэр мөнгө. Буруутын зүрх үнэ цэнэгүй.” (10:19-20). Мөнгө нь галаар тунгаагдах. Бурханы Үгийн галаар яриагаа цэвэршүүлбэл, яриан дахь бохирдол, хэрэггүй хог нь зайлуулагдана. Иаков ном биднийг яриандаа хойрог бай гэдэг. Миний хувьд ч урсгаад хаямаар байсан ч, хэлээ хазаад өнгөрснийхөө ачаар олон ч удаа аюулаас аврагдаж байлаа. Хүн сонсох тусам, яарч дуугарах нь багасдаг.

Бурхантай ч олон таван юм ярихгүй байхыг ятгах. Тэр чинь тэнгэрийн Бурхан бол, бид чинь газрын хүмүүс. Хэзээд нь ярьж, хэзээд нь сонсох нь Бурханаас эмээн хүндэтгэхүйн амин бүтэц. Бид ярьснаараа бус, сонсоноороо суралцдаг. Тиймд чиний залбирлын амьдралын томоохон хэсгийг сонсохуй эзлэх ёстой гэсэн үг. Бишүүрхсэндээ дуугаа хураах явдал Бурхан, та хоёрын дунд гарахгүй. Бурханыг ч сонс, чиний амьдралд тавьсан хүмүүсийг нь ч сонс. Тэгвэл чи өснө.

Эзэн минь, хүмүүсийн үгийг жинхэнээсээ сонсож, Таны өгсөн чигээр хариулж байхад туслаач. Өдөр бүр Таны үгийг сонсоход зүрхийг минь дасгалжуулаач.

Би хүчирхэг

БУРХАНЫГ БОЛООД БУСДЫГ САЙТАР
СОНСОХДОО, БИ ХҮЧИРХЭГ.

ДУРШЛАА ХЯНАН ЗАХИРАХ

Надад бүх юм зөвшөөрөгддөг, гэсэн ч бүх юм тустай биш. Надад бүх юм зөвшөөрөгддөг, гэсэн ч би юугаар ч эзэмдүүлэхгүй.

1 КОРИНТ 6:12

Би хар шоколад, кофе хоёрт ухаанаа алддагаа хүлээе. Гэхдээ би хар шоколад идэж үзээгүй бол, үе үе тэгтэл хорхойсохгүй л байх. Кофены тухайд? Унтаа биеэ сэрээхийн тулд аяга яава кофе дээрээ Бреейрс кофетой зайрмаг овоолоод, орой дээр нь шанцай цацалж үзээгүй бол, мока латте уухсан гэж үгүйлэх болов уу?

Мэдээж үгүй! Би хорвоогийн тэр тансаг амтыг мэдрэх ч үгүй, мэдэх ч үгүй байсан. Өтгөн хар ус гэдгээр нь мэддэг байхдаа кофе гэдэг ундааг би үздэггүй байлаа. Сүүтэй, цагаан гэдэг хоёр төрлөөр нь мэддэг байхдаа, шоколадыг тоодог ч үгүй байлаа.

Одоо ч үхэн хатсан юм байхгүй л дээ! Хар шоколад идэхгүй л бол, өглөө бүр кофены ёслолоо хийхгүй л бол үхлээ гэсэн зүйл байхгүй. Зүгээр тансагламаар учраас л тансагладаг! Энэ хоёр нь миний эзэн бус, зүгээр л дуртай юмс. Би хар шоколад идэлгүй хэд ч хонож чадна. Идэхгүй гээд хэн ч хохирохгүй. Салганаад унахгүй. Зүгээр л жаргаж хийнэ гэдэг шиг жаргаж иддэг л байхгүй. Кофег бол, би нойрноосоо аажмаар бус, огцом сэрэх дуртай учраас л уудаг.

Гэтэл би эрүүл хоолноос татгалзаад, зөвхөн шоколад, кофе хэрэглээд байвал, юу болох вэ? Хар шоколаднаас авдаг зуурдын таашаалаа огцом зуурын сэргээш мэт кофегоо амьдралынхаа бусад бүх мэдрэмжээс дээгүүр залчихбал, яах уу? Хэлийг минь баясгадаг

шоколадны хайлмагтсан амтгүй гээд ногоон хүнсээ ад үзэх үү? Магадгүй бусад идээ ундаа шал утгагүй санагдах байх.

Ийм маягаар хөөрөөд, хоёр долоо хоног дан шоколад, кофе хоёроор амьдарбал, яах уу? Магадгүй хэсэгтээ гоё, зэгзгэр, сэргэг шогших байх. Гэвч төдөлгүй бүх тэнцвэр алдагдаж, миний дуршил доголдоно.

Тэгэхээр, хүн дуршил, хүслээ өөрөө л бүтээдэг юм. Хоол, секс, зугаа, олон нийтийн сүлжээ тэргүүтэй алив дуршил нь биднийг бодит байдлаас төөрүүлж, тэнцвэрийг минь алдагдуулна. Тиймээс л дуршилдаа автаад байлгүй, биеэ хянаж, хүчирхэг бай. Хүн дуршилдаа өгсөн үнэ цэнээрээ дуршлынхаа хүчийг ихэсгэж, багасгана.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, надад тэнцвэрээ алдалгүй,
дурилаа үнэлэхийг зааж өгөөч. Амьдралд минь хэр
хэмжээнээсээ даварсан зүйл байгаа эсэхийг, юу
намайг боолчлоход холгүй байгааг хэлээч.*

— Би хүчирхэг —

БИ ДУРШИЛДАА ЗАХИРАГДАЛГҮЙ,
ХАРИН ЗАСАГЛАЖ, ТЭНЦВЭРЭЭ
САХИХДАА, ХҮЧИРХЭГ.

3

УУРЛАХ НЬ ХЭВИЙН

Уурлав ч нүгэл бүү үйлд.

Уур хилэн дээр чинь нар бүү жаргаг.

ЕФЕС 4:26

Энэхүү эшлэлийн эхэн дээр “уурлав ч” гэжээ. Уурлах шиг амархан юм байхгүй. Гонсойх нь эрүүл учраас, Бурхан бидэнд уурлахыг зөвшөөрсөн. Уур нь баяр, гуниг, итгэл, айдастай л адил хүний эрүүл мэдрэмж. Бурхан Өөрөө ч олонтаа уурлах. Хуучин гэрээн дээр ч Бурхан Израильд болоод бусад улсад уурласан олон зуун үг бий.

Сэтгэл мэдрэмжийг цогшуулаад орхичихоор, хожмоо улаан түймэр дэгдээнэ. Нөгөөтэйгүүр дураараа цацаад байвал, мөрөөр нь нүгэл нэвтэрнэ. Бурхан Өөрөө хүний уурыг үнэлсэн. Гэтэл олонх маань үүнийг ойлгодоггүй. Уурлах нь хамаг юмаа чулуудаж, хайртай хүмүүс рүүгээ хашхичих юмуу зүй бус хандлагад нь хорсож, хонзогнох явдал уу? Үгүй ээ, эдгээр нь уурын зүй бус илрэл. Уур, нүглийн хооронд торгон заадас бий.

Уурыг *Америк өв сангийн тайлбар толь* дээр “төрөл бүрийн авир үйлдлээр илэрхийлэгддэг, ихэвчлэн түрхэн зуурын хүчтэй дургүйцэл” хэмээн тодорхойлжээ. Аливаа үйл явдал юмуу хүний үйлдлээс болж эрчтэй, хүчтэй дургүйцэх, үл зөвшөөрөх, үл таалах, цээрлэх нь хэвийн зүйл. Эдгээр нь өдөр тутам хүн болгонд төрдөг мэдрэмж. Харин “гэвч нүгэл бүү үйлд” гэдэг хэсэгт л нилээд хүч хөдөлмөр зарцуулагдах. Хүүхдээс том хүний дайтай хариу үйлдэл

гарахгүй. Хүн төлөвших тусмаа, биеэ хянан захирах чадвар нь ч өснө. Гонсойх нь буруу биш ч, үүнээсээ болж бусдыг шийтгэх нь буруу. Христэд итгэдэг хүн ганц өөрийгөө төлөөлөхгүй. Бид элч төлөөлөгч учраас, авир үйлдлээрээ бусдад хэрхэн нөлөөлөхөө бодууштай. Хүн юу тохиолдохыг хянаж чадахгүй ч, хэрхэн хариу үйлдэхээ хянаж чадна.

*Эзэн минь, сэтгэл мэдрэмжээ Таны
хүүхэд шиг төлөвшил, нигүүлслээр хянан
захирахад туслаач. Уур, нүглийн зааг дээр
тулаад ирбэл, Сүнсээрээ хөтлөөрэй.*

Би хүчирхэг

БИ УУРАА ХЯНАН ЗАХИРЧ
ЧАДДАГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

4

ҮГЭЭ МЭДЭХ

*Учир нь бид цөмөөрөө олон юман дээр бүдэрдэг.
Үгэн дээрээ бүдэрдэггүй нэгэн байваас, тэрээр
бүх биеэ хазаарлах чадвартай төгс хүн болой.*

ИАКОВ 3:2

Хэл амаа мэдэж явах нь амин чухал болохыг Иаков номын 3,4-ээр эшлэл ч үргэлжлүүлэн хэлдэг:

Морьдыг залахын тулд бид амыг нь амгайвчилж, бүх биеийг нь жолооддог. Мөн усан онгоцуудыг хар. Тэдгээр нь хэдийгээр агуу том болоод зогсохгүй хүчит салхинд туугддаг боловч жижигхэн залуураар залуурчийн хүссэнээр жолоодогддог.

Хэл яриа амьдралыг минь сайн, муугаар эргүүлэх хүчтэй. Үг биднийг өөдлүүлнэ ч, уруудуулна ч. Иаков хэл яриаг улаан түймэр дэгдээх чадалтай өчүүхэн цогтой зүйрлэсэн. Гал түймрийг хэн хүсэх вэ?! Нөгөөтэйгүүр Ром ном харанхуйн хаанчлалаас гэрлийн хаанчлал руу авран, өөрчлөх чадалтай үгийн хүчийг бас илчилжээ. Ром 10:9-10 дээр:

“...та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл,

аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.” хэмээн амласан байна

Биднийг асуудалд оруулдаг тэр л зүйл биднийг асуудлаас авардаг аж: “Хэл гэдэг амилуулах бас үхүүлэх хүчтэй Хэн үүнд дурлана үр жимсийг нь хүртэнэ” (Сургаалт үгс 18:21). Бид бүтээж, амьдруулахын төлөө л өгүүлдэг тэнгэрийн Ааваа дууриах ёстой. Энэ нь үгээрээ ерөөж, хараахаа хүн өөрөө сонгоно гэсэн үг.

Энэ бол суралцах мөнхийн боломж. Үхэл, сүйрэл рүү хөтөлдөг бус, харин амь руу аваачих аргаар ярьцгаая. Ам чинь л амьдралыг чинь жолоодох учраас, зорьсон газартаа хүрэх арга замаар л яриарай.

Эзэн минь ээ, хэл амаа мэдэж явахад минь туслаач. Үг минь намайг зөв чиглүүлдэг жолоо байх болтугай. Би сүйрлийн бус, үнэн, гэрлийн үгийг ярих болтугай.

Би хүчирхэг

БИ ХЭЛ АМАА ЗАХИРДАГ
УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ХАРУУСАЛГҮЙ

Бурханы дагуух гашуудал нь авралд хүргэдэг гэмшлийг бий болгодог. Харин ертөнцийн гашуудал үхлийг бий болгодог.

2 КОРИНТ 7:10

Хүн бүрт харуусал бий. Гэхдээ харуусалдаа автаж болохгүй. Сүйрүүлэгч харууслыг Паул “дэлхийн гуниглал” гэсэн. Дэлхийн гуниглал гэж юу вэ? Нэр төр, мөнгө, хөрөнгө, харилцаа юмуу энэ дэлхийтэй холбоо бүхий алив зүйлийн араас нэхэн гашуудах. Энэ төрлийн харуусал нь биднийг авир үйлдлээрээ бусдыг хэрхэн хичнээн хохироосон дээрээ бус, харин өөрийнхөө гарз дээр л төвлөрүүлдэг. Энэ төрлийн гуниглал нь шашны хүчин чармайлтаар өөрчлөлт авчрах гэж оролддог. Гэвч ийм хандлага зүрхний сэдэл рүү гүнзгийрэх нь юу л бол.

Тэгвэл Бурханлаг гуниглал нь үр дүнг даваад, Бурхантай болоод бусадтай тогтоох харилцаанд маань учирсан хор хохирол дээр төвлөрнө. Энэ гуниглал сүйрүүлдэггүй, харин байгуулдаг. Бурханлаг гуниглал нь бидэнд юмсыг бодитоор харахад тусална. Дуулал 51:1 дээр Давид бурханлагаар гуниглахыг үлгэрлэн харуулжээ. “Бурхан, хайр энэрлийнхээ учир Намайг нигүүлсээч. Арвин их өршөөлийнхөө учир Гэмт үйлдлийг минь арилгаач.”

Давид Бурханы итгэмжит хайранд даатгуулан, Түүний эсрэг нүгэл үйлдсэнээ хүлээн зөвшөөрчээ. Тэрбээр биеэ яаж ч өмгөөлөөгүй. Хэнийг ч буруутгаагүй. Зүгээр л буруугаа хүлээгээд, улайсан. Бид алдаагаа улайхдаа чөлөөлөгддөг. Биеэ даруусгахад, Бурханы энгүй нигүүлсэл бидэнд хүрэлцэж, Бурхан биднийг нөхцөл байдлаас минь өөд өргөнө.

Давид өөрийгөө цэвэрлэж чадахгүйгээ мэдсэн учраас, Эзэнд

хандсан. Биднийг уучлаад зогсохгүй, сүүдэр, толбоны үлдэц бүрийг арилгах хүч нь ганц Бурханд л бий.

Нүгэл нь зүрхийг үхүүлж, зоригийг мохойлгоно. Давидын дуулалт залбирал цаашаа ийн үргэлжлэв: “Авралынхаа баясгаланг надад сэргээж өгч, Хүсэл зоригийнхоо сүнсээр намайг тэтгээч. Би тэрслэгчдэд Таны замуудыг заах бөгөөд Нүгэлтнүүд Тан уруу буцах болно” (Дуулал 51:12-13).

Энэ эшлэл магад миний хамгийн дуртай эшлэл байх. Энд харуусал, гуниглалын буурин дээр баяр хөөр, шинэ эхлэл цэцэглэхийг амлажээ. Бурхан муухайгаас сайхныг бүтээж чадна. Тэр цагт бүтэлгүйтэл минь Бурханы өршөөл, хайрыг заах боломж болж хувирна. Тэнгэрийн Аав минь харуулсын хар тасархай болгоныг Өөрийнхөө итгэмжтэй чанар, үнэний бамбар болгон асаах чадалтай. Бурхан ийнхүү бидний авралыг ялуулдаг. Чамайг чөлөөлсөн хайр, үнэний тухай заахдаа, өөрийнхөө хөндүүртэй хэсэг болгоныг гоо үзэсгэлэн, эрх чөлөөний амьд жишээ болгоорой. Энэ чинь л бурханлаг гуниглалын үр дүн.

*Эзэн минь, миний гуниглал дэлхийн бус, бурханлаг байх
болтугай. Төрсөн харуусал болгоноо гэмшин, Танаар
эдгээлгэхээр авчирч байна. Холион бантан шиг амьдралыг
минь Та гоо үзэсгэлэнтэй болгож өгөх учраас, баярлалаа.*

— Би хүчирхэг —

БИ АЛДАА ЗӨРЧЛӨӨ ЭЗЭНДЭЭ
БАРЬДАГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ҮГЭНД ҮНДЭСЛЭСЭН

*Хуулийн энэ номыг амнаасаа салгалгүй байж, өдөр шөнөгүй
үүнийг бясалган, үүн дотор бичигдсэн бүхнийг сахин биелүүл.*

Тэгвэл чиний зам өөдөлж, чи амжилтад хүрэх болно.

ИОШУА 1:8

Биднийг Библийн үг шиг хүчжүүлдэг зүйл үгүй. Тиймээс л Бурханы үгийг өдөр тутмынхаа хэрэглээ болгох нь амин чухал. Бурханы Үгийг уншиж, хэрэгжүүлсэн хүн хэзээ ч янзаараа үлдэхгүй. Зүрх нь дэвтэж, Бурхан Аавынхаа юмст зөөлөрч, тэр хэрээрээ заавар чиглүүлэгт нь ч нээгдэнэ. Бичээсийг судлахуй нь бусад бүх сүнсний сахилга батыг амь, эрч хүчээр тэжээдэг сүнсний сахилга бат юм.

Бичээсийг хэр их мэдэх бус, харин амьдрах нь хаанчлалын зарчим. Энэ маягаар Үг нь чиний амьдралд биежиж, үр жимс гаргана.

Тэгэхээр, хаанаас эхлэх үү?

Хаанаас эхлэх, яаж судлах нь ч чөлөөтэй. Библийг янз бүрийн төлөвлөгөөний дагуу эхнээс нь дуустал уншиж болно, сонирхсон сэдвээрээ ч уншиж болно үгүй бол амьдралдаа хариу хайсан сэдвээ хөөж ч уншиж болно. Гол нь өдөр бүрийн мөрдлөгө болгох. Туйлбаргүй зуршил дээрээ бус, харин өдөр бүр Библиэ туйлбартай нээх дээрээ л төвлөр. Тэгсээр, төдөлгүй амьдралын чинь зангуу болохыг үзнэ.

Үзэг, дэвтрээ нээж тавиад, Бичээсээрээ дамжуулж ярихыг Ариун Сүнснээс гуй. Сонгосон эшлэлээ тунгаагаад дуусгачилгүй, харин сурснаа хэрхэн хэрэгжүүлэхээ дэвтэртээ бич. Тухайн үнэнийг

амьдрал дээрээ хэрэгжүүлэх бодит алхам бүхий төлөвлөгөө гарга. Зүрхэнд чинь суулгагдсан үрийг ирэх 24 цагийн дотор, ирэх өдрүүдэд хэрхэн тордох уу? Өсөлтөө ямар арга замаар мөрдөх үү?

Сахилга бат гэхээр толгойд дургүй юмаа хийх, шийтгэл ухааны юм буудаг. Гэтэл Библи унших цаг нь эрүүл хооллох сахилга баттай л адил. Тайвшруулдаг, сэргээдэг, тэжээл өгдөг сахилга бат болой. Чамд айлдах Бурханы Үгийг эрэлхийлж, зориуд Түүний үгээр амьдралынхаа хэсэг бүрийг бордох. Таван минут байна уу, өдөржин байна уу хамаагүй, Бичээст суралцах үйл хэргээ эхлүүлж, чамайг яаж хүчжүүлэхийг нь үзээрэй.

*Аав аа, надад Үгээ өгсөнд баярлалаа. Одоо өдөр
бүр Үгээр тань дутах цангаа өгөөч.*

Би хүчирхэг

БИ БУРХАНЫ ҮГИЙГ ЗҮРХЭНДЭЭ
СУУЛГАЖ, ЗАЛБИРАЛ, ХАЛАМЖ,
ЗОРИЛГОТойгоор УСЛАХДАА, ХҮЧИРХЭГ.

ТАРИАЛАХ БА ХУРААХ

...хүн юу тарьснаа л хурааж авдаг. Учир нь махбоддоо таригч нь махбодоосоо ялзралыг хурааж авна. Харин Сүнсэнд таригч нь Сүнснээс мөнх амийг хурааж авна.

ГАЛАТ 6:7–8

Энэ бол тариалах ба хураахуйн хууль. Зөв зүйлээ тариалсан бол, төсөөлөө ч үгүй ургацаа хураана. Бичээсийн үр нь хүчирхэг, тэжээллэг ургац авчирдаг.

Олон жилийн өмнө би зөвтийн ургацыг авчирна гэсэн найдвар өвөрлөн, зүрхэндээ баахан Бичээс суулгаж билээ. Тэдгээрийн нэг нь Иаков номд буй: “Хайрт ах дүү нар минь... сонсохдоо түргэн, ярихдаа удаан, уур хилэнд хойрго байг” (1:19).

Тухайн үед би яг энэ үгийн эсрэг дүр нь байлаа. Ярихдаа хурдан, сонсохдоо хойрог, уурлахдаа түргэн! Надад болж бүтдэг тал байсангүй.

Тэгээд хэл амныхаа асуудал дээр Бурханаас тусламж гуйж, Давидтай адил “ЭЗЭН, аманд минь манаач тавьж, уруулын минь хаалгыг хамгаалаач!” (Дуулал 141:3) хэмээн залбирдаг болов.

Буруу үг мулт үсрээд, хор хөнөөлөө тарьчихгүйн тулд энэ хамгаалалтыг тавьжээ. Ариун Сүнс бидний зүрхэн дэхь Бичээсийг аваад, яг зөв үед гаргаж ирдгийг би сурсан. Энэ нь хазгай үг хальтрахын даваан дээрх анхааруулга болно.

Хүний зуршил эвдэгдэхэд хорин нэг хоног хэрэгтэй байдгийг шинжлэх ухаан тогтоосон. Зуршил хүчтэй эд. Зуршил нь хүмүүний

бодлогогүйгээр, шууд үйлддэг хариу үйлдэл. Тухай нь, би нэг хэсэг юм л бол дүрсхийдэг зантай байлаа. Юун хорин нэг хоног тэсэх. Бүтэхгүй. Хорин нэгэн жил өнгөрсөн ч, засрахгүй. Бараг л миний эд эсэд шингэсэн зан гэмээр.

Тэгэхээр, зуршлыг хэрхэн эвдэх вэ? Бий болгосон замаараа л эвдэнэ. Зөвхөн энэ удаа л тэвчих, таван минут л тэвчих, ганц цаг л тэвчих, ганц өдөр л тэвчих. Би ийм хандлагаар л уурын тойргоо эвдсэн. Өглөө сэрээд нүдээ нээхээсээ өмнө “Бурхан минь, өнөөдөр Та надад хэрэгтэй. Миний амыг ян тан байлгаарай. Би Таны ч, хүний ч эсрэг нүгэл үйлдмээргүй байна. Надад ярихдаа хойрог, сонсохдоо түргэн, уур хилэнд залхуу байхад туслаарай” гэж залбирна. Эдгээр Бичээсийн сануулга нь миний өдөр бүрийн залбирал, хүч болсон юм.

Амархан байгаагүй ээ. Гэхдээ Бурхантай байхад боломжгүй зүйл гэж үгүй. Тэр цагаас хойш би ухаан мэдрэлгүй уурлаж сэгсгэнэхээ болиод хориод жил болжээ. Бичээсийн хоёр жижиг үрийг суулгаж, тордсоны минь ачаар л ургасан ургац.

Тэгвэл чи өнөөдөр зүрхэндээ юу тариалах гэж байна? Юу хураамаар байна? Үгээс үрийг нь олж, суулгаад, Бурхан хэрхэн ургуулахыг үз.

*Бурхан минь, сэтгэлдээ суулгах ёстой Бичээсийг зааж өгөөч.
Итгэлээр суулгаж, тордох үед Та ургуулна гэдэгт итгэж байна.*

— Би хүчирхэг —

БИ БУРХАНЫ ҮГИЙГ ЗҮРХЭНДЭЭ СУУЛГАЖ,
ҮГИЙН ДАГУУ ҮЙЛДЭХДЭЭ, ХҮЧИРХЭГ.

АМРАХЫН ХҮЧ

*Долоо дахь өдөр гэхэд Бурхан хийж байсан ажилаа гүйцээгээд,
хийж байсан бүх ажлаасаа Тэрээр долоо дахь өдөртөө амарчээ.*

ЭХЛЭЛ 2:2

Саббатын тухай ярихаар олон хүн ял мэдэрдэг. Эмэгтэйчүүд бид “угаалга” гэдэг мөнхийн албатай. Угаалгаа хийхгүй бол овоороод, дийлдэхээ болино гэдэг байнгын айдастай. Ар гэртэй улс чинь юун амрах. Гэр бүлээ дагуулж чуулганд явах чинь нүсэр ажиллагаа. Эхлэл 20:8 дээрх “Саббат өдрийг ариунаар сахихаа мартуузай” гэдэг дөрөвдүгээр тушаалыг зөрчмөөр байгаадаа бус, зүгээр л налайж суух цаг алга гэж боддог учраас л тэр. Эцсийн эцэст энэ маань итгэлцлийн л асуудал. Бурхан биднийг халамжилж амжихгүй учраас, бидэнд ч завсарлага авч, амрах цаг алга л гэсэн зовиур.

Үнэндээ, амрах өдөр (Саббат) нь эрүүл мэнд, сэргэлт рүү л дуудсан уриалга юм. Миний хувьд, Бүтэн сайнд амрах боломжгүй учраас, Саббатыг арай өөрөөр сахидаг. Есүс ч дагалдагч нартаа үйлчлэлээсээ амарч байхыг уриалсан: “...зэлүүд газарт оч. Жаахан амар.” (Марк 6:31). Дагалдагч нар амралтгүй ажилласаар, унаад өгбөл, өөрсдөө ч хохирох, үйлчлэл ч хохирохыг Есүс мэдэж байв. Хүн ядарсан үедээ сайн шийдвэр гаргадаггүйг би зовлогоороо сурсан. Цуцсан хүн зөвшөөрөх ёстой зүйлээсээ татгалзаж, татгалзах ёстой зүйлээ зөвшөөрдөг. Тэгээд тааруу шийдвэрээсээ болоод улам цөхрөх.

Тиймээс Есүсийн амралтын урилгыг хүлээж ав. Заавал Бүтэн

сайн гэлтгүй, нэг өдрийг юмуу хагас өдөр, хэдэн цагийг ч хамаагүй сонгоод, бие сэтгэлээ сэргээх цаг болгон нөөцөл. Зориулалт гарга, урьдаас төлөвлө, утсаа унтраа, компьютераа хаа, тухайн хугацаанд саад болохгүй байхыг хүмүүст урьдаас мэдэгд. Хүүхдүүдтэйгээ инээлдэж, нөхөдтэйгээ зугаацаж, хань ижилтэйгээ цагийг өнгөрөө. Гадуур хооллох юмуу урьд орой нь хоолоо хийгээд тавьчих. Гэрийнхээ ажлын жагсаалтыг битгий давтаад бай. Угаалгыг умарт. Гэрээсээ бүү ажилла. Өнөөдөр бол амрах өдөр. Бурханаас хайрласан амралтыг эдэлж сур. Энэ цагаар зүрхээ сахь, торд, хамгаал. Тэгж байж л Бурханы дараа дараагийн ажилд бэлэн болно.

Ажлынхаа цагаар ажилласан шиг ажиллаад, амрах цагаараа амарсан шиг амар! Цэнэг авахын тулд Бурханы хэлснээр амар.

*Эзэн минь ээ, би үрэгдэж дуусмааргүй байна. Ажил,
амралтаа тэнцвэртэй авч явахыг зааж өгөөч.*

Би хүчирхэг

БУРХАН БҮХНИЙГ ХЯНАЖ БАЙГАА ГЭДЭГТ
ИТГЭН, АМРАХДАА, БИ ХҮЧИРХЭГ.

БУРХАНЫ ТӨЛӨӨЛӨГЧ

Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний хүчирхэг үйлдлийг та нар тунхаглах юм. Та нар урьд нь ард түмэн ч биш байсан бол одоо Бурханы ард түмэн болжээ. Та нар өршөөлийг хүртээгүй байсан боловч одоо та нар өршөөлийг хүртжээ.

1 ПЕТР 2:9-10

Олимпийн тамирчдын гавъяаг үнэлэн, медаль гардуулах үеэр тамирчид улсынхаа төрийн далбааг нөмөрч гангардаг. Тэгтэл шагнал гардуулах ёслолын дундуур Америкийн тамирчин Канадыг төлөөлнө гэвэл, яах уу? Зөвшөөрөх үү? Зөвшөөрөхгүй! Тэрбээр Канадыг бус, Америк улс, Америкчууд, Америк соёлыг төлөөлсөн тамирчин.

Тэгвэл бидний хувьд ч ялгаагүй. Бид чинь тэнгэрийн төлөөлөгч, элчингүүд. Уулзсан хүмүүстээ хэний хүн болохоо, ямар хаанчлалынх болохоо харуулах учиртай. 2Коринт 5:20 дээр элч Паул биднийг “Христийн элчингүүд” гэсэн бол, Петр “язгуурын тахилч нар” гэсэн. Бидэнд Бурханы язгууртан тахилч нарын гэр бүлийн гишүүн бөгөөд элчин байх хүндэтгэл хүлээлгэжээ. Тийм байтал бид Бурхан Аавынхаасаа өөр хаанчлалыг төлөөлөхийг хүснэ гэж үү? Петр цааш нь:

Та нар урьд нь ард түмэн ч биш байсан бол одоо Бурханы ард

түмэн болжээ. Та нар өршөөлийг хүртээгүй байсан боловч одоо та нар өршөөлийг хүртжээ. Хайртууд аа, сэтгэлийн чинь эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалуудыг цээрлэхийг ирмэл агаад түр суурьшигч та нараас би гуйя. Харийнхан дунд биеэ зөв авч яв. Ингэснээр тэд та нарыг муу муухайг үйлдэгчид хэмээн гүтгэвч, сайн үйлсийг чинь хараад Түүний харгалзлын өдөр Бурханыг алдаршуулах болно (1Петр 2:10-12) гэжээ.

Нэгэн цагт бид Бурханых байгаагүй ч, эдүгээ Бурханых болсон. Нэгэн цагт бид Бурханы шүүх дор байсан ч, эдүгээ өршөөлд нь багтсан. Өөрөөр хэлбэл, бид нэгэнтээ шүүхийн тогтоол дор энэ дэлхийнх байсан бол, эдүгээ энэ дэлхийнх бус, Бурханы хаанчлалынх болсон. Тийнхүү бид нэгэн цагт харьяат нь байсан дэлхийнхээ хувьд харь хүмүүс болжээ. Бид дэлхийд илгээгдсэн Бурханы төлөөлөгч, элчин сайд - тахилч юм.

Өнөөдөр чи сонголт хийхдээ, үйлдэл хийхдээ, хариу үйлдэхдээ, хэний индэр дээр зогсож байгаагаа санаарай. Хүмүүсийг өөрийн эрхгүй Бурханыг алдаршуулж, аугаа магтаалд дуу хоолойгоо нэгтгэтэл нь зөв амьдраарай.

Эзэн минь, Таны элчин байх нь нэр төрийн хэрэг. Миний амьдрал, үйлс Таны сайн сайхан, нигүүлсэл, өршөөлийг л харуулах болтугай.

Би хүчирхэг

БИ АЛДРЫН ХААНЧЛАЛЫГ, ЯЗГУУРЫН
ТАХИЛЧЛАЛЫГ ТӨЛӨӨЛЖ, БУРХАНЫ
ӨРШӨӨЛӨӨР ТИТЭМЛЭГДСЭН
УЧРААС, ХҮЧИРХЭГ.

Эрх чөлөөгөөр
хүлээх

НҮГЛЭЭС ЧӨЛӨӨЛӨГДСӨН

*Есүс тэдэнд —Үнэнээр үнэнээр Би та
нарт хэлье. Нүгэл үйлдэгч бүр нүглийн
боол мөн. Иймээс Хүү та нарыг чөлөөлвөл
та нар үнэхээр эрх чөлөөтэй болно.*

ИОХАН 8:34–36

Хүү биднийг чөлөөлөхөд, бид “жинхэнээсээ эрх чөлөөтэй” болно. “Жинхэнээсээ” гэдэг нь юу гэсэн үг вэ? “Ямар ч эргэлзээгүй, баталгаатай” гэсэн үг. Хүмүүс чамайг чөлөөлөгдөх эрхтэй хүн мөн эсэхэд чинь эргэлзэх. Үүх түүх чинь чамайг алдаагаар чинь далайлган ичээж болох. Хүмүүс чамайг чулуугаар нүүлгэж алахыг хүсч болох ч, Есүсийн “—Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ. (Иохан 8:11) гэдэг үг амьдрал дээгүүр чинь цуурайтаж байна.

Нэгэнт нүглээ улайсан бол, нүгэл, ичгүүр, бусдын ял, өөрийнхөө зэмийн мэдрэмжээ ардаа үлдээгээд, урагш хөдөл. Бид харанхуйгаас Бурханы гэрэл рүү нэвтрэхдээ, цаашид нүгэл үйлдэхгүй байх хүчийг олдог. Бурхан чамайг ялгүй гэсэн бол, чи үнэн дотор эрх чөлөөт хүн. Энэ тал дээр мэдрэмж худлаа ярьдаг учраас, мэдрэмждээ бүү итгэ. Бид дотроо ч, гадраа ч зөвт биш учраас, хэзээ ч зөвт байдлыг мэдрэхгүй. Бид Бурханы өмнө үйлсээрээ юмуу зан авираараа бус, гагцхүү Христийн дотор л зөвтгөгдсөн болой. Энэ нь биднийг өнгөрснийхөө алдаа, бүтэлгүйтлээс нүүж, урагш хөдлөх

хүчтэй болгодог. “Урьдын юмыг бүү дурсагтун. Эртний юмыг бүү бодогтун.” (Исаиа 43:18).

Өнөөдөр нь өчигдрийн бүтэлгүйтэлтэй уялдаагүй. Бид өглөө бүр шинээр буудаг өршөөлөөр амьдралын шинэ хэв рүү хөл тавих эрх чөлөөтэй.

*Тэнгэрийн Аав минь ээ, би Таны
өршөөлийг хүлээн авч байна. Таны
өршөөл миний амьдрал дээрх ялтай хэсэг
болгон дээр ялгуух болтугай. Өөрийгөө
үзэн ядах, ялын энэ газрыг орхиё.*

Би хүчирхэг

НАМАЙГ ДЭЭДИЙН ДЭЭД ШҮҮГЧ
БҮХ ЯЛ, ИЧГҮҮРЭЭС ЧӨЛӨӨЛСӨН
УЧРААС, БИ ХҮЧИРХЭГ.

ШИНЭ ЗҮРХ

*Тэгээд Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор
шинэ сүнсийг өгнө. Би бие махбодоос чинь чулуун
зүрхийг зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө.*

ЕЗЕКИЕЛ 36:26

Христэд итгэдэг хүмүүс бид Библийн хэлдгээр “махан зүрхтэй” буюу өр зөөлөн зүрхийг хүсэн эрмэлздэг. Байнга энэрэл, хайр, Бурханы удирдамжид мэдрэг чанараар өсч байдаг зүрхийг. Тэнгэр нь зүрхэнд маань бичигдсэн хайрын ариун коодоор засаглагддаг. Чулуун дээр сийлэгдсэн, амьгүй дүрэм нь хатуурсан, үхмэл зүрхэнд зориулагдсан юм. Эрх чөлөөний хууль нь чулуужсан хатуу зүрхэнд бус, харин зөөлөн махан зүрхэнд зориулагдсан болно.

Гэхдээ өр зөөлөн зүрх нь чулуун зүрхнээсээ хавь илүү хайрлах ч, зовиурлах ч хүчин чадалтай байдгийг хэлэх хэрэгтэй. Зөвшөөрөөд байвал, шаналал нь бидний зүрхийг хатуулж, сэрэмжтэй байхгүй бол, эрт орой хэзээ нэгэн цагт амьдралаас минь Бурханы юмсыг нүүлгэнэ. Хүнд, хөндүүртэй мэдрэмж нь үүний дохио. Ийм зүрхэнд бусдыг уучлах улам л бэрх болно. Хорсол, эсэргүүцлийн ирэн дээр амьдрах хэцүү.

Гэхдээ хамгийн хатуу зүрх ч Бурханы Үгийн үнэнээр чөлөөлөгддөг. Миний бие Христэд итгэсэн хойноо ч байн байн зүрхнээсээ үзэн ядалтыг илрүүлдэг байсан ч, хадгалж үлдэхийг хүсээгүй юм. Чиний зүрхэнд - шийдвэрлээгүй гомдол, уур хилэн, үзэн ядалт, атаархал зэрэг бидний амархан урхидуулдаг нүглээс чөлөөтэй гэдгийг баталгаажуулах хамгаалалт хэрэгтэй. Зүрхээ хамгаалах нэг арга нь байнга үнэнээр зүлгэж байх. Үүний тулд

мэдээж хөдөлмөр, даруу зан, үнэнч чанар шаардагдана. Гэхдээ зүрх гэдэг ийм л үнэт зүйл.

Өнөөдөр ч чиний тархинд учир зүйн тулаан болж байгаа байх. Чамайг хорлож хохироосон урт дараалал бүхий хүмүүсийг уучилж, чөлөөлөх ятгалга нь тэднийг жадлан эсэргүүцэхийг зөвшөөсөн зөвтгөлтэй мөргөлдөж байгаа байх. Эхний дуу хоолойг л сонсоорой. Хатуу зүрх хэзээ ч, хэнийг ч хамгаалахгүй.

Аав аа, би хатуу зүрхээ гэмшиж байна.

Та Үгээрээ хатуурлыг хага цохиод,

махан зүрхийг минь ил гаргаарай.

— Би хүчирхэг —

БИ ЗҮРХЭЭ ХАМГААЛАН, ЗӨӨЛӨН
БАЙЛГАЖ, БУРХАНЫ ДУУ ХООЛОЙД
НЭЭЛТТЭЙ БАЙДАГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

МЭДЭГДЛИЙН ХҮЧ

...бие биенийхээ өмнө нүглээ улайж, бие биенийхээ төлөө залбир. Ингэснээр та нар эдгээгдэх болой. Зөвтийн залбирал үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлнэ.

ИАКОВ 5:16

Хүлээн зөвшөөрөл нь сүнсний хамгийн хүнд сахилга бат. Яагаад хэрэгтэй гэж? Аавдаа нүглээ улайхын даруй бид уучлагддаг. Гэхдээ Иаков ном дээр цаашаа нэг алхам лавшруулаад, эдгэрэхийн тулд мөн бие биедээ нүглээ мэдэгдэж, хамт залбирах хэрэгтэйг хэлжээ. Энэ нь гурван шалтгаантай гэдэгт би итгэдэг.

Нэгдүгээрт - хаанчлал нь байгалийн хуулиар ажилладаггүй. Есүс Фарисайчуудад эмэгтэй хүн рүү тачаалын нүдээр харсан нь зүрхэндээ завхайрсан хэрэг гэснийг санаж байна уу? Хаанчлалд зүрхний асуудал л хамгийн чухал. Бидний зүрх сайн, муугийн үрийг боловсруулагч хөрс болой. Фарисайчууд, бодитоор үйлдээгүй, зүрх хавьцаа өрнөсөн нүглийг нүгэлд тооцдоггүй байж.

Хоёрдугаарт - нүглээ мэдэгдэх замаар өөрийгөө даруусгаж, итгэл нэгт нөхөдтэйгээ залбирснаараа, бид эдгэрэх зам дээрээ гарна. Нүглийг нээлттэй, аюулгүй орчинд ил гаргах үед зүрхний харанхуйлал руу эдгэрэл урсаж ордог. Мэдэгдэл нь нүгэл, ичгүүрийн хэсэг дээр гэрэл тусгаж, тэр гэрлийн уур амьсгал дотор залбирал нь эдгэрэл, сэргэлтээ эхлүүлдэг.

Гуравдугаар шалтгаан: мэдэгдэл нь бидэнд хариуцлагын тогтолцоо өгдөг. Мэдэгдэлтэй хамт хариуцлага ирнэ. “Андын чинь

учруулсан шарх сайныг. Дайсны чинь үнсэлт заль мэхийг.” (Сургаалт үгс 27:6). Би өрөвдүүлэх гэсэндээ биш, харин намайг сайн сайхан болгохын төлөө зөвөөр өвтгөөд өгөх хүнийг хүссэндээ, буруугаа мэдэгддэг ба түүнтэй хамт залбирсны дараа мөрөн дээрээс хүнд ачаа авагдчих шиг л болдог.

Гэхдээ зуршлын асуудал үлдэнэ. Матай 16:24 дээр Есүс “Тэгээд Есүс шавь нартаа —Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага.” хэмээсэн. Мэдэгдэл нь Бурханаас бүрэн хамаарахаа мэдэгдэж, “загалмайгаа авахын” нэгэн хэлбэр юм. “Өөрийгөө няцаахуй” нь өөрийгөө цэгцлэх юмуу өөрийн биеэр нүглийн тойргоо эвдэх явдал. Мэдэгдэл нь энэ бүхнийг бид ганцаараа хийж чадахгүйгээ хүлээн зөвшөөрч буй явдал. Бурханы бөгөөд гэр бүлийнхээ тусламжаар бид эдгэрэл рүү чиглэж эхэлнэ.

Аав аа, мэдэгдлээр ирдэг эдгэрлийг харуулаач. Намайг зөв хүмүүс рүү чиглүүлж, загалмайгаа үүрэх чинээний шударга, зоригтой, нээлттэй байхад туслаач. Би Таныг дагаж, өөрөө хийж чадахгүйгээ хүлээн зөвшөөрч байна.

— Би хүчирхэг —

БИ ЗАГАЛМАЙГАА АВААД, ҮҮРЭГ,
ХАРИУЦЛАГАА ҮҮРЭХДЭЭ, ХҮЧИРХЭГ.

НҮГЛЭЭС ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ

*... сүсэг бишрэлгүйг болон ертөнцийн шуналыг
үгүйсгэхийг, мөн эдүгээ үед биеэ цэнэдэг ба
сүсэг бишрэлтэй амьдрахыг бидэнд сургадаг.
Ингэхдээ бид аугаа Бурхан ба Аврагч Есүс
Христийнхээ ерөөлт найдвар хийгээд цог
жавхлант илэрхийллийг хүлээдэг. Тэр Өөрийгөө
бидний төлөө өгсөн нь биднийг алив ёс бус
явдлаас золин, сайн үйлсэд зүтгэгч тусгай ард
түмнийг Өөртөө цэвэршүүлэхийн тулд юм.*

ТИТ 2:12–14

Нүгэл биднийг эрхшээхээ больсон. Энэ бол хамгийн сайхан мэдээ! Бид хэд, хичнээн удаа нүгэлд толгой дохисон эсэхээсээ үл хамааран, бидний ирээдүйд орших орон нүгэлд байхгүй. Бидэнд ичгүүрээр урхидах гэсэн нүгэлд толгой сэгсрээд, эргээд явах бүх эрх нь бий! Есүс нүглийн хүчийг тастаад, бидэнд өршөөлөө сунгаад, Бурханы нигүүлслээр амьдрах хүчтэй болгосон. Христ бидний нүглийг Өөр дээрээ авсан учраас, Христийн дотор бидэнд ял үгүй. Бид уучлагдсан бөгөөд үхлээс амь руу шинээр төрсөн. Хайрт охид минь, сэтгэлийн чинь дайсан чамд үүнийг мэдүүлэхийг хүсдэггүй. Сэтгэлийн чинь дайсан чамайг нүглээр чинь боомилж алах гэсэндээ ичгүүр дотор чинь л хорих санаатай. Өөрийнх нь дээр хүчийг тогтоосон гэдгийг дайсан чамд мэдүүлэхийг үл хүсэх. Мэдээж бид хүнийхээ хүчээр мянга оролдов ч, бүтэлгүйтдэг жамтай ч, эдүгээ

ганцаараа тулалдаагүй. Бид Түүний дотор байгаа бөгөөд бидний зэвсэг хүчирхэг!

*Есүс ээ, нүглийн хүчийг эвдсэнд
баярлалаа. Би дайсны хүчийг
эсэргүүцэж, нүглээс Тан руу эргэж
байна. Таны үхэл надад энэ тулаанд
ялахад хэрэгтэй бүхнийг өгсөн.*

Би хүчирхэг

ХРИСТ НАДАД НҮГЛИЙГ ЯЛГУУХ
ХҮЧИЙГ ӨГСӨН ТУЛ, БИ ХҮЧИРХЭГ.

ДЭНДҮҮ ӨВДӨЖ БАЙНА

*Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид
үхэл гэж байхгүй, гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно.*

ИЛЧЛЭЛ 21:4

Зовиураасаа сал! Чи “Яаж салах юм бэ?” хэмээн гайхаж байгаа байх. Чиний зовиурыг ойлгохгүй, чамайг яасныг мэдэхгүй, ямар гүн шархлуулсныг мэдэхгүй болохоороо, том, том ярьж байна гэж бодож байгаа байх. Тийм ээ, чиний зөв. Би энэ бүхнийг мэдэхгүй ч, мэддэг Нэгэн буй. Шархыг тоочоод дуусахгүй. Магадгүй зарим чинь итгэж явсан дотны хүндээ хүчирхийлүүлж, ашиглуулсан ч юм уу. Зарим чинь танихгүй хүнд хүчиндүүлж, халдуулсан ч юм уу. Эсвэл хэзээд хамт гэж амласан хүн чинь хаяад явсан ч юм уу. Эсвэл үр чинь ямар ч утгагүй, аймшигт үхлээр амиа алдсан ч юм уу. Эсвэл хайртай хүн чинь чамд хүншгүй хандсан ч юм уу. Эсвэл эцэг эх чинь чамайг үргэлж голж хэмлэсэн ч юм уу. Эсвэл хүмүүс гадаад төрхөөр чинь элэглэсэн ч ч юм уу. Ийм гадуурхалд ялангуяа тахир татуу хүмүүс их өртдөг. Тэгээд мэдээж хамгийн том харуусал нь ихэнх хүнээс дотны хүн нь урвасан байдаг.

Эдгээр болоод энд багтаагүй өөр олон эмгэнэл нь биднийг насан турш эрэмдэглэж орхидог. Тэгээд хамгийн эмзэг байх үеэр Сатан шархтай сэтгэлд минь хорслын үг, өс хонзонгийн бодлыг цацаж амжина. Сатан бидний зовиурыг мартуулахгүйн тулд шархаа ахин дахин хуулахад хүргэдэг. Сатан биднийг шархаа хэзээ ч аниулалгүй,

элгэндээ эвхээсэй гэж хүснэ. Ингэж байж л ирээдүйн хүчирхийллээс сэргийлнэ гэдэг хуурамч амлалтыг ч давхар өгнө.

Гэтэл эдгэрэл нь бүх зовиураа жинхэнээсээ ойлгодог Есүст шилжүүлэхэд л оршино. Исаиа дээр “Түүн дээр гэсгээл байж, шархаар нь бид эдгэрчээ.” (Исаиа 53:5) гэдэг.

Зовиуртайгаа зууралдаг хүн улам гүн шархална. Нүдээ аниад, бүх зовиураа Есүст өгч байна гээд төсөөл. Есүс чиний зовиурыг чамлахгүй. Есүст өгөөд, Түүгээр зайлуулж, солиул.

*Есүс, Та миний эдгэрэл гэдэгт би итгэж байна.
Би Танд зовиурынхаа хэлтэрхий бүрийг даатгаж
байна. Үүрэх албагүй зүйлээ үүрэхээс би татгалзаж
байна. Би зовиураа (зовиураа тооч) Таны мэдэлд
шилжүүлж байна. Таны алдраар солиорой.*

Би хүчирхэг

БИ ЗОВИУРАА ЭДГЭЭГЧИД
ӨГДӨГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ЭРХ ЧӨЛӨӨ ДОТРОО БАТ

Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсөн юм.

Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтун.

ГАЛАТ 5:1

Нэгэнт эрх чөлөөг олсон бидний хувьд, эрх чөлөөтэй амьдрах нь том тэмцэл. Соёл, шашны хүлээс нь биднийг дахин боолчлох гэж хүчтэй ажиллана. Дахин “боолчлолын буулгыг” зүүж, нэгэнтээ биднийг боолчилж байсан, ичгүүрээр хүлэгч нүглийн дараастай, зовлонт жинг үүрүүлэхийг хүснэ. Эрх чөлөө нь нэгэн зэрэг ганц амьсгаагаар болоод цаг хугацааны явцад өрнөдөг зүйл. Есүст амьдралаа өргөх үед Есүс биднийг чөлөөлж, эрх чөлөө нь бидний болно. Үүний дараа цаг хугацааны явцад бид нэгэнтээ биднийг дарамталж байсан нүглийн эсрэг “бат зогсож”, өөрийн хүчээр төгс байх буулганаас татгалзсанаараа, өөрт олгогдсон эрх чөлөөгөө тасралтгүй эдэлсээр явна.

Тиймээс эрх чөлөө дотроо бат зогс! Чамайг дахин ялагдлын дарамт, нүглийн амьдрал руу чинь эргүүлэх гэж урхидах ял, ичгүүрийн эсрэг бат зогс. Муугийн үлгэр загварт үгүй гэж хэлэх эрхгүй хэмээн шившиглэх өнгөрсөн амьдралынхаа сүүдэр бүрийг сөрж зогс. Магадгүй өнгөрсөнд чи ичгүүр, ялаасаа болоод үгүй гэж хэлэх нүүргүй байсан байж болох ч, өнөө чи өнгөрснөөсөө чөлөөлөгдсөн бөгөөд ирээдүй чинь эрх чөлөөтэй, гэрэлтэй байна!

Христийн өгдөг жавхлант найдвар, эрх чөлөөний улмаас бид Эзэнтэйгээ дахин уулзахаас айхгүй. Учир нь Тэр биднийг ёрын

муугаас авран сэргээж, Өөрийн болгосон. Өмнө нь бид мууд дурлагч байсан бол, өнөө бид сайнд дурлана! Жинхэнээсээ дахин төрсөн хүний төрөлх хүсэл өөрчлөгддөг. Эзэн биднийг уучлаад, мөн чанарыг минь “Яв... дахиж нүгэл бүү үйлд” гэдэг үгээрээ өөрчилдөг. Энэ нь уучлалын нөхцөл биш. Уучлалыг хэдийн хүртээсэн. Энэ нь өөртөө итгэлтэй байхын санал бөгөөд сайн сайхан зүйлс айсуйн итгэл юм.

Есүсийн үгийг дараах байдлаар эш татаж болно: “Би та нарыг яллахгүй. Би та нарыг уучлан, нүглийн шүүх, ялын тогтоолоос суллаж байна. Одоо яваад, дахиж нүгэл бүү үйлд” (Иохан 8:11). Бидэнд сунгагдсан өршөөлийг бид ямар ч гавъяагаар олохгүйтэй адил Бурханы нигүүлсэлгүйгээр өөрсдөө бурханлаг амьдарч, дэлхийн дур хүсэл, нүгэлд үгүй гэж хэлж чадахгүй. “Эрх чөлөө нь Христ биднийг чөлөөлсний гавъяа” учир, бид дахиж нүгэл үйлдэхгүйгээр амьдрах хүчтэй болсон юм.

*Эзэн минь, надад уучлал, авран сэргээлтээ хайрласанд
баярлалаа. Намайг боолчлогч юмсаас эргэхэд тусалж,
эрх чөлөөгөө хэрэгжүүлэхийг зааж өгөөч.*

Би хүчирхэг

ХРИСТ НАМАЙГ ЧӨЛӨӨЛСӨН ТУЛ
БИ ХҮЧИРХЭГ. ЭНЭ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ
НОТОЛГОО НЬ МИНИЙ АМЬДРАЛД
ӨДӨР БҮР ӨССӨӨР БАЙНА.

ХҮЛЭЭСГҮЙ

*Тиймээс ах дүү нар аа, бид зарц бүсгүйнх биш,
харин эрх чөлөөт эмэгтэйн хүүхдүүд билээ.*

ГАЛАТ 4:31

Хүүхэд байхад аав надтай нэг их харилцдаггүй байлаа. Гэхдээ гүргэр занг минь магтахаас буцахгүй. Аав намайг “шар бар”, “шазруун шар” гэж хочилно. Ийм дүртэй эмэгтэйлэг төрх, даашинз сэлт нь огт авцалдахгүй. Тиймээс би хэзээ ч аальгүй, маягтай шар охин болохгүй гэж шийдсэн юм.

Тэгтэл дунд сургуульд байхдаа, нэгэн Хагас сайн өдөр кино үзэж байгаад, өөрийнхөө үлгэр жишээ бүсгүйн дүрийг олсон юм. Түүнд маяг, гоёо гэх юм байсангүй. Амьдрал нь цул адал явдал. Тэрбээр Жэймс Бондын сонгомол бүсгүй. Бариу өмдтэй, буу шийдэм эргүүлсэн, эрчүүдтэй эгнэж гүйсэн тэр дүр надад хачин дотно санагдав. Тийм охид хэний ч дор оролгүй, эрчүүдтэй ана мана үзэлцэх. Тэд өөрийг нь хамгаалаад өгөх эрийг хүлээлгүй, өөрөө өөрийгөө хамгаалчихна.

Гэхдээ Бондын охидод нэг асуудал бий. Миний санаж байгаагаар 007 кино болгон дээр тэд ээлжлэн үхдэг. Киноны төгсгөлд Бонд амьд үлдсэн хүүхэнтэй нь нэг хөнжилд ороод дуусдаг ч, дахиад хамт гардаггүй. Бонд дараагийнхаа адал явдалд өөр шинэ гоё хүүхэнтэй хамт гарна. Тэгэхээр, тэд нээрээ л өөрийнхөө үнэ цэнийг мэдэхгүй “хүлээстэй” хүүхнүүд гэж хэлж болох. (Бонд гэдэг нь “хүлээс, хүлэх” гэсэн утгатай үг.)

Сексийн тал дээрээ итгэл дүүрэн, хатуу, чанга тэдгээр хүүхнүүд анх тун зоригтой харагддаг ч, үнэндээ тийм үү? Бондын бүх хүүхэн

ялангуяа хяналтаас нь гарсан зүйлээсээ айдаг. (Эс бөгөөс юу гэж буутай явах билээ?) Олонх нь багадаа аавын хайр хамгааллыг үзээгүй өссөн учраас, асуудлыг гартаа авахаар шийдсэн хүүхнүүд. Зарим нь хайр, халамжаар өссөн ч, Бурханд итгэж байснаас өөрийнхөө чадлаар өөрийгөө хамгаалахад ухуулсан нийгмийнхээ суртал ухуулгад автжээ. Гэхдээ эцсийн дүнд бүгдээрээ л гаднаас дотогшоо өнгийсөөр үлдсэн улс. Дур булаам гэдэг нь эрх чөлөөтэй гэсэн үг огт биш.

Манай соёл бидэнд эрх чөлөөтэй эмэгтэй байхаасаа илүү хэн нэгний харъяат байх боломжийг л түгээж байна. Гэвч бид заавал ч үгүй цэцэгчин бүсгүй юмуу зэрлэг сарнай гэсэн энэ хоёр “төрлийн” аль нэг нь байх шаардлагагүй. Бурхан эмэгтэйчүүдийг төрөл төрлөөр бүтээсэн. Тиймээс хүний тогтоож өгсөн хязгаараар л амьдарна гэдэг худалд бүү авт. Бид ямар ч найдваргүй юмд найдагч хүлээстэй охид биш, харин Бурханы язгууртан охид. Тийнхүү бүрэн бөгөөд онцгой хайрлуулснаа мэдэж, яг өөрөөрөө байх учиртай.

Аав аа, би Таны бүтээсэн хүн л баймаар байна. Намайг байх ёстойгоосоо доошоо орох гээд байвал, хэн болохыг минь сануулаач.

— Би хүчирхэг —

БИ ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ТАЛААРХ ХИЙСВЭР
ДҮР ТӨРХӨӨР БООГДОЛГҮЙ, АМЬД
БУРХАНЫ ОХИН УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ШИНЭ БОЛГОГДСОН

Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна!

2 КОРИНТ 5:17

Христийг Аврагчаа бөгөөд Эзэнээ болгох үед нүглийн мөнхийн шийтгэл нь зүүн нь баруунаасаа хол байдаг шиг л (Дуулал 103:12) холуу зайлуулагдах. Нүгэл нь чиний сүнсийг хүлэх эрх зүйн үндэсгүй, өмчлөлийн эрхгүй болно. Чи эрх чөлөөтэй болсон. Тийм боловч, эрх чөлөө, уучлал нь нүглийн бодитой үр дагаврыг арилгахгүй. Би гэмт хэрэг үйлдэж, шоронд орсныхоо дараа аврагдсан бол, сүнс минь чөлөөлөгдсөн ч, бие минь шорондоо л байна. Энэ нь би уучлагдаагүй гэсэн үг бус, харин Бурханы зөвлөгөөг хайгаад, бодит байдлаа туулна гэсэн үг.

Би уучлагдсан бөгөөд шинэ бүтээл болсон гэдэг энэ үнэн хэрхэн хэрэгжих талаар чи гайхаж байж магадгүй. Миний хувьд, хуучин нь өнгөрч, бүх зүйл шинэ болсон. Бидний дотор ийм л үнэн ажилладаг. Бид нүглээ мэдэгдэх эгшиндээ уучлагдаж, бидний нүгэл угаагдана. Бид Христийн ер бусын өршөөлийг хүртсэн эгшиндээ л сүнсээр цоо шинэ болдог. Гэхдээ ингэлээ гээд өмнөх сонголт маань автоматаар нөлөөлөхөө болихгүй. Хэдийгээр би цаашид мөнхийн шийтгэл, ялгүй боловч, зарим үр дүн үлддэгээрээ үлдэнэ.

Тухай нь, би ганц бие явахдаа хүүхэд олчихсон бол, яах уу? Мэдээж миний хувьд том сануулга болж үлдэнэ. Тэгтэл би хүүхэд олсныхоо дараа Есүст итгэсэн бол, яах уу? Хүүхэд маань алга

болчих уу? Болохгүй. Би нүглээ уучлуулсан ч гэлээ, хүүхэд минь алга болгохгүй. Хүүхэд нүгэл биш. Үр хүүхэд нь миний хийсэн сонголтын хамгийн сайхан үр дүн. Хүүхэд минь гэрлэлтийн гэрээнээс гадуур мэндэлсэн ч гэлээ, түүнийг бэлэг мэт баярлан хүлээж аваад, хайрлах ёстой.

Бурхан бидний алдаа, эндэл, нүглийг авран сэргээх ажил хийдэг. Гайхамшиг бидний санасан арга замаар ирдэггүй бөгөөд хэлтэрхий, хагархайгаар үзэсгэлэнтэй бүтээл урлаж болно. Бурханы хувьд боломжгүй зүйл үгүй боловч, эмтэрсэн зүрх нь Бурханы нэн тэргүүний анхаарал болой. Бурхан чулуужиж, хагарсан зүрхийг аваад, зөөлхөн махан зүрхээр орлуулна. Бурхан биднийг шинэ болгосон гэдэгт итгэж болно.

*Эзэн минь, надад мөнхийн уучлал, бодит нөхцөл байдлын
үр дагаврын ялгааг харуулж өгөөч. Та намайг бүх
талаар шинэ болгож чадна гэдэгт би итгээж байна.*

— Би хүчирхэг —

БИ БОДИТ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ МИНЬ
ӨӨРЧЛӨХ ЧАДАЛТАЙ БУРХАНД
НАЙДДАГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ТҮҮНИЙХ БАЙХААР ЧӨЛӨӨЛӨГДСӨН

*Та нарт Канаан нутгийг өгөхөөр мөн Бурхан чинь
байхын тулд Египет нутгаас та нарыг гарган
авчирсан нь та нарын Бурхан ЭЗЭН Би билээ.*

ЛЕВИ 25:38

Та өнөөдөр үхлээ гэхэд, хаана очихоо мэдэх үү?” гэдэг асуултыг бид зөндөө сонссон. Энэ асуулт нь сонсогчийг “Би үнэхээр тэнгэрт баттай очих уу?” гэж өөрөөсөө асуухад хүргэх зорилготой. Итгэлгүй байгаа бол, залбираад, мөнхийн байр сууриа баталгаажуулах боломжтой. Гэхдээ өнө мөнх нь үхлийн дараа хүрдэг газар бус, харин эдүгээ амьдрах ёстой амьдралын хэв маяг юм. Дараах эшлэл нь Изралийг Египетээс чөлөөлсөн Бурханы хамгийн гол, гүн хүсэл, зорилгыг илчилж байна: “Би египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн Өөртөө яаж авчирсныг та нар өөрсдөө харсан” (Гэтлэл 19:4).

Би энэ эшлэлийн гоо үзэсгэлэн, хүчинд хайртай. Тэнгэрийн хүчит Хаан дөрвөн зуун жил дарлуулсан хүүхдүүдээ сэт хийтэл аврахаар сүн хийтэл бууж иржээ. Энэ үйл явц дундаа Бурхан тухайн үеийн дэлхийн хамгийн хүчирхэг улс Египетийг дэлсээд, хагархай тэвштэй нь үлдээсэн. Египетчүүдийн алт, мөнгө ч Израилийнх болсон.

Бурхан үүнийг ганц Израильд бус, чамд ч хүснэ.

Бидний галтай, ариун Бурхан чамайг мөшгиж байна! Тэр чамайг хүлээсээр, Түүний зүг харах эсэхийг чинь ажигласаар байна. Тэр

чамайг санасаар, Өөр рүү нь эргээд ирээсэй, Бичээс даяар сүлжсэн хайрынх нь үгсийг уншаасай гэж хүссээр. Тэр чамайг харанхуйн хорионы ертөнцөөс Өөрийнхөө гэрлийн амьдрал руу чөлөөлөхийг хүснэ. Тэр чамайг энэ дэлхийн харгис эзний чанга хүлээсээс суллаад, Өөрийнхөө өр зөөлөн хайр, өршөөлийг үзүүлэхийг хүснэ.

Авралын утга учир нь амлагдсан газарт бус, харин амлалтын Эзэнд орших. Бурхан чамайг эцсийн дүнд Өөр дээрээ л авчрахыг хүснэ. Хуучин гэрээний амлалт нь ердөө айсуй юмсын сүүдэр байв. Бурханы авралын эцсийн зорилго нь хүүхдүүдээ Өөр дээрээ л авчрахад л оршиж байжээ. Бурханы хайрт хүүхдүүд минь, аврал нь гал, амь даатгалаас том шүү!

Энэ дэлхийн харгислалаас шүүрэгдээд, Бурханы уулан дээр очих хүсэлгүй хэн байх билээ? Тэгээд ч энэ дэлхий бидний гэр биш учраас, энэ хүслийг улам бүр ноцоох хэрэгтэй. Аврал нь хүлээс, шүүхээс зугтах гарц мөн боловч, авралын утга учир үүгээр дуусахгүй. Бүгдээрээ Бурханых болохын төлөө тэмүүлцгээе.

Аав аа, намайг чөлөөлсөнд баярлалаа. Таных байхад минь юу ч саад хийхгүй. Эдүгээ би Таныг танин мэдмээр байна.

— Би хүчирхэг —

БИ БУРХАНЫХ БОЛОХООР
АВРАГДСАН УЧРААС, ХҮЧИРХЭГ.

Архын
байгуулал
хүчирхэг

ЭНЭ ДЭЛХИЙНХ БУС

*Та нар ертөнцийнх байсан бол ертөнц өөрийнхнийгөө хайрлахсан.
Харин та нар ертөнцийнх биш, гагцхүү Би та нарыг ертөнцөөс
сонгосон юм. Тиймээс ертөнц та нарыг үзэн яддаг.*

ИОХАН 15:19

Дэлхий биднийг эрхшээхгүйг Есүс тодорхой айлдсан. Энэ үнэн бидний амьдралд яг хэрхэн хэрэгжих вэ? Энэ дэлхий - тодруулбал дэлхийн соёл нь биднийг өөрийнхөө зан үйлдэл рүү урвуулдаг. Гэтэл бид энэ дэлхийн соёлд хамаарахаа болиод, Бурхантай болоод Бурханы хүмүүстэй харилцаатай болсон. Бид соёлоосоо өөр байхаар буюу үзэн ядахад нь хайрлахаар, харгислахад нь энэрэхээр дуудагдсан. Энэ ялгаа нь бидний ёс суртахууны луужин дээр ч хүчинтэй. Ефес ном бидэнд жинхэнэ хойд зүгийг зааж өгдөг: “Харин ариун хүмүүст үл нийцэх аливаа садар самуун, бузар булай, шунал нь та нарын дунд бүү дурдагдаг” (Ефес 5:3).

Энэ эшлэл дээр саарал хэсэг байхгүй. Яагаад ийм хатуу гэж? Миний бодлоор, яльгүй санаа ч бусдад эргэлзмээр, холимог мессеж илгээж чадах учраас, тэр болов уу. Бид Бурханых учраас, Түүнийг бүхий л үг, үйлдлээрээ хүндэтгэнэ. Энэ нь үг, үйлдэл маань бидний амьдрал дээрх Бурханы нөлөөллийг тусгах ёстой гэсэн үг. Бид Христийн дотор уучлагдахаар барахгүй, ариун болсон. Нэгэнтээ харанхуй татуулж явсан газартаа эдүгээ бид гэрэл гийгүүлэх болсон.

Ефес дээр цааш нь “Садар булай, шалиг балай эсвэл самуун балиар яриа нь зохимжгүй. Харин оронд нь талархалаа өргө” (Ефес

5:4) гэжээ. Паул мөн энэ жагсаалт дээр эргэлзээтэй зан үйлдэл, ёс бус явдал, тэнэглэл бөгөөд бохир хэл яриаг нэмжээ. Эдгээр харилцан ярианы юу нь ч бурханлаг чанартай эгнэхгүй бөгөөд эцэст нь угаадас л уулгана.

Ёс бусыг ярьж байхаар талархлаараа ус цас байя. Ийм замаар Бурханы таалал, өршөөлийг олох талархлын хандлагаа сахина. Ганц энэ шалтгааны улмаас л амаа мэдэж явбаас зохилтой. Шаль шаль хийгч, бүдүүлэг, гоншигногч, гомдоглогч байхын оронд хэл амаараа ерөөл, амийг урсгадаг Аавыгаа дуурайя. “Бүх юм сайхан болно... Зүгээр дээ... Бүгдээрээ л хийдэг шдээ...” гэх зэрэг хоосон үг нь хүний өөртөө эрдэх занг л бордоно. Хүний хоосон үгд бүү хуурт. Хоосон үг байдаг шиг, дүүрэн үг ч бас бий. Амийн үг нь биднийг илүү дээр юмс руу дууддаг. Тэдгээр нь Өндөр Бурханы охид - бид бусадтай адилгүйг минь сануулдаг. Бид дэлхий дээр байгаа болохоос, дэлхийнх биш (Иохан 17:15-16).

*Бурхан минь, дэлхий, Та хоёр хэрхэн өөр өөрөөр
ажилладгийг харуулаач. Би салаалсан санаагүй, цэвэр
сэтгэлээр Таныг үг, үйлдлээрээ хүндэтгэе..*

— Би хүчирхэг —

БИ ДЭЛХИЙН БУС, БУРХАНЫ СТАНДАРТААР
АЖИЛЛАДАГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ДУУЛГАВАРТАЙ ЗАНД СУРАЛЦАХ

*ЭЗЭНээс эмээдэг, Түүний замаар замнагч
хүн бүр юутай ерөөлтэй вэ!*

ДУУЛАЛ 128:1

Томчуудын гяланцагладаг зүйлсийг хүүхдүүд хуурайгаар шууд дууриах нь олонтаа. Томчууд бид Бурханыг дагамааргүй үедээ авирладгийг миний хоёр дахь хүү бяцхан Аустинд тохиолдсон явдал тод харуулдаг.

Аустиныг хоёртой байхад, найзууд нь тоглохоор зочлов. Явахад нь би хүүхэд болгонд чихрэн динозавр бэлэглэхээр бэлтгээд, найзууддаа өгөөрэй гээд хүүгийнхээ тосоотой алган дээр чихэр асгалаа. Хүүхдүүд харихдаа, нэг нэгээрээ чихрээ авсаар, хоёрхон чихэр үлдтэл, Аустин алгаа хавсарчив. Ганц л охин чихрээ аваагүй байлаа. Би хүүдээ: “Аустин, уутан дотор зөндөө чихэр байгаа. Наад хоёроо найздаа өг” гэв.

Гэтэл Аустин үгэнд оролгүй, толгой сэгсэрснээ, шуудангийн хайрцагны шонг тойрч зугтав.

Би гэртээ гүйж ороод, ууттай чихрээс охинд өглөө. Дараа нь найзууддаа хүүхдүүдтэй нь гаргаж өгөнгөө, Аустиныг шуудангийн шонгоос салгах гэж ноцолдов.

Гэрт орсон хойно байдал бүр дордов. Аустины хөлстэй гарнаас хайлж, нялцайсан чихрийг нь салгаж цэвэрлээд, тайвширтал нь өрөөнд нь оруулах гэтэл,

Нөгөөх чинь гал тогтооны шалан дээр дэвслээд: “Би өрөөндөө орохгүй!” гэж эсэргүүцлээ.

Би ч гал тогооноосоо тайван дуугаар: “Орох л болно” гэв.

Ийм маягаар хэдэнтэй давтагдсан ч, Аустины дуу цаашилсаар байгааг анзаарав. Өрөө рүүгээ дөхөж байгаа нь тэр! Арван тав орчим минутын дараа Аустин цонхийсон дуугаар: “Би унтахгүй, за! Унтахгүй, за!” гэв.

Тэгж байснаа таг болчихов. Яваад ортол, орон дээрээ нойрсож байлаа.

Аустин буруу хэрэг хийснээ, дараа нь юу хийх ёстойгоо яваандаа ойлгожээ. Тиймээс л нам унтаад өгч. Тэгтэл ядартлаа эсэргүүцээд яана? Тэгтэл цуцталаа тэмцэлдээд яана?

Тэгэхээр, бид дуулгавартай байхтай юунд тэгтэл тэмцэлдэнэ вэ? Миний хүүтэй л адил ядарна шүү дээ. Алга дүүрэн чихэр нь дундарсаар, алга болохыг Аустин үзээд, уур нь хүрчээ.

Үнэндээ, би түүнээс өөрийгөө олж харсан юм. Би ч бас үгээр илэрхийлэшгүй мэдрэмжийг үзсэн. Тиймээс л: “Бурхан, минь би бэлэн болохоороо юмуу ийм, тийм нөхцөлд л дагана” хэмээн эсэргүүцлээ илэрхийлдэг.

Харин төлөвших тусмаа, гараа зангидаж, аминчаар хариу үйлдэх бус, харин бидэнд юу нь зүйтэйг Бурхан мэднэ гэдэгт итгэж сурдаг. Зовлогоороо сурч байснаас, анхнаасаа зөвийг үйлдээд явчих нь хавьгүй амар буюу.

Эзэн минь, дуулгаваргүй загнахдаа, юу юуны туханд хүрэлгүй үйлдэх бус, харин түрүүлж Тан дээр очихыг зааж өгөөч.

Би хүчирхэг

БИ ТЭМЦЭЛДЭХГҮЙГЭЭР
ДАГАХДАА, ХҮЧИРХЭГ.

АРИУН БОЛГОГДСОН

Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм.

1 ПЕТР 1:15–16

Бурхан ариун... бид ч ариун. Ариун байдал нь бидний хувьд, сайн хүн болох гэсэн бас нэгэн бүтэлгүй оролдлого бус, харин Бурханых гэсэн илчлэл болой. Ариун байдал нь үйлчлэгч нарын ажлын нэршил бус, харин ариун Бурханы өмнө цугласан бүхэнд хамаатай тушаал юм. Бурхан ариун учраас, бид ч ариун болой. Биднийг ариун мэт үйлдээрэй, ариун царайлаарай гэж заагаагүй, харин ариун *бай* хэмээн урьсан. *Байх* гэдэг нь бидний оршихуйн хэсэг юмуу амийн хүч болдог гэсэн үг. Бид ариухан Ариун Сүнсээр дүүрч, удирдуулсан.

Ариун гэж юу гэсэн үг вэ? Дараах Бичээс бидэнд ойлгуулна байх: “Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм.” (Ефес 1:4).

Бид анхныхаа амьсгалыг авахаасаа ч өмнө сонгогдсон байв. Дэлхий бүтээгдэхээс ч өмнө бид Бурханы оюунд байв. Чи ариун ба буруутгалгүй байхаар Христийн дотор Бурханаар сонгогдсон. Есүс ариун ч, буруутгалгүй ч учраас, бид ч Аавын өмнө тийн зогсоно.

Христээс тусгаар бид Бурханы эрх хүч, амлалтаас тусдаа байв. Гэтэл загалмай дээр хөшиг хоёр хуваагдсан. Биднийг сөрж байсан

бүхэн нь загалмай дээр хадагдаж, бид Бурхантай нэг болгогдсон (Колоссай 2:14).

Ариун байхуй нь тусгаар байх - сүнс, сэтгэл, биеэр тусгаарлагдахуй болой. Товчхондоо, ариун гэдэг нь бид Бурханых л гэсэн үг.

Аав аа, намайг эрхмийн дээд тахилаараа ариун болгосонд баярлалаа. Намайг үйлдэл болгоноор минь Өөрийнхөө ариун чанар руу ойртуулаарай.

Би хүчирхэг

БИ АРИУН БӨГӨӨД БУРХАНЫХ
УЧРААС, ХҮЧИРХЭГ.

ГАЛААР ШИНЭТГЭГДСЭН

Үзэгтүн, мөнгө шиг биш ч Би чамайг цэвэршүүлсэн.

Чамайг зовлон зүдүүрийн зуухан дотор Би сонгосон.

ИСАИА 48:10

Алт, мөнгийг өндөр температурын галд хайлуулан шатаадаг. Энэ нөхцөл дор хаягдал, бохирдол нь ил гарна. Тэгээд металлыг хөрж, биежихээс нь өмнө хог хаягдлаас нь салгана. Энэ үйл явц нь металлыг султгагч хог, хольцоос нь бүрэн цэвэрштэл давтагдана.

Бурхан биднийг жинхэнэ зууханд хийлгүй, өөр арга замаар буюу бэрхшээлийн замаар шатаана. Бэрхшээлийг мөн зовлон, асуудал, дайсагнал, зовнил, сорил гэж нэрлэж болно. Бэрхшээлд дуртай хүн байхгүй ч, үр жимсийг нь үзмээр байгаа бол, үйл явц дээрээ үлдсэн нь дээр. Яагаад гэхээр сорил дундуур “явбал” бус, “харин явах үед” гэж яригддаг учраас, энэ нь тун чухал асуудал юм.

Чамайг ус гатлахад Би чамтай хамт байна. Голоор туулахдаа чи живэхгүй. Гал дундуур явсан ч чи түлэгдэхгүй, Дөл нь ч чамайг шатаахгүй. Исаиа 43:2

Амьдралын бэрхшээл нь үер, түймэртэй л адил. Энэ сорилыг тойрох завшаан хэнд ч олгогдоогүй. Гэхдээ энэ нь цаг хугацаатай бэрхшээл. Бид эрхшээгдэхээс татгалзсан цагтаа л бэрхийг даван

туулна. Бурхан Аав юу хийж байгаагаа мэднэ. Шатаах үйл явцаар бид улам л бэхжээд нөгөө талд гарна.

Бурхан бидний тав тухд бус, нөхцөл байдалд илүү санаа тавьдаг. Энэ нь Бурхан бидний үнэн нөхцлийг илчлэхийн тулд амьдралыг минь тухгүй болгохоос буцдаггүй гэсэн үг. Шатаах үйл явц нь бидний залбирлаас эхлэх нь олонтаа. Бидний өсөлтөд саад болж байгаа юмуу Бурханд таалагдахгүй юмсыг зайлуулахыг гуйх үед юмс улайдаж эхэлдэг. Галт сорил нь бидний хүчийг ч, алдааг ч зэрэг зэрэг илчилнэ. Гал дунд дуулж, талархлынхаа залбирлыг үерийн дээгүүр тат. Учир нь Бурхан чамайг Өөрийнхөө зорилгын төлөө, чиний хүчийн төлөө шинэтгэж буй.

*Эзэн минь, нүдийг минь нээгээд, бэрхшээл,
дайсагнал нь үнэндээ намайг өөрчлөх хүчин зүйлс
болохыг ойлгуулж өгөөч. Та намайг зууханд
орхихгүйг би мэднэ. Тиймээс Өөрийнхөөрөө л хий.*

Би хүчирхэг

БИ АМЬДРАЛЫН ГАЛААР ШИНЭТГЭГДЭЖ,
ЗҮРХЭЭ ЦЭВЭРШҮҮЛЭХИЙГ
ЗӨВШӨӨРӨХДӨӨ, ХҮЧИРХЭГ.

МАХ БИЕЙН МАЦАГ

*Тиймээс Бурханд захирагдагтун. Диаволыг
эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна.*

ИАКОВ 4:7

Мацаг нь сэтгэлийн жинг бууруулах төгс арга юм. Бодол, үйлдэл, зуршлаасаа татгалзах нь дан сүнсний мацаг болно. Харин махан биеийн мацаг нь Бурханыг хайхын төлөө хоолноосоо татгалзах Библийн үйл юм.

Махан биеийн мацаг нь хоолны мацгаас юугаараа ялгаатай вэ? Нэгэн том ялгаа нь хоолны мацаг нь гадаад төрхийг өөрчилдөг бол, махан биеийн мацаг нь харааг өөрчилнө. Нэг нь жингийн заалтыг өөрчилдөг бол, нөгөө нь нүднээс чинь хаалтыг зайлуулна! Махан биеийн мацаг нь Бурханд захирагдахуйг илэрхийлнэ. Бид ажил амьдралаа зогсоогоод, өвдөг дээрээ сөгдөөд, Бурханд бууж өгөхөд, дайсан аймшигт автаад, зугтана! Хоолноосоо татгалзах үед Бурханы юмст дурлах өлсөө, цангаа маань хүчээ авахад бэлэн болно. Бид Бурханы Үгээр хооллож, Түүний сайн сайхан, хайрыг санах үед дуршил минь өөрчлөгддөг. Биеийн мацаг нь өндөр сэрэмжийг дагуулдаг бөгөөд зүрхийг зөөллөх нөлөөтэй.

Анх удаа махан биеийн мацаг барих гэж байгаа бол, чихэр, гурил зэрэг эрүүл бус хүнснээс татгалзах маягаар, энгийнээр эхэл. Даниелийн мацгийн талаар уншаа л байх. Эсвэл дан өдрийнхөө хоолоор мацаг барьж болно. Янз бүрийн эм хэрэглэдэг хүн усан мацаг барих зорилготой байгаа бол, эхлээд эмчтэйгээ зөвлөлдсөн нь дээр.*

* Энэ ном нь эрүүл мэндийн зөвлөгөө юмуу таны эмчийн зөвлөгөө, эмчилгээг

Махан биеийн мацаг нь махан биеэ няцаах явдал юм. Тиймээс махан бие чинь тухгүйтнэ. Гэхдээ сүнсний тал дээр энэ нь баяраа тэмдэглэх, найрлах, баярлах цаг! Хааныг хүндэтгэх үед Хаан чамайг оршихуйгаараа хүндэтгэнэ. Махан биеийн мацаг нь шийтгэл бус, эрхэм завшаан болой.

Түүнчлэн энэ нь амьдрал, үхлийн асуудал, үхлийг хүлж байгаа хэрэг гэдгийг мэдээрэй.

Бурханыг эрэн хайлгүйгээр, хоосон хоол хорих нь нэн утгагүй. Мацгийнхаа үеэр элдэв шалдав юмст түүртэхгүйн тулд шаардлагатай юмсаа урьдаас бэлд. Утас, компьютер, олон нийтийн сүлжээ, зурагтаа унтраа. Магтаал, хүндэтгэлийн дуу тавь. Саббат учраас, өөр юм бүү хий. Амар, унт тэгээд Бурханд ойрт. Бичээсийг юмуу тэр дундаа мацгийн талаарх амлалт бүхий Естер номыг эсвэл шандсыг чинь сорих өөр Христэч ном зохиол унш.

Мацаг барихдаа, чи сүнсээ бэхжүүлнэ. Энэ үеэрээ залбирлын тэмдэглэл хөтөл. Аавтайгаа нээлттэй, шударга харилцаж, залбирал, Бичээсээр дамжуулж хэлсэн үгийг нь тэмдэглэж ав.

Энэ бол хайрлах цаг бөгөөд Бурхан чамд амьд ус, тэжээл өгнө.

*Бурхан Эзэн минь, надад ойртооч. Миний дурилыг хувиргаж,
Танаар өлсгөж, цангаагаач. Би Таныг ярина гэдэгт итгэн,
чимээгүй хүлээ. Намайг юу мөхөйлгөж байгааг илчилж
хэлээч. Таныг сонсох сонсголыг минь сайжруулаач.*

— Би хүчирхэг —

БИ ХААНТАЙГАА ХАМТ МАЦАГ
БАРЬДАГ УЧРААС, ХҮЧИРХЭГ.

орлох зорилгогүй учраас, мацгийн талаар санал, асуулт байгаа бол, хувийнхаа эмчтэй юмуу мэргэжлийн эмчтэй зөвлөлдөнө үү. Хэрэв та 18 нас хүрээгүй бол, эцэг эхийнхээ зөвшөөрөлгүйгээр бүү мацаг бариаарай.

ЗҮРХЭЭ ТАХИЛ БОЛГОН ӨРГӨХ

*ЭЗЭН тунхаглаж байна. “Одоо гэлтгүй мацаг,
уйлаан, гашуудал дор Над уруу зүрхээрээ
эргэгтүн! Та нар хувцсаа биш, Харин зүрхээ урж
тасчигтун” Бурхан ЭЗЭНдээ эргэгтүн. Учир нь
Тэрээр нигүүлсэнгүй, өршөөнгүй, Уурлахдаа удаан,
хайр энэрлээр бялхам, Шийтгэхдээ зөөлөрдөг.*

ИОЕЛ 2:12–13

Бурхан бидэнтэй эцэж цуцалгүй хөөцөлддөг. Биднийг хаана ч байсан ч, юу ч хийж байсан, Бурхан бидний араас ертөнцийн мухар хүртэл явна. Бурхан энэ үеийнхэний араас: “Хамаг найдвар тасарсан ч, чи өөртөө хэнд ч хэрэггүй, бузар санагдаж байсан ч, бүх юм хөсөрдсөн ч, зүтгэсэн бүхэн чинь бүтэлгүйтсэн ч... Би тэгэхгүй! Хэзээ ч тэгэхгүй! Бүх зүйл дууссан мэт харагдаж байв ч, дуусаагүй! Хамаг зүрхээрээ Над руу эргэ!” хэмээн хашхирсаар байна. Одоо хэр нь!

Бурхан бидний араас хөөцөлддөг учраас, бид Түүнд итгэхэд л болно. Бурхан биднийг юмны наад цаадахыг эргэцүүлж, үнэн нөхцөл байдлаа бодитоор харж, сайнгүй байгааг нь хүлээн зөвшөөрөөсэй хэмээн хүсэх! Гэхдээ Бурхан цусан улаан тахилыг хүсэхгүй. Учир нь Ханхүү бүгдийг нь хэдийнээ төлсөн. Бурхан биднийг цэвэр болгож угаахыг л хүснэ. Бурхан биднийг хэзээ ч жинхэнээсээ цатгахгүй, энэ дэлхийн “хоосон” хоолтой хөөцөлдөхийн оронд эхлээд хүсэлтэй, удаагаар нь дуулгавартай байвал, газар нутгийн аль шилдгийг нь өгөхийг хүснэ. Дураараа задгай явснаа гэмших хүсэлтэй байвал,

Бурханд баяртайгаар үйлчлэх хүсэлтэй байвал. Учир нь энэ бол хайр, амь, эрх чөлөөний хууль болой. Махан биеэр ирсэн Христийн дотор амьдралаа нууж, загалмайгаа аваад, Түүнийг үлгэрлэн дагах хүсэлтэй байх. Өнөөдөр бид ямар ч зүрхтэй байсан бай, Иоелын үг “Бүх зүрхээрээ Над дээр эргэж ир” хэмээн дуудаж байна. Энэ бүх тулаан тэмцэл нь хэзээд эмэгтэйчүүдийн зүрхний төлөө л өрнөж байгаа бөгөөд Бурхан чиний үйрсэн, няцарсан, шархалсан зүрхийг гуйж байна. Бурхан чамайг дэлхийн хар дарсан зүүднээс Түүний зүүдэнд нэвтрэхийг урьж байна. Учир нь цаг хугацаа эхлэхээс л Бурхан яг чам шиг сүйт охиноо хайсаар буй.

Аав аа, Та намайг ойроос дагадаг учраас, баярлалаа.

Би зөвхөн Тан руу эргэхэд л болох учраас, баярлалаа.

Би Танд зүрхээ өргөж, Тан дээр эргэн ирлээ.

Би хүчирхэг

МИНИЙ АРААС ДАГАДАГ БУРХАН
РУУГАА ЭРГЭХДЭЭ, БИ ХҮЧИРХЭГ.

ЗАГАЛМАЙГАА АВАХ

Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр нь өдөр бүр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ аварна.

ЛУК 9:23–25

Бурхан биднийг өөрийнхөө хүчээр сайн хүн болох гэж оролдож байснаас, зүгээр Түүнийх л байгаасай гэж хүсдэг. Бурхан биднийг шашны хаалт, махан биеийн үйлсээс давж хараад, Түүний сайн чанарт хэзээ ч эргэлзэлгүй, итгэлээр ойртох зүрхтэй байгаасай гэж хүсдэг. Бурхан биднийг Түүний дотроос сүнс ба үнэнээр хүндэтгэж, өдөр бүр загалмайгаа үүрээд, Өөрийг нь дагаасай гэж хүсдэг.

Загалмайгаа үүр гэсэн нь ямар утгатай вэ? Энэ нь хүзүүндээ сондор зүүх шиг амархан зүйл биш. Энэ нь бид Бурханд зориулагдсан амьд өргөл болохыг өдөр бүр гэрчлэх зүрхний тэмдэг юм. Гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, харин төөрөлдөн мөхөж буй дэлхий дээр амьдарч буй бидэнд загалмайн худалдаж авч өгсөн хүч, амлалтыг ч үүрэх үүргийг давхар хамаарна.

Хуучин гэрээнд тахилч нар Эзэний өмнө өдөр бүр тахил өргөдөг байж. “Тэгээд үүдний танхимын урд талд өөрийн босгосон, ЭЗЭНий тахилын ширээн дээр ЭЗЭНд зориулан Соломон шатаалт тахилууд тахив. Үүнийг өдөр тутмын журмын дагуу, Мосегийн тушаал ёсоор... тахидаг байв (2Шастир 8:12-13). Загалмайгаа үүрэх

нь бидний өдөр бүрийн өргөл юм. Үүнийг бид Мосегийн хуулийн дагуу бус, Эзэний Өөрийнх нь заалтын дагуу үйлддэг.

Зарим чинь Есүс тахил болж, энэ ажил гүйцэлдсэн учраас, бид загалмайг үүрэх шаардлагагүй хэмээн маргах байх. Гэхдээ загалмайгаа үүрэхүй нь нүглийн өргөл биш юм. Ер нь бидний эсрэг тэмдэглэгдсэн заалтыг ямар ч тахилаар аргалж дийлэхгүй л болов уу. Есүс л бидний төлөө үхэхдээ, үүнийг гүйцэтгэсэн. Бидний амь Есүс дотор нууцлагдсантай адил, Есүсийн амь Бурхан дотор нууцлагдсан.

Есүс цусаа урсгасан учраас, бид цус урсгах хэрэггүй. Гэхдээ амьд өргөл байх нь Есүс шиг л нүгэлд үхмэл, Бурханд амьд байхуй! Бид өөрийгөө - бие, сэтгэлтэй нь зөвтгөлийн зэмсэг болгон Бурханд өргөө.

Хууль нь бус, өршөөл л биднийг нигүүлслийн дор тавьдаг бөгөөд энэ нигүүлсэнгүй бэлгийн ачаар л бид загалмай дээрх Христийн үлгэр жишээг дагана. Бид өдөр бүр махан бие, ёрын мууд бус, харин Бурханд бөгөөд зөвт байдалд бүрэн захирагдах ёстой. Амьдралаа дуртайяа хойш тавиад, биеэ Бурханд өргөх. Дараа нь итгэлээр загалмайгаа тэврэн, Бурханы зүрх рүү ойртох.

*Есүс ээ, загалмайн үйлсэд тань баярлалаа.
Загалмайгаа аваад, Танд талархалтайгаар,
дуулгавартай амьдрахыг зааж өгөөрэй.*

Би хүчирхэг

БИ ӨДӨР БҮР ЗАГАЛМАЙГАА
АВААД, ӨӨРИЙГӨӨ АМЬД ӨРГӨЛ
БОЛГОН ӨРГӨХДӨӨ, ХҮЧИРХЭГ.

БУРХАНЫ ҮГ

Тиймээс та нар миний энэ үгсийг зүрх, сэтгэлдээ тогтоож, түүнийг тэмдэг болгон бугуйндаа уяж, хоёр нүднийхээ хоорондох сахиус мэт байлга. ... тэмдэг болгон бугуйндаа уяж, хоёр нүднийхээ хоорондох сахиус мэт байлга. Та нар үүнийг гэрийнхээ хатавчин дээр, хаалган дээр ч бич.

ДЭД ХУУЛЬ 11:18, 20–21

Бурхан Израилийн хүүхдүүдэд Үгийг нь гэрийнхээ хаалганы шон дээр бөгөөд зүрхэндээ бич хэмээв. Би л хувьдаа үүнийг нь Бичээсийг цээжилж, тунгаан бодуулахаас гадна бүтээлч байх уриалга хэмээн хүлээж авна! Бурханы хүмүүс ч яг л тэгжээ. Еврей эрчүүд жижиг хайрцаг бүтээгээд, түүндээ бяцхан хуйлмал Бичээс хийгээд, хуулийг дагах санамж болгон, духан дээрээ зүүдэг болсон. Еврей мезуза нь “хаалганы шон” гэсэн утгатай бөгөөд дотроо “Чи Бурхан ЭЗЭНээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла. Сонс, Израиль аа! ЭЗЭН бол бидний Бурхан бөгөөд ганц ЭЗЭН.” (Дэд хууль 6:4-5) гэсэн бичээсийг агуулсан, хаалганы шон дээрээ наадаг, гоёмсог сийлбэр бүхий хайрцаг болно. Юутай сайхан санамж вэ! Бид ч бас тэгвэл яасан юм?

Хөвгүүд маань тунгаан бодож байгаа Бичээсээ толин дээрээ наадаг байж билээ. Нөхөр минь машиндаа ч, бэлтгэлийнхээ зааланд ч аудио Библи сонсдог. Онлайнгаар дүүрэн подкаст, магтаалын хөгжим, сургаал. Бурханы Үгийг өдөр тутмынхаа амьдралд нэвтрүүлэх тун хялбар.

Ач нар маань Библийн эшлэл цээжилдэг. Зарим хүмүүс бие дээрээ шивдэг. Хэрэв та нар Бичээсийг гэр бүлээрээ цээжилж байгаа бол, гэрийнхээ хаа сайгүй наагаад, амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэх

талаараа зөвлөлдбөл сайн. Эсвэл эшлэлээ хувьчлан тунгаахдаа, өдөр тутмынхаа амьдрал, харилцаа, Эзэний доторх өсөлт хөгжилдөө хэрэгжүүлэх санаагаа тэмдэглэж бичвэл сайн.

Иймэрхүү бодит үйлдэл нь бидэнд Бурханы Үгийг хаа ч явсан, ямар ч нөхцөлд, амьдралынхаа харилцаа бүрт байлгаж, хэрэгжүүлэх санамж болно. Бурханы Үг тархинаас чинь зүрхэнд чинь хүртэл бич, постол, цээжил, давт.

*Эзэн минь, Таны Үгийг өдөр тутмынхаа амьдралын
салиггүй хэсэг болгох бүтээлч арга замыг зааж өгөөч.*

— Би хүчирхэг —

БИ БУРХАНЫ ҮГИЙГ ЦАГ ҮРГЭЛЖ
НҮДНИЙХЭЭ ӨМНӨ, ТАРХИНДАА
БАЙЛГАХДАА, ХҮЧИРХЭГ.

ТЭСВЭР СУУХ

*Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг
бүрэн баяр хөөр гэж үз. Итгэлийн чинь шалгуур
хатуужилд хүргэдгийг та нар мэдэх билээ.*

ИАКОВ 1:2–3

Айн? Бэрх цагт баярлах гэж үү? Хүчний хариу үйлдэл нь манай соёлын хариу үйлдлээс өөр байгааг дахин харж байна уу? Тэгээд ч зовж байгаа хүн чинь “цэвэр баяр хөөр” гэж хандах нь байтугай, инээвхийлэх ч хэцүү биш үү? Гэтэл Есүсийн дүү Иаков ингэхийг л уриалжээ. Амар цагт бус, бэрх цагт л хүнд тэсвэр суудгийг харж байна уу? Зарим нэг ижил утгатай үгсээс дурьдбал: зорилго, жолоо, зориулалт, шийдэл, барьц, шийдэмгий байдал. Хүч чадлыг минь найрагч дэлхий дээр хүчтэйхэн зогсох гэж байгаа л бол, бидэнд энэ бүхэн хэрэгтэй. Тэсвэр гэдэг чанарыг өөрөөр бас “тэнгэрийн нигүүлсэл” гэнэ.

“Харин тачаалдаа автаж, татагдахдаа хүн бүр уруу татагддаг.” (Иаков 1:4). Бүрэн гүйцэхүй, төлөвшихүйн энэ амлалтын гэрлээр тусгаж харбал, Иаков юуны учир цэвэр баяр хөөр нь тохирох хариу үйлдэл гэх болсныг чи ойлгоно. Сорилын бэрх цагт л бид найдвараа юун дээр тавьснаа, хүчээ юунаас татдагаа олж мэднэ. Амьдралынхаа хуурай улиралд л бид худгийнхаа гүнийг олж мэднэ. Элбэг дэлбэгийн улирал нь бидний үнэн мөнхийг илчлэхгүй. Сорил, бэрх цаг нь олон талаараа бидэнд сүнсний хүчний дасгал болдог.

Анхны элч нарын амьдрал ямаршуу байсныг Паул ийн өгүүлэв:

“Намайг саваагаар гурвантаа жанчиж, нэг удаа над уруу чулуу шидэцгээж байв. Гурван удаа би усан онгоцны

сүйрэлд өртөж, гүн тэнгист өдөр шөнийг өнгөрөөж байлаа. Ахин дахин аялахдаа, гол усны аюул, дээрэмчдийн аюул, овог нэгтний аюул, харийнхны аюул, хот дахь аюул, цөл дэх аюул, тэнгис дэх аюул, хуурамч ах дүүсийн дундах аюул...” (2Коринт 11:25-26).

Энэ жагсаалт нь Паулын амьдралд тулгарч байсан зовлонгийн хоёрхон эшлэл билээ. Уншихаар, бидний харьцуулах жишээ дэндүү жул. Өнөө бидэнд тулгардаг бэрхшээлийг нэг иймэрхүү янзаар л тоймлох болов уу: олон нийтийн сүлжээн дээр дагахаа больсон, найз нөхдийнхөө хүрээллээсээ хассан, хийсэн үйлсийг минь тоогоогүй, намайг биеийн үзэмж, жингээр минь гоочилсон. Анхан үеийн чуулганд тулгарсан юмсыг уншаад, нэгийг тунгааж, хүчээ ахиулах цаг аргагүй болжээ.


*Тэнгэрийн Бурхан Аав аа, би зовлонд баярласандаа
бус, харин үүгээр дамжуулж надад бий болгох тэсвэр
тэвчээрт баярлаж, үүнийг цэвэр баяр хөөр гэж үзье.*

Би хүчирхэг

СОРИЛ НЬ МИНИЙ ДОТОР ИХИЙГ
ГҮЙЦЭЛДҮҮЛЖ БАЙГААГ МЭДЭЖ
БАЙГААДАА, БИ ХҮЧИРХЭГ.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Эргэлзээ, харьцуулалтын энэ эрин цагт
өөрийгөө болон зорилгоо олж мэдэх



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарахгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

Татаж аваарай:



MessengerX.com

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охидууд бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрсөнийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

Татаж аваарай:



MessengerX.com

АДАМАНТ

Олон санаат ертөнцөд үнэнийг олох



Үнэн, хайрын тал дээр хад чулуу мэт хөдлөшгүй байх ёстой цаг гэж байдаг бол тэр цаг иржээ. Бурхан бол хайр. Бурхан бол үнэн. Хайр ч, үнэн ч цаг хугацаагүй бөгөөд үе үеийн чиг хандлага, санаа бодлыг давдаг. Заримдаа үнэнийг ярих нь бидний хийж чадах жинхэнэ хайрын үйлс болдог. Гэхдээ үнэнийг ярих нь үнэнээр амьдрахаас эхлэнэ.

Шилдэг борлуулалтай номын зохиолч Лиза Бивэр Бичээс, түүхийг хослуулан байж, таныг Бурханы ганхашгүй үнэн, хайр дотор амьдруулахаар барахгүй, харин “адамант” буюу хөдлөшгүй, шийдэмгий, ганхашгүй хүмүүс болгох газрыг зорих аян замд гаргана.

Бурханы дотор амьдрах үед Түүний төлөвлөгөө илчлэгддэг. Тэнд л бид хэлбэршин бүрэлддэг. Бид Булангийн чулуу болох Христ дотор амьдрахдаа, адамантын буюу хөдлөшгүй нэгний дүрд хувирдаг

УЙЛУУЛАХ УЧИРГҮЙ ҮНСЭЛТ

Эмэгтэй хүн буулт хийхдээ ялагддаг



Нүгэл, ичгүүр хоёр нь биднийг Бурханы хайрыг харах нүдгүй болгож, эрх чөлөөнөөс хорьдог ахан дүүс, ихрүүд юм. Үнэн л биднийг эрх чөлөөтэй болгоно. “Иймээс Хүү та нарыг чөлөөлвөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно” гэж Есүс амласан (Иохан 8:36). Эмэгтэйчүүд өөрсдийх нь нэр төрийг хаяад, ял дор булшлахыг санаархагч дайсныхаа саварт тарчилж байна.

“Уйлуулах учиргүй үнсэлт” ном нь хайртай охин чамдаа зориулсан Бурханы зүрхний үгс юм. Бурхан чамд дотносол, хайр, дур хүслийг эдлүүлэхээр чамайг бүтээсэн. Чи хэн нэгний бэлгийн гарч юмуу дур хүслийг тайлагч байхаар бүтээгдээгүй. Бурханы Үгийн хүч нь чиний цагаас нь өмнө сэрээсэн зүйлсийг чинь тайвшруулан, буцааж нойрсуулахаар айлчилж байна. Бурхан миний нэр төр, хүч чадал, эрх хүчийг сэргээсэн шигээ чинийхийг ч сэргээнэ.

ЭРСЛЭН СЭРЭВ

Сэрээд, ертөнцөө өөрчил



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгачихсан мэт ялгарашгүй байлгахгаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаашд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!


Татаж аваарай:




MessengerX.com

X MessengerX

Газар газры хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 125 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой
- Апп хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу:

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой

ХҮЧИРХЭГ БАЙХ БУРУУ БИШ! Бурхан угаасаа чамайг бүх талаараа хүчирхэг байхаар бүтээсэн. Гэхдээ, буруу зүйл хүчтэй байдаггүй. Өнөөдөр бид Бурханы дуудсаны дагуу хүчирхэг бүсгүйчүүд байхаас гадна зөвийн төлөөх найраагүй мөрдлөгө болох Бурханы Үг дотор хүчирхэг байх ёстой.

Хүч нь дуудлага ч, тушаал ч мөн боловч, хүчээ хаанаас олох нь хүчээ үзүүлэн болгохоос дутуугүй чухал. Манай соёлд хүн дотроосоо хүчийг олдог хэмээн сургадаг ч, үнэндээ Бурхан л бидний өөртөө итгэх итгэл, хүчний Эх болой.

Нью Йорк Таймсын бестселлер зохиолч Лиза Бивэр номоороо дамжуулан хүчирхэг чанарын жинхэнэ утгыг алдагдуулсан өнөөгийн энэ дэлхийд үүний жинхэнэ утгыг шинээр таниулжээ. Тэрбээр хэрхэн хүчирхэг атлаа зөөлөн байх, харилцааны эдгэрэл, сэтгэл хангалуун байх, харууслаасаа эдгэрэх, амрахуйн хүч зэрэг олон сэдвийг хөндөхдөө, чамайг хүчтэй байж, итгэлээр гүн өсч, Бурхантай ч, бусадтай ч, өөртэйгээ ч эвтэй амьдрахад зоригжуулжээ.

Лиза Бивэр - галтай, жинхэнэ, хөгжилтэй арга барилаараа Библийн үнэнийг бодит хэрэгжилттэй нь хавсаргаж заадаг зохиолч. “Fight Like A Girl”, “Эрслэн сэрэв”, “Сэлэмтэй охид” зэрэг ном нь дэлхийн 65 орчим хэлээр хөрвүүлэгдэн, бөмбөрцгийн сая сая хүний гарт очоод байна. Лиза нөхөр Жонныхоо хамт Мессенжер Интернэйшнэл байгууллагыг үүсгэн байгуулсан бөгөөд хоёул бестселлер зохиолч болно.



Дэлгэрэнгүйг **MessengerX.com**



Энэхүү ном нь зохиолчийн бэлэг бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

